ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1995 оны 8-9 сар № 8-9 /39-40/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай 889
2. Нөхөрлөл компанийн тухай 890
3. Хоршооны тухай 934
4. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай 936
5. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай 939
6. Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай 943
7. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан, агнах, баарих зөвшөөрлийн хураамжийн тухай 949
8. Конвенцид нэгдэн орох тухай 955
9. Хэлэлцээр соёрхон батлах тухай 955
10. Таатварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай 956
11. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай 956
12. Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 958
13. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 960
14. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 960

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

15. Төслийг буцаах тухай №29 968
16. Байгаль орчны тухай багц хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №31 968
17. 5000-тын дэвсгэрт болон 20, 50, 100, 200 төгрөгийн зоосон мөнгөн тэмдэгтийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцож, гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай №33 969
18. Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай №34 970
19. Дүрэм батлах тухай №35 971
20. "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ыг батлах тухай №36 974
21. Боловсролын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №37 985
22. Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргыг томилох тухай №38 987
23. Зарим хүмүүсийг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилох тухай №39 988
24. Цалингийн санг батлах тухай №40 988

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

25. Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай №71 989
26. Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай № 72 989
27. Б. Должинцэрэнг элчин сайдаар томилох тухай №73 990
28. Чимиддоржийн Цэрэндоржийг Сүхбаатарын одонгоор шагнах тухай №74 990
29. Намсрайн Ёндонд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгох тухай №75 991
30. Жанчивын Баатарсүрэнг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай №76 991

31. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай №84 99
32. ОХУ-ын иргэн, зарим ахмад дайчдыг Цэргийн гавъяаны одонгоор шагнах тухай №85 99
33. ОХУ-ын иргэн зарим ахмад дайчдыг медалиар шагнах тухай №86 99
34. Украйн улсын иргэн зарим ахмад дайчдыг "Найрамдал" медалиар шагнах тухай №87 99

IY. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

35. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай №04 99

Y. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

36. Хөтөлбөр батлах тухай №46 10
37. Дүрэм батлах тухай №47 101
38. Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай №51 103
39. Төр, захиргааны байгууллага болон терийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын архивын ажлын үндсэн заавар батлах тухай №52 104

YI. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

40. Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 107

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дараахь зарлигийг хүчингүй болсонд тооцсугай:

1/ "Зарим газар нутгийг дархан цаазтай болгох тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар зарлиг;

2/ "Дархан цаазтай газрын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 189 дүгээр зарлиг;

3/ "Дархан цаазтай газрын жагсаалтанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1974 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 248 дугаар зарлиг;

4/ "Говийн их дархан газрыг тогтоох тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 84 дүгээр зарлиг;

5/ "Дархан цаазтай Богд уулын хилийн цэс батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 78 дугаар зарлиг;

6/ "Дархан цаазтай зарим газрын хилийн цэсийг батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 111 дүгээр зарлиг.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙН ТУХАЙ

I ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь нөхөрлөл, компанийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл, тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "үүсгэн байгуулах гэрээ" гэж хэд хэдэн этгээд ашиг олох зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн энэ хуульд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар хэлэлцэн тохирч бичгээр байгуулсан хэлцлийг хэлнэ:

2/ "үүсгэн байгуулах баримт бичиг" гэж эрх бүхий байгууллагын шийдвэр, нөхөрлөл, компанийн гэрээ /төсөл/, дүрмийг хэлнэ;

3/ "гишүүн" гэж нөхөрлөл, компанид хөрөнгө оруулсан этгээдийг хэлнэ. Хувь хүн, нөхөрлөл, компани, төрийн эрх бүхий байгууллага гишүүн байж болно.

3 дугаар зүйл. Нөхөрлөл, компанийн хэлбэр

1. Нөхөрлөл дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно:

1/ бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай;

2/ зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай.

2. Компани дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно:

1/ хувьцаат;

2/ хязгаарлагдмал хариуцлагатай.

4 дүгээр зүйл. Гадаад худалдааны эрх

Нөхөрлөл, компани эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцох эрхтэй.

5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авах

1. Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхөрлөл, компани хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

2. Нөхөрлөл, компани татан буугдах үед эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл хүчингүй болох бөгөөд бүртгэх байгууллага энэ тухай тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэнэ.

6 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар

Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Энэ тухайгаа компани хуульд заасан журмын дагуу бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

7 дугаар зүйл. Нөхөрлөл, компани нэгдэх

Нөхөрлөл, компани үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллагад төлөөлөх зорилгоор салбар, нутаг дэвсгэрийн болон бусад чиглэлээр Иргэний хуульд зааснаар нэгдэж болно.

8 дугаар зүйл. Нөхөрлөл, компанийн нэр

1. Нөхөрлөл, компани оноосон нэртэй байна. Оноосон нэр товч бөгөөд төрийн албан бичгээр илэрхийлэгдсэн, бусад нөхөрлөл, компанийн оноосон нэртэй давхардаагүй байна.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжүүдийг энэ хуульд зааснаас өөрөөр нэрлэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийг бүртгэх

1. Нөхөрлөл, компанийг оршин байгаа газрынх нь нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллага, тэдгээрийн өргөдлийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ.

2. Гадаад улсад байгуулагдсан бөгөөд энэ хуульд заасан нөхөрлөл, компанитай адил төрлийн хуулийн этгээд, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бол энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

3. Нөхөрлөл, компанийг бүртгэгдсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

10 дугаар зүйл. Бүртгүүлэх тухай өргөдлийн агуулга

1. Өргөдөлд энэ хуулийн 32 дугаар зүйл, 88 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бүрдсэн эсэхийг заана.

2. Өргөдөлд дор дурдсан зүйлийг хавсаргана:

1/ үүсгэн байгуулах гэрээ /цаашид "гэрээ" гэх/;

2/ хуульд заасан бол дүрэм;

3/ энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл;

4/ гишүүдээс тухайн нөхөрлөл, компанид оруулсан хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан баталгаа.

11 дүгээр зүйл. Бүртгэх байгууллагын бүрэн эрх

1. Бүртгэх байгууллага өргөдлийг хүлээн авч хянаад энэ хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл нөхөрлөлийг ажлын 7, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг 14, хувьцаат компанийг 30 хоногийн дотор тус тус улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

2. Бүртгэх байгууллага бүртгэлтэй холбогдсон асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нөхөрлөл, компани хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдаж байгаа эсэхийг хянах;

2/ бүртгэгдсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, эсхүл түүнтэй холбогдсон бэлтгэл ажлаа эхлээгүй, үйл ажиллагаагаа эхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд тасалдсан тохиолдолд нөхөрлөл, компанийг улсын бүртгэлээс хасах;

3/ дор дурдсан үндэслэлээр бүртгэхээс татгалзах:

а/ энэ хуульд заасан журмын дагуу гэрээ, дүрмээ батлаагүй;

б/ үйл ажиллагааны зорилго нь хуульд нийцээгүй;

в/ үүсгэн байгуулагч нь эрх зүйн чадамжгүй;

г/ оноосон нэр давхардсан.

4/ нөхөрлөл, компанийн талаар нийтэд мэдээлэхээр энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх.

3. Бүртгэх байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан үндэслэлээр бүртгэлээс хассан, эсхүл мөн хэсгийн 3-т заасан үндэслэлээр бүртгэхээс татгалзсан бол энэ талаар тухайн нөхөрлөл, компанид 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Шийдвэрийг зөвшөөрөөгүй нөхөрлөл, компани шүүхэд гомдол гаргаж болно.

4. Нөхөрлөл, компанийг бүртгэхэд энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

5. Бүртгэх байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг шүүхэд гаргана.

12 дугаар зүйл. Оршин байгаа газар, түүнийг өөрчлөх

1. Нөхөрлөл, компанийн оршин байгаа газрыг тэдгээрийн удирдлагын төвийн оршин байгаа газраар тодорхойлно.

2. Нөхөрлөл, компани оршин байгаа газраа өөрчлөхөөр бол энэ тухайгаа харьяаллынхаа бүртгэх байгууллагад 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3. Бүртгэх байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шилжилт хийсэн тухай улсын бүртгэлд тэмдэглэл хийж, шинээр орших газрын харьяаллын бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд тухайн нөхөрлөл, компанитай холбогдолтой бүх баримт бичгийг хавсаргана.

4. Шинээр орших газрын харьяаллын бүртгэх байгууллага шилжилтийг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу хийгдсэн гэж үзвэл тухайн нөхөрлөл, компанийг улсын бүртгэлд авна.

13 дугаар зүйл. Нөхөрлөл, компани зохион байгуулалтын төрөл, хэлбэрээ өөрчлөх

Нөхөрлөл, компани хуульд заасан төрөл, хэлбэрээр энэ хуульд заасан журмын дагуу өөрчлөгдөн зохион байгуулагдаж болно.

14 дүгээр зүйл. Татан буугдах

1. Нөхөрлөл, компани нь дор дурдсан үндэслэлээр гишүүдийн хурлын шийдвэрээр татан буугдана:

1/ гэрээ, дүрэмд заасан хугацаа дууссан;

2/ саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшиж байгаа гишүүд санал гаргасан;

3/ тусгай зөвшөөрөл, шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээг дагнан эрхэлдэг нөхөрлөл, компанид олгогдсон тусгай зөвшөөрөл хүчингүй болсон;

4/ зохион байгуулалтын төрөл, хэлбэрээ өөрчилсөн;

5/ нөхөрлөлийн онцлогтой холбогдон энэ хуульд заасан бусад үндэслэл;

6/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар улсын бүртгэлээс хассан;

7/ гэрээ, дүрэмд заасан бусад үндэслэл.

2. Шүүх нөхөрлөл, компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

1/ дампуурсан;

2/ нэг ч гишүүн үлдээгүй;

3/ энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 6-д заасан үндэслэлээр татан буугдах шийдвэр гаргаагүй, эсхүл шийдвэр гаргасан боловч үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн эрхэлж байгаа;

4/ хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

5/ хуульд заасан бусад үндэслэл.

15 дугаар зүйл. Татан буулгах комисс

1. Татан буулгах тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон татан буулгах комисс татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

2. Татан буулгах комисс томилсноор тухайн нөхөрлөл, компанийн удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

16 дугаар зүйл. Татан буулгах комиссын үүрэг, хариуцлага

1. Татан буулгах комисс дараахь үүрэг гүйцэтгэнэ:

1/ нөхөрлөл, компанийг татан буулгах тухай шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор нийтэд мэдээлэх;

2/ дуусгалтын баланс, тайлан гаргаж, гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

3/ өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулах;

4/ үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу гишүүдэд хуваах;

5/ татан буулгах ажиллагаа дууссаныг бүртгэх байгууллагад мэдэгдэх.

2. Тухайн нөхөрлөл, компанийг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно. Энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

3. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн нөхөрлөл, компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

4. Татан буулгах комисс, тухайн нөхөрлөл, компани, гишүүдийн хооронд үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл. Харилцагчдын үүрэг

1. Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа нөхөрлөл, компанитай харилцагчид татан буугдах гэж байгааг нийтэд мэдээлснээс хойш 3 сарын дотор төлбөр тооцоогоо хийх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд харилцагч тал төлбөр, тооцоогоо хийгээгүй бол нэхэмжлэл хангуулах эрхээ алдана.

18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Нөхөрлөл, компанийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бүртгэх байгууллага зөрчлийн шинж байдлыг харгалзан дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ нөхөрлөл, компанийг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол олсон орлогыг хурааж гэм буруутай этгээдийг 40000-50000 төгрөгөөр торгох;

2/ дүрэм болон дүрмийн санд орсон өөрчлөлтийг бүртгэх байгууллагад хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй бол гэм буруутай албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр торгох;

3/ гэрээ, дүрэмд зааснаас өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол олсон орлогыг хурааж нөхөрлөл, компанийг 200000-250000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн бол буруутай албан тушаалтныг 10000-25000 төгрөгөөр торгох.

II хэсэг

НӨХӨРЛӨЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

19 дүгээр зүйл. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

1. Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран

хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

2. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нэрийн ард "ББ" гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

20 дугаар зүйл. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл байгуулах, бүртгүүлэх

1. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /цаашид нөхөрлөл гэх/-ийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрээний үндсэн дээр байгуулна.

2. Гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1/ нөхөрлөлийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг ;

2/ эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, үйл ажиллагаа явуулах хугацаа;

3/ удирдах төлөөлөх эрх бүхий этгээдийн овог нэр, хаяг, регистрийн дугаар;

4/ гишүүн тус бүрийн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээ, үнэлгээ, үнэлэх аргачлал, буцаан олгох нөхцөл;

5/ хэрвээ ажиллах чадвараа нэгтгэж байгаа бол түүний үнэлгээ, үнэлэх аргачлал, үзүүлэх үйлчилгээ, хугацаа;

6/ ашиг, алдагдал хуваах зарчим;

7/ гэрээ байгуулсан он, сар, өдөр;

8/ гишүүдийн овог, нэр иргэний харьяалал, хаяг, гарын үсэг;

9/ шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

3. Гишүүд гэрээ баталснаас хойш 7 хоногийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлэх тухай өргөдөл гаргана. Гэрээ нотариатаар гэрчлэгдсэн байна.

21 дүгээр зүйл. Нөхөрлөлийн удирдлага, хяналт

1. Гишүүн бүр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй.

2. Гэрээнд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхийг нэг буюу хэд хэдэн гишүүнд олгохоор зааж болно.

3. Удирдах эрх бүхий гишүүд олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна.

4. Нөхөрлөлийг удирдах эрх бүхий гишүүд нөхөрлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, энгийн бүртгэл хөтөлнө.

5. Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина.

6. Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүнийг удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж үзвэл гишүүд түүнийг уг үүргээс чөлөөлж болно.

7. Нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүн нөхөрлөлийн үйл ажиллагааны талаар бусад гишүүдэд байнга мэдээлнэ.

22 дугаар зүйл. Нөхөрлөл, гишүүдийн хооронд харилцаа

1. Гишүүд үйл ажиллагаа явуулахад шаардагдах мөнгө, эд хөрөнгө, ажиллах чадвараа үнэлж нэгтгэн нөхөрлөлд оруулна.

2. Гишүүн нь нөхөрлөлийн үйл ажиллагаанд заавал биечлэн оролцоно.

3. Нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөл, компанийн гишүүн байхыг хориглоно.

4. Гишүүдээс нөхөрлөлд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг үндэслэн гишүүн тус бүрийн саналын эрхийн тоог гэрээнд тусгана.

5. Гишүүд дор дурдсан асуудлыг заавал санал нэгтэй шийдвэрлэнэ:

1/ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

2/ үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг өөрчлөх. Гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг гишүүдийн саналын эрхийн дийлэнх олонхиор шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Нөхөрлөлд орох, нөхөрлөлөөс гарах, хасагдах

1. Нөхөрлөлд шинээр гишүүнээр орж болох бөгөөд нөхөрлөлийн хүлээсэн үүргийг бусад гишүүдийн нэг адил хариуцна.

2. Нөхөрлөлөөс дор дурдсан үндэслэлээр гарна:

1/ гэрээнд заасан хугацаа дууссан;

2/ гэрээнд заасан бусад нөхцөл.

3. Нөхөрлөлөөс дор дурдсан үндэслэлээр хасагдана:

1/ гэрээгээр хүлээсэн үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлэх чадваргүй, эсхүл хөрөнгөө оруулах боломжгүй нь тогтоогдсон;

2/ гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн.

4. Нөхөрлөлөөс хасагдах үндэслэлийг тухайн гишүүнд урьдчилан мэдэгдэнэ. Хасах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд уг гишүүн санал өгөх эрхгүй.

5. Хасагдсан гишүүн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

6. Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөлөөс гарсан буюу хасагдсан гишүүний нөхөрлөлд оруулсан хөрөнгийг гарсан өдрөөс нь хойш 3 сарын дотор буцаан олгоно.

24 дүгээр зүйл. Ашиг, алдагдал хуваах зарчим

Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөл жил бүр ашиг, алдагдлаа тодорхойлно. Гишүүдэд ногдох ашиг, алдагдал нь тэдгээрээс нөхөрлөлд оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүү байна. Энэ зүйл компанид нэг адил хамаарна.

25 дугаар зүйл. Эд хөрөнгө хуваах

1. Нөхөрлөл татан буугдсаны дараа гишүүд нөхөрлөлд оруулсан хөрөнгөө буцаан авах эрхтэй. Гэхдээ харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл нөхөрлөлийн хөрөнгийг гишүүдэд хуваарж болохгүй.

2. Нөхөрлөлийн төлбөрийг бүрэн барагдуулсны дараа гишүүдийн оруулсан хөрөнгийг буцаан олгож, үлдэх эд хөрөнгийг гишүүдэд оруулсан хөрөнгөтэй нь хувь тэнцүү хуваана. Эд хөрөнгийн хэлбэрээр оруулсан хөрөнгийг биет байдлаар нь буцаан олгох боломжгүй бол гэрээнд заасан үнэлгээ, нөхцөлийг баримтална.

3. Нөхөрлөлийн эд хөрөнгө төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол гэрээнд гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байхаар зааснаас бусад нөхцөлд гишүүдээс оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүү хэмжээгээр тэдгээрийн хувийн өмчийн эд хөрөнгөөс гаргуулж, харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулна.

26 дугаар зүйл. Татан буугдах өнцлог

Аль нэг гишүүн нөхөрлөлөөс гарсан, хасагдсан, хөрөнгийн чадваргүй болсон буюу нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон гишүүний өв залгамжлагч тухайн нөхөрлөлд ороогүй тохиолдолд нөхөрлөл татан буугдана. Гэхдээ тухайн нөхөрлөл цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахаар бол гэрээгээ шинэчилж бүртгэх байгууллагад дахин бүртгүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

27 дугаар зүйл. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

1. Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

2. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нэрийн ард "ЗБ" гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

28 дугаар зүйл. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн онцлог

1. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл байгуулах гэрээнд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна гишүүн тус бүрийн хариуцлагыг ялгаж заана.

2. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн гагцхүү бүрэн хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй.

3. Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт бүрэн хариуцлагатай гишүүдэд нэг адил хамаарна.

4. Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийн үйл ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болно.

5. Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох нь тухайн нөхөрлөлийг татан буулгах үндэслэл болохгүй. Харин тэдгээр нь бүгд гарвал нөхөрлөл татан буугдана.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд үлдсэн гишүүдийн шийдвэрээр уг нөхөрлөл бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж болно. Энэ тохиолдолд гэрээгээ шинэчлэн, бүртгэх байгууллагад дахин бүртгүүлнэ.

7. Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийг татан буулгах үед оруулсан хөрөнгөө тэргүүн ээлжинд буцаан авах давуу эрхтэй байна.

8. Энэ зүйлийн 1-7 дахь хэсэгт заасан онцлогоос бусад харилцаа энэ хуулийн 2 дугаар бүлгийн холбогдох зүйл, заалтын дагуу зохицуулагдана.

III ХЭСЭГ

КОМПАНИ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хувьцаат компани

29 дүгээр зүйл. Хувьцаат компани

1. Дүрмийн сан нь нэг бүрийн нэрлэсэн үнэ бүхий тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, хүлээсэн үүргээ өөрийн эд хөрөнгөөр

хариуцдаг, гишүүн нь гагцхүү эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг хуулийн этгээдийг хувьцаат компани гэнэ.

2. Хувьцаат компанийн оноосон нэрийн ард "ХК" гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

30 дугаар зүйл. Хувьцаат компани байгуулах

1. Компанийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүсгэн байгуулагчдын боловсруулсан төслийг нийтэд /нээлттэй/ санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл хязгаарлагдмал хүрээнд /хаалттай/ цөөн тооны этгээдээс захиалга авах аргаар байгуулж болно.

2. Хувьцааны захиалга авах аргаар байгуулж байгаа компанийн төсөлд дор дурдсан зүйлийг тусгана:

1/ эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл;

2/ шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа;

3/ дүрмийн сангийн төлөвлөсөн хэмжээ;

4/ гаргах хувьцааны нэрлэсэн үнэ, тоо, нийт үнэ;

5/ төлөвлөсөн ашгийн хэмжээ;

6/ үүсгэн байгуулагчдад давуу эрх олгох эсэх;

7/ захиалга эхлэх, дуусах хугацаа.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төслийг боловсруулж гарын үсэг зурсан этгээдийг үүсгэн байгуулагч гэнэ.

31 дүгээр зүйл. Хувьцааны захиалга авах, урьдчилсан төлбөр хийх

1. Хувьцааны захиалга авахтай холбогдон үүсэх харилцааг үнэт цаасны хорооноос гаргасан журмын дагуу зохицуулна.

2. Эрх бүхий байгууллагаас баталсан захиалгын хуудсаар хувьцааны захиалга авна.

3. Захиалгын хуудсанд захиалагчийн овог нэр, захиалга хүлээн авсан байгууллагын нэр, захиалсан хувьцааны нэрлэсэн үнэ, тоо, нийт үнэ, захиалга хийсэн он, сар, өдрийг бичнэ.

4. Захиалагч өөрөө буюу түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд захиалгын хуудсанд гарын үсэг зурсан бол захиалга хийгдсэн гэж үзнэ.

5. Төсөлд заасан хугацаанд хувьцааны захиалга бүрэн хийгдээгүй бол захиалга авах хугацааг үүсгэн байгуулагчид зөвхөн нэг удаа 30 хоногоор сунгах шийдвэр гаргаж болно.

6. Захиалагч нь захиалсан хувьцааныхаа үнийн дүнгийн 30-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний урьдчилсан төлбөрийг захиалга авах хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хийнэ.

7. Тогтоосон хугацаанд төлбөр хийгээгүй бол төлбөр хийх хугацааг зөвхөн нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

32 дугаар зүйл. Компани байгуулагдах нөхцөл

Компани байгуулахад дор дурдсан нөхцөл бүрдсэн байна:

1/ хувьцааны захиалга дүрмийн сангийн төлөвлөсөн хэмжээгээр бүрэн хийгдсэн;

2/ хувьцааны урьдчилсан төлбөр 31 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хэмжээгээр бүрэн хийгдсэн;

3/ шаардлагатай бол энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авсан.

33 дугаар зүйл. Зохион байгуулах хурал

1. Энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан нөхцөл бүрдсэн гэж үзвэл үүсгэн байгуулагчид зохион байгуулах хурлыг зарлан хуралдуулна.

2. Хурлын даргыг үүсгэн байгуулагчид дотроосоо сонгоно.

3. Зохион байгуулах хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

1/ компани байгуулах тухай шийдвэр гаргаж, дүрмийн сангийн хэмжээг батлах;

2/ компанийн дүрэм батлах;

3/ энэ хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдгээрийн хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

4/ хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийг эрх бүхий байгууллагаас нийтэд зарласан мэргэшсэн нягтлан бодогчдын нэрсийн жагсаалтаас сонгож, батлах, хөлс урамшууллын хэмжээг тогтоох;

5/ үүсгэн байгуулагчдад давуу эрх олгох эсэх;

6/ үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг үүсгэн байгуулагчдад нөхөн олгох.

4. Захиалагчдын дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

5. Зохион байгуулах хуралд захиалагч бүр саналын нэг эрхтэй байна.

6. Хэрэв төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол уг шийдвэрийг захиалагчид санал нэгтэй зөвшөөрсөн тохиолдолд хурлаар хэлэлцэнэ.

34 дүгээр зүйл. Компанийн дүрэм

1. Компанийн дүрэмд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1/ компанийн оноосон нэр, оршин байгаа газар, хаяг;

2/ эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл;

3/ шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа;

4/ дүрмийн сангийн хэмжээ;

5/ хувьцаа, түүний төрөл, төрөл тус бүрийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ, тоо, нийт үнэ;

6/ удирдлага, хяналтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ;

7/ дүрэмд тусгахаар энэ хуульд заасан болон бусад зүйл.

2. Зохион байгуулах хурал хийж дүрэм баталснаас хойш 14 хоногийн дотор үүсгэн байгуулагчид бүртгэх байгууллагад бүртгүүлэх тухай өргөдөл гаргана. Дүрэм нотариатаар гэрчлэгдсэн байна.

35 дугаар зүйл. Үүсгэн байгуулагчдын үүрэг, хариуцлага

1. Үүсгэн байгуулагчид дараахь үүрэг хүлээнэ:

1/ хувьцааны захиалга, хувьцааны урьдчилсан төлбөрийг энэ хуульд заасан хэмжээгээр хийлгэх;

2/ компанийн дүрэм боловсруулах;

3/ үүсгэн байгуулахтай холбогдсон мэдээллийн үнэн зөвийг хариуцах.

2. Хэрэв ямар нэг шалтгаанаар компани байгуулагдаагүй бол захиалагчийн урьдчилан хийсэн төлбөр, үүссэн хохирлыг энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор нөхөн төлнө.

3. Зохион байгуулах хурлаас компани байгуулах тухай шийдвэр гарч, тухайн компанийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулагчид үүсгэн байгуулахтай холбоотой үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөнө.

36 дугаар зүйл. Үүсгэн байгуулагчдад олгох давуу эрх

1. Компанийн гишүүн болсон эсэхээс үл хамааран үүсгэн байгуулагчдад ашгийн зохих хэсгийг тодорхой хугацаанд олгож байхаар дүрэмд зааж болно.

2. Үүсгэн байгуулагчдад энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр давуу эрх олгохыг хориглоно.

37 дугаар зүйл. Дүрмийн сангийн хэмжээ, дүрмийн сан бүрдүүлэх

1. Дүрмийн сангийн хэмжээ 30 сая төгрөгөөс доошгүй байна.

2. Компанийн анхны дүрмийн сан захиалагдсан хувьцааны төлбөрөөс бүрдэнэ.

3. Хувьцааны төлбөрийг бэлэн мөнгө, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлж оруулах хэлбэрээр хийж болно.

4. Хувьцааны төлбөрийг эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлж оруулах хэлбэрээр хийхээр бол энэ хуулийн 38 дугаар зүйлд заасныг үндэс болгоно.

5. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилийн дотор дүрмийн санг нь бүрэн бүрдүүлсэн байна.

6. Энэ зүйлийн 4, 5 дахь хэсэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн сан бүрдүүлэхэд нэг адил хамаарна.

38 дугаар зүйл. Дүрмийн санд эд хөрөнгө, оюуны өмчийг үнэлж оруулах

1. Хувьцааны төлбөрийг эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийх тохиолдолд гишүүний оруулж байгаа зүйлийн үнэлгээ үнэн зөв, үнийн дүн нь түүнд ногдох хувьцааны нийт үнэтэй тохирч байгаа эсэхийг тодорхойлсон эрх бүхий шинжээчийн дүгнэлт гаргуулна. Дүгнэлтийг компанийн дүрэмд хавсаргана.

2. Төлөөлөн удирдах зөвлөл болон хянан шалгагчид компани байгуулагдсанаас хойш 6 сарын дотор шинжээчийн дүгнэлтэд тодорхойлсон үнэлгээг хянаж, шаардлагатай гэж үзвэл дахин шалгаж болно. Үнэлгээг дахин шалгаж тогтоох хүртэлх хугацаанд түүнд ногдох хувьцааг тухайн гишүүнд шилжүүлэхгүйгээр компанийн мэдэлд хадгална.

3. Эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр оруулж байгаа зүйлийн үнэлгээ түүнд ногдох хувьцааны үнийн дүнтэй тохирохгүй байвал зөрүүг талууд мөнгөөр нөхөн төлнө.

39 дүгээр зүйл. Хувьцааны төлбөрийг тогтоосон хугацаанд хийгээгүйгээс үүсэх үр дагавар

1. Гишүүн тогтоосон хугацаанд төлбөр хийх үүрэгтэй.

2. Тогтоосон хугацаанд төлбөр хийгээгүй гишүүний төлбөр хийх хугацааг төлөөлөн удирдах зөвлөл зөвхөн нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

3. Гишүүн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд уг төлбөрийг хийгээгүй бол тухайн этгээдийг гишүүнээс хасч, хувьцааг нь нийтэд худалдахаар санал болгоно. Уг хувьцаа нийтэд худалдагдсан бол тухайн гишүүний урьдчилан хийсэн төлбөрийг түүнд буцаан олгоно. Хэрэв уг хувьцаа худалдагдахгүй бол хэсэгчлэн хийсэн хувьцааны төлбөрийг түүнд буцааж олгохгүй. Хувьцааны төлбөрөөс компанид учирсан хохирол, гарсан зардлыг нөхөн авч, хувьцааг нь компанийн мэдэлд үлдээнэ.

4. Тухайн гишүүнийг хассанаас хойш нэг жилийн дотор уг хувьцаа гүйлгээнд ороогүй бол түүнийг хүчингүй болгож компанийн дүрмийн санг мөн хэмжээгээр хорогдуулах бөгөөд сан нь энэ хуульд заасан дүрмийн сангийн доод хэмжээнээс бага байхыг хориглоно.

40 дүгээр зүйл. Дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх

1. Хувьцааны төлбөр бүрэн хийгдсэн нөхцөлд дүрмийн санг нэмэгдүүлж болно. Энэ заалтыг зөрчиж хувьцаа гаргасан этгээд түүнтэй холбогдон үүсэх хариуцлагыг биечлэн хүлээнэ.

2. Дүрэмд өөрөөр заагаагүй бол шинээр хувьцаа гаргах, эсхүл хувьцааны нэрлэсэн үнийг нэмэх аргаар дүрмийн санг нэмэгдүүлж болно.

3. Дүрмийн сан нэмэгдүүлэх асуудал хэлэлцэх гишүүдийн хурал хуралдуулах тухай зарлалд дор дурдсан зүйлийг тусгана:

1/ дүрмийн санг нэмэгдүүлэх хэмжээ, нэмэгдүүлэх болсон шалтгаан, арга;

2/ дүрмийн санг нэмэгдүүлэхтэй холбогдон дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

3/ шинээр гаргах хувьцааны төрөл, тоо, нэрлэсэн үнэ, нийт үнэ;

4/ хувьцааны захиалга эхлэх, дуусах хугацаа.

4. Дүрэмд өөрөөр заагаагүй бол компанид илүүдэл эд хөрөнгө хуримтлагдсан, эсхүл алдагдалд орсон нөхцөлд төлбөрийг нь буцаан олгож уг хувьцааг хүчингүй болгох буюу эсхүл хувьцааны нэрлэсэн үнийг багасгах аргаар дүрмийн сангийн хэмжээг хорогдуулж болно.

5. Дүрмийн санг өөрчлөх тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ. Бүртгэх байгууллага энэ тухай нийтэд мэдээлнэ.

41 дүгээр зүйл. Эд хөрөнгө хуваах

1. Компанийг татан буулгах үед бусдад өгөх өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу бүрэн барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд эзэмшиж байгаа хувьцаа /ногдол хувь/-тай нь хувь тэнцүү хуваана.

2. Компанийг татан буулгах үед түүний эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний байгаа эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн нэхэмжлэгчдэд хуваарилна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хувьцаат компанийн удирдлага

42 дугаар зүйл. Компанийн эрх барих байгууллага

1. Компанийн эрх барих байгууллага гишүүдийн хурал байна.

2. Дор дурдсан асуудлыг заавал гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

1/ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх;

3/ компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

4/ баланс, тайлан хэлэлцэж батлах;

5/ төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг энэ хуульд заасны дагуу сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох хөлс, урамшууллын хэмжээг тогтоох, тайланг хэлэлцэх;

6/ төлөөлөн удирдах зөвлөлийн тухайн жилийн төсвийг батлах;

7/ хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийг эрх бүхий байгууллагаас нийтэд зарласан мэргэшсэн нягтлан бодогчдын нэрсийн жагсаалтаас сонгож, тэдгээрт олгох хөлс, урамшууллын хэмжээг тогтоож, тайланг хэлэлцэх.

43 дугаар зүйл. Гишүүдийн хурал хуралдуулах журам

1. Гишүүдийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулна. Гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

2. Гишүүдийн ээлжит хурлыг жилд 1-ээс доошгүй удаа компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хийнэ.

3. Шаардлагатай үед төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа гишүүдийн санаачилгаар гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4. Гишүүдийн хурлын товыг хурал хуралдуулахаас 30 хоногийн өмнө зарлаж, гишүүдийн хурлаас гарах шийдвэрийн төслийг гишүүдэд бичгээр мэдэгдэнэ.

5. Хэлэлцэхээр товлоогүй асуудлыг зөвхөн гишүүдийн хуралд оролцож байгаа гишүүдийн зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

6. Гишүүдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга удирдана.

7. Гишүүн өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр гишүүдийн хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөлд гишүүдийн хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

8. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн гишүүдийн хуралд хүчинтэй. Гишүүдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон хянан шалгагч тухайн компанийн гишүүнийг төлөөлж гишүүдийн хуралд оролцохыг хориглоно.

44 дүгээр зүйл. Гишүүдийн хурал, гишүүдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

1. Саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа гишүүд оролцсоноор гишүүдийн хурал хүчин төгөлдөр болно. Гэхдээ хэлэлцэх асуудлын төрөл, компанийн гишүүдийн тоо зэргийг харгалзан компанийн дүрэмд хуралд оролцох гишүүдийн тооны доод хязгаарыг зааж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьд хүрээгүй бол гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж, дахин хуралдах өдрийг товлоно. Дүрэмд өөрөөр заагаагүй бол дахин зарласан хурал энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болно.

3. Гишүүд хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг гишүүдийн хуралд оролцсон гэж үзнэ. Харин ээлжит бус хуралд гишүүн заавал биечлэн оролцоно.

4. Гишүүдийн хуралд оролцогчдын саналын эрхийн дийлэнх олонхиор шийдвэр хүчин төгөлдөр болно.

5. Гишүүдийн ирц, хурлын явцын тэмдэглэл, гаргасан шийдвэрийг энэ хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан бүртгэлд бүртгэнэ.

45 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

1. Гишүүдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

2. Төлөөлөн удирдах зөвлөл 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн бүрэн эрхийн хугацааг дүрэмд заана.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр компанийн гишүүн биш этгээдийг сонгож болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх олонхи нь компанийн гишүүн байна.

4. Шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг гишүүдийн хурлаас хэдийд ч өөрчилж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн орон гарвал гишүүдийн хурлаас нөхөн сонгоно.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн өөр нөхөрлөл, компанийн удирдлагад сонгогдож болох эсэхийг дүрэмд заана.

6. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл гишүүдийнхээ дотроос зөвлөлийн даргыг сонгоно.

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнд орсон өөрчлөлтийн талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх бөгөөд бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

46 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

Төлөөлөн удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ компанийн бизнес төлөвлөгөөг зохиох;

2/ компанийн аппаратын зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоох;

3/ компанийн Гүйцэтгэх захирлыг Иргэний хуульд заасан хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, томилох;

4/ компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар Гүйцэтгэх захирлын эрх хэм хэмжээг тогтоох;

5/ Гүйцэтгэх захирлын болон компанийн аппаратын үйлажиллагаанд дотоодын хяналт тавих;

6/ гишүүдийн хурал зарлан хуралдуулах;

7/ компанийн баланс, тайлан болон дүрмийн санд оруулах өөрчлөлтийн талаар хуралд дүгнэлт гаргах;

8/ жилд нэгээс доошгүй удаа хуралд ажлаа тайлагнах;

9/ хууль болон дүрэмд заасан бусад бүрэн эрх.

47 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, түүний шийдвэр

1. Төлөөлөн удирдах зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал сард нэг удаа хуралдана. Гишүүдийн дийлэнх олонхи, хэрэв 3 гишүүнтэй бол гишүүд бүрэн оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

3. Зөвлөлийн дарга, гишүүн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 2, 4 дэх хэсэг ээлжит бус хуралд нэгэн адил хамаарна.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхиор шийдвэр хүчин төгөлдөр болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарна.

48 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам

Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг хурлаар хэлэлцэж батлахаар дүрэмд заагаагүй бол журмыг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

49 дүгээр зүйл. Гүйцэтгэх захирал

1. Гүйцэтгэх захирал нь дүрэм болон хөлсөөр ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

2. Дүрэмд өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэх захирлаар компанийн гишүүн бус этгээдийг томилж болно. Гүйцэтгэх захирал компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

3. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг Иргэний хуулийн 308-312 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

4. Гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулах тухай саналыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг хүлээж аваагүй тохиолдолд компанийн хянан шалгагчид хандах эрхтэй.

5. Гүйцэтгэх захирал томилогдсоноосоо хойш 15 хоногийн дотор гарын үсгийн хэвийг бүртгэх байгууллагад тэмдэглүүлнэ.

50 дугаар зүйл. Төлөөлөлт

1. Гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийг төлөөлж болно.

2. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагаатай холбогдолтой гэрээ, хэлэлцээрийг төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор хийнэ.

3. Гүйцэтгэх захиралтай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн компанийг төлөөлөн оролцоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хяналт

51 дүгээр зүйл. Дотоод хяналт

1. Компанийн гүйцэтгэх захирал болон компанийн аппаратын үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

2. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг компанийн дүрэмд заана.

52 дугаар зүйл. Гишүүдээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналт

1. Төлөөлөн удирдах зөвлөл болон компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/ гүйцэтгэнэ.

2. Хяналтын үүргийг зөвхөн нэг этгээд гүйцэтгэж байгаа бол түүнийг хянан шалгагч гэнэ. Харин хэд хэдэн этгээд хяналтын үүрэг гүйцэтгэхээр бол хянан шалгагчдын зөвлөл байгуулна.

3. Хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийн сонгуулийн хугацааг дүрмээр тодорхойлно.

53 дугаар зүйл. Хянан шалгагч байхыг хориглох үндэслэл

Дор дурдсан этгээдийг хянан шалгагч байхыг хориглоно:

1/ эрх зүйн чадамжгүй;

2/ урд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан;

3/ компанийн удирдлагын төрөл, садан, эсхүл ямар нэг шалтгаанаар компанийн удирдлагын нөлөөнд автагдсан;

4/ тухайн компани болон хараат буюу салбар компанид ажилладаг.

54 дүгээр зүйл. Хянан шалгагчийн үүрэг

1. Хянан шалгагч дараахь үүрэгтэй байна:

1/ компанийн удирдлагын үйл ажиллагааг хянах;

2/ компанийн үйл ажиллагаа энэ хууль, компанийн дүрэмд заасны дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;

3/ нягтлан бодох бүртгэл хөтлөлт, баланс, тайлан гаргалт, татвар төлөлт хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийгдсэн эсэхийг хянах;

4/ энэ хуулийн 67 дугаар зүйлд заасан компанийн бүртгэлүүд баланс, тайлангийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэхийг шалгах;

5/ эд хөрөнгийн үнэлгээ зөв эсэхийг шалгах;

6/ бэлэн мөнгө, үнэт цаас, барьцаалсан зүйлийг шаардлагатай гэж үзвэл хэдийд ч тоолж шалгах;

7/ шаардлагатай гэж үзвэл компанийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлэлцээрийг шалгах.

2. Хянан шалгагч шалгасан баримт бичиг, баланс, тайлангийн нууцыг хадгалах үүрэгтэй.

3. Хянан шалгагчийн хийсэн хяналт шалгалтын баримт бичиг, түүнтэй холбогдон гарсан шийдвэрийг энэ хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан бүртгэлд бүртгэнэ.

55 дугаар зүйл. Хянан шалгагчдын зөвлөлийн хурал, хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

1. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хянан шалгагчдын зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хийнэ.

2. Хянан шалгагчдын олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Шийдвэрийг "зөвшөөрсөн", "татгалзсан" алин болохыг хянан шалгагч тус бүрээр протоколд тэмдэглэнэ.

56 дугаар зүйл. Гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцох

1. Хянан шалгагч гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцоно.

2. Хянан шалгагчийн тавьсан асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл хүлээж авахгүй буюу тодорхой асуудал хэлэлцүүлэхээр гишүүдийн хурал хуралдуулах хүсэлт гаргасныг нь зөвшөөрөөгүй тохиолдолд хянан шалгагч гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.

57 дугаар зүйл. Хянан шалгагчийн хариуцлага

Хянан шалгагч нь энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

58 дугаар зүйл. Хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-д гомдол гаргах

1. Хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-д гишүүд тодорхой асуудлаар үндэслэл бүхий гомдол гаргаж болно.

2. Гомдолтой холбогдсон асуудлыг хянан шалгагчид яаралтай шалгаж, энэ тухай дүгнэлт, шийдвэр гаргана. Шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг хэлэлцүүлэхээр гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.

59 дүгээр зүйл. Гишүүдээс шүүхэд гомдол гаргах

1. Төлөөлөн удирдах зөвлөл болон хянан шалгагчдын үйл ажиллагаатай холбогдуулан гишүүд шүүхэд гомдол гаргаж болно.

2. Шүүхийн зардлыг гомдол гаргасан гишүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцна.

3. Гомдолд заасан зүйл үндэслэлтэй бөгөөд ноцтой байдал тогтоогдвол уг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр гишүүдийн хурлыг шүүх зарлан хуралдуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Компанийн санхүү, бүртгэл тайлан

60 дугаар зүйл. Хувьцааны тухай ойлголт

1. Хувьцаат компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн ногдол ашиг авах, компанийн эд хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөх эрхийг гэрчилж байгаа үнэт цаасыг хувьцаа гэнэ.

2. Энгийн хувьцаа бүр саналын эрхтэй.

3. Хувьцаат компани үүсгэн байгуулах, нэмж хувьцаа гаргах төсөлд заасан хувьцааны нэрлэсэн үнээс доогуур үнээр хувьцаа гаргахыг хориглоно.

4. Хувьцаа үл хуваагдана.

61 дүгээр зүйл. Хэд хэдэн эзэмшигчтэй хувьцаа

1. Нэг хувьцааг хэд хэдэн этгээд хамтран эзэмшиж болох бөгөөд тэд хувьцаа эзэмших эрхээ хамтран хэрэгжүүлнэ.

2. Нэг хувьцааг хамтран эзэмшиж байгаа хэд хэдэн этгээд уг хувьцаатай холбогдон үүсэх үүргийг хамтран хариуцна.

3. Хувьцаа эзэмшихтэй холбоотой аливаа мэдээллийг хамтран эзэмшигчдийн аль нэгэнд мэдэгдсэнийг хангалттай гэж үзнэ.

4. Хувьцаа эзэмших эрхээ зөвхөн нэг этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

62 дугаар зүйл. Хувьцааны ангилал

1. Хувьцааг түүний эрхээс хамаарч дор дурдсанаар ангилна:

1/ энгийн хувьцаа;

2/ давуу эрхийн хувьцаа.

2. Саналын эрхтэй хувьцааг энгийн; тэргүүн ээлжинд ногдол ашиг, эд хөрөнгө авах эрхтэй, саналын эрхгүй хувьцааг давуу эрхийн хувьцаа гэнэ.

3. Компани давуу эрхийн хувьцаа гаргахаар бол түүний тоо хэмжээ, төлбөр хийх журам, уг хувьцааг хүчингүй болгох хугацаа, эзэмшигчдийн эдлэх эрх, хязгаарлалт зэргийг нарийвчлан тодорхойлсон нэмэлт журам боловсруулж гишүүдийн хурлаар батална.

4. Компаниас гаргах давуу эрхийн хувьцаа дүрмийн сангийн 20 хувиас дээш байхыг хориглоно.

63 дугаар зүйл. Хувьцааны бүрдүүлбэр

1. Хувьцаа дор дурдсан бүрдүүлбэртэй байна:

1/ хувьцаа гаргагчийн нэр, оршин байгаа газар, үйл ажиллагаа явуулах хугацаа;

2/ хувьцааны нэрлэсэн үнэ;

3/ хувьцаа гаргагчийн дүрмийн сангийн хэмжээ;

4/ хувьцааны төрлөөс хамаарч эзэмшигчдийн эдлэх эрх.

2. Хувьцааны эх хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

64 дүгээр зүйл. Өөрийн хувьцааг худалдан авах

1. Компанийн бүх хувьцаа худалдагдсаны дараа компани өөрийн хувьцааг худалдан авч болно.

2. Худалдаж авах хувьцааны тоо хэмжээ, төлбөр хийх хугацаа, ашиглах журмыг гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Худалдан авч байгаа хувьцааны хэмжээ дүрмийн сангийн 10 хувиас дээш байж болохгүй.

4. Компани андеррайтерт өөрийн хувьцааг худалдан авахаар захиалга хийж болохгүй.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийг зөрчиж захиалга хийсэн бол үүнтэй холбогдон үүсэх хариуцлагыг захиалга хийсэн этгээд хариуцна.

65 дугаар зүйл. Бусад компанийн хувьцааг худалдан авах

1. Компани өөр компанийн гаргасан хувьцааг худалдан авч болно. Хувьцааг нь худалдан авсан компани хувьцаа гаргасан компанийн хувьд оролцогч компани болно.

2. Компани өөр компанийн хувьцааг үйл ажиллагаанд нь шийдвэрлэх нөлөө үзүүлэх хэмжээгээр эзэмшиж байвал энэ нь толгойлох компани, хувьцаа гаргасан компани нь хараат компани болно.

3. Оролцогч болон толгойлох компани хувьцааг нь эзэмшиж байгаа компанийн үйл ажиллагаанд зөвхөн саналын эрхээр дамжуулан нөлөөлнө.

4. Хараат компани толгойлох компанийн хувьцааг худалдан авч болно.

66 дугаар зүйл. Облигаци гаргах

1. Компани дүрмийн сангийн хэмжээгээр барьцаалж, компанийн облигаци гаргаж болно.

2. Облигаци дараахь бүрдүүлбэртэй байна:

1/ компанийн нэр, оршин байгаа газар, эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээ;

2/ компанийн дүрмийн сан, түүний төлбөр хийгдсэн хэсгийн хэмжээ;

3/ облигаци гаргах тухай гишүүдийн хурлын шийдвэр, он, сар, өдөр;

4/ гаргасан облигацийн тоо, нэрлэсэн үнэ, нийт үнэ, хүү төлбөрийн болон буцааж худалдан авах нөхцөл;

5/ баталгаа болгох хөрөнгийн нэр, хэмжээ.

3. Компанийн гаргасан облигаци хөрвөх эсхүл давуу эрхтэй байж болно.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлтэй облигаци гаргах журмыг компанийн дүрмээр тодорхойлно.

67 дугаар зүйл. Компанийн бүртгэл

1. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтөлнө:

1/ гишүүдийн бүртгэл, гишүүдийн бүртгэлд тэдгээрийн овог, нэр, эзэмшиж буй хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, нийт үнэ шилжилт хийсэн тухай тэмдэглэл зэргийг заана;

2/ облигацийн бүртгэл, облигацийн бүртгэлд гаргасан облигацийн тоо хэмжээ, үнэ, облигаци эзэмшигчийн овог нэр, шилжилт

хийсэн тухай тэмдэглэл, төлбөр хийсэн байдал, компаниас гаргасан, буцаан авсан облигацийн тоо хэмжээг заана;

3/ гишүүдийн хурлын болон хурлын шийдвэрийн бүртгэл, хурал, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр, шийдвэр батлахад зөвшөөрсөн, татгалзсан алин болохыг гишүүн тус бүрээр зааж тэмдэглэнэ;

4/ төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл;

5/ хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийн шийдвэрийн бүртгэл;

6/ облигаци эзэмшигчдийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг мөн хэсгийн 4, 5, 6-д нэг адил заана.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаас бусад бүртгэлийг компанийн нарийн бичгийн дарга хөтөлнө. Нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас сонгох бөгөөд түүний эрх хэмжээ, үүрэг, хариуцлагыг нь дүрэмд заана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасан бүртгэлийг облигаци эзэмшигчдийн хурлаас сонгогдсон этгээд хөтөлнө.

5. Энэ зүйлд заасан бүртгэл тус бүрийг тусгай дэвтэрт хөтөлж бүртгэлийн дэвтрийн хуудсыг өсөх дарааллаар дугаарлан, бүртгэх байгууллагаар тэмдэг даруулж баталгаажуулна.

6. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3-т заасан бүртгэлийг гишүүд өөрсдөө шалгаж, эсхүл шинжээчээр магадлуулж болно. Шинжээчээр магадлуулсантай холбогдон гарах зардлыг тухайн гишүүн хариуцна.

68 дугаар зүйл. Санхүүгийн тайлан гаргах

1. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайланг гаргаж нийтлүүлнэ.

2. Санхүүгийн тайланд дараахь үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна:

1/ баланс;

2/ орлогын тайлан;

3/ мөнгөн гүйлгээний тайлан;

4/ хуримтлагдсан ашгийн тайлан;

5/ нэмэлт тайлбар, тодруулга.

3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал хариуцна.

69 дүгээр зүйл. Балансад тусгагдах хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийн ангилалт

Балансад тусгагдах хөрөнгө, түүний эх үүсвэрийг дор дурдсанаар ангилна:

1. Хөрөнгө:

1/ захиалагдсан, төлөгдөөгүй хөрөнгө, /нэр төрлөөр/;

2/ үл хөдлөх болон удаан гүйлгээтэй хөрөнгө:

а/ үл хөдлөх хөрөнгө;

б/ удаан гүйлгээтэй биет хөрөнгө;

в/ биет бус хөрөнгө;

3/ капитал оруулалт:

а/ хувьцаагаар;

б/ облигацаар;

в/ тусгай зориулалттай сан /хадгаламж/;

г/ бусад.

4/ эргэлтийн хөрөнгө:

а/ мөнгөн хөрөнгө;

б/ авлага;

в/ үнэт цаас;

г/ материаллаг нөөцүүд;

д/ урьдчилан төлөгдсөн зардал.

2. Хөрөнгийн эх үүсвэр:

1/ хувь нийлүүлэгчдийн капитал, нөөц:

а/ дүрмийн сан /гаргасан хувьцаагаар/;

б/ нэмж төлөгдсөн капитал;

в/ тодорхой зориулалттай сан, нөөц;

г/ хуримтлагдсан ашиг.

2/ урт хугацаат өр төлбөр:

а/ облигаци;

б/ зээлийн өглөг;

в/ бусад өглөг.

3/ богино хугацаат өр төлбөр:

а/ харилцагч байгууллагад өгөх өглөг;

б/ ажиллагчид болон бусад хүмүүст өгөх өглөг;

в/ банкны зээл;

г/ татварын өглөг.

70 дугаар зүйл. Орлого, үр дүнгийн тайлан

Орлогын тайлан дор дурдсан бүтэцтэй байна:

1/ нийт болон цэвэр борлуулалт;

2/ борлуулалтын өртөг;

3/ борлуулалтын болон удирдлагын зардал;

4/ санхүүгийн ажиллагааны орлого, зардал;

5/ онцгой шинжтэй /нэг удаагийн/ орлого, зардал;

6/ татвар төлсний дараахь цэвэр орлого /ашиг/;

7/ нэгж хугацаанд ногдох ашиг.

71 дүгээр зүйл. Мөнгөн гүйлгээний тайлан

Тайланд мөнгөн гүйлгээний орлого, зарлагын хөдөлгөөнийг дараахь хэсгүүдээр ангилж харуулна:

1/ үндсэн үйл ажиллагааны;

2/ хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны;

3/ санхүүгийн үйл ажиллагааны.

72 дугаар зүйл. Хуримтлагдсан ашгийн тайлан

Хуримтлагдсан ашгийн тайлан дор дурдсан бүтэцтэй байна:

1/ тайлангийн үеийн ашиг /алдагдал/-ийн эхний үлдэгдэл;

2/ цэвэр ашиг /алдагдал/;

3/ ашгийн хуваарилалт;

4/ тайлангийн үеийн ашиг /алдагдал/-ийн эцсийн үлдэгдэл.

73 дугаар зүйл. Санхүүгийн тайлангийн нэмэлт тайлбар тодруулга

1. Санхүүгийн тайлан гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, оролцогч компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримтлагдсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

2. Санхүүгийн тайланг компанийн хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-аар хянуулж, үр дүнг гишүүдийн хуралд танилцуулна.

3. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт аргачлалыг нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайд батлаж мөрдүүлнэ.

74 дүгээр зүйл. Удирдлагын үйл ажиллагааны тайлан

1. Компанийн бизнесийн ажиллагааны явц, ирээдүйн төлөв, чиг хандлагыг тодорхойлсон төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан нь дор дурдсан хэсгүүдтэй байна:

1/ компанийн тайлангийн жилийн удирдлагын үйл ажиллагааны тухай илтгэл, дүгнэлт;

2/ компанийг хөгжүүлэх талаар хийсэн судалгаа, үр дүн;

3/ хараат, толгойлох болон бусад компаниудын хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоо;

4/ эдийн засгийн үндсэн үзүүлэлт, санхүүгийн үр дүн;

5/ сүүлийн 5-10 жилийн үйл ажиллагааны үзүүлэлтийн динамик.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр гишүүдийн хурлаар хэлэлцүүлж үнэлэлт дүгнэлт өгнө.

3. Хөндлөнгийн бүртгэл, хяналтын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг Үнэт цаасны хороо, бүртгэл, санхүү, татварын байгууллагад хүргүүлнэ. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөндлөнгийн хяналтын ийм байгууллага байхгүй бол харилцагч санхүүгийн байгууллагаар тайланг хянуулж болно.

4. Компанийн санхүүгийн болон татварын бүртгэл нь ялгаатай байж болох бөгөөд татварын тооцоо бүртгэх, тайлагнах журмыг Албан татварын хуульд нийцүүлэн холбогдох байгууллагаас тусгайлан гаргаж мөрдүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Өөрчлөн байгуулах

75 дугаар зүйл. Нэгдэх, нийлэх

1. Бие даасан хэд хэдэн компаниуд нэгдэж шинээр нэг компани байгуулах буюу эсхүл хэд хэдэн компаниуд аль нэгэндээ нийлж томрох аргаар энэ хуульд заасан аль ч хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж болно.

2. Дампуурсан буюу татан буугдаж байгаа компаниудад дээрх заалт хамаарахгүй.

76 дугаар зүйл. Нэгдэх, нийлэх тухай төсөл боловсруулах

1. Нэгдэж эсхүл нийлж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл нэгдэх, нийлэх тухай төсөл /цаашид төсөл гэх/ боловсруулна.

Төсөлд дор дурдсан зүйлийг тусгана:

1/ шинээр байгуулах компанийн нэр, энэ хуульд заасан аль төрөл, хэлбэрээр зохион байгуулагдах, оршин байх газар;

2/ шинээр байгуулж байгаа компанийн дүрэм, хэрэв аль нэг компанид нийлж байгаа бол тухайн компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт;

3/ хувьцаа, ногдол хувь, эд хөрөнгийн үнэлгээ, шилжүүлэх харьцаа;

4/ нэгдсэн, нийлсэн компаниудын хувьцаа, эд хөрөнгийн харьцааг хуваарилах арга;

5/ ашиг хуваарилахад оролцож эхлэх хугацаа;

6/ нэгдсэн нийлсэн компаниудын эрх үүрэг шилжих хугацаа;

7/ хувьцаанаас бусад төрлийн үнэт цаас эзэмшигчидтэй хийсэн гэрээ, хэлцлийг хэрхэх;

8/ нэгдэж нийлж байгаа компанийн удирдлагын эрх ашгийг хамгаалах үүднээс тэдэнд зарим нэгэн хөнгөлөлт, давуу байдал тогтоох эсэхийг тусгах.

77 дугаар зүйл. Нэгдэж, нийлж байгаа компаниудын хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэр

1. Нэгдэх нийлэх төслийг бүртгүүлснээс хойш 4 сарын дотор төлөөлөн удирдах зөвлөл нэгдэж, нийлж байгаа компаниудын хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийг тогтооно.

2. Нэгдэж нийлж шинээр компани байгуулагдсан өдрөөр тасалбар болгон нэгдэж, нийлж байгаа компаниудын дуусгалтын баланс, тайланг шинээр байгуулж байгаа компанийн эхлэлтийн баланс, тайланг зохионо.

3. Нэгдэж, нийлж байгаа компанийн гишүүд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт бичгийг бүхэлд нь буюу өөрт шаардлагатай хэсгийг хуулбарлан авах буюу үзэж танилцах эрхтэй.

78 дугаар зүйл. Нэгдэх, нийлэх тухай шийдвэр гаргах, бүртгүүлэх

1. Төслийг нэгдэж, нийлж байгаа компанийн гишүүдийн хурлаар тус бүр хүлээн зөвшөөрснөөр нэгдэх, нийлэх тухай шийдвэр гаргана. Шийдвэрийг нотариатаар гэрчлүүлнэ.

2. Шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлэх тухай өргөдөл гаргана.

79 дүгээр зүйл. Нэгдсэн, нийлсэн компаниудын эрх, үүрэг дуусгавар болох

Шинээр байгуулагдсан компанийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн нэгдсэн, нийлсэн компаниудын эрх, үүрэг дуусгавар болно.

80 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан

Нэгдэж, нийлж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл тэдгээр компаниудыг нэгтгэх, нийлүүлэх шаардлага болон хувьцаа, ногдол хувь, эд хөрөнгийн үнэлгээ, шилжүүлэх харьцааг тодорхойлсон тайлан бичнэ.

81 дүгээр зүйл. Шинжээч, шинжээчийн тайлан

1. Нэгдэж, нийлж байгаа болон шинээр байгуулагдсан компанийн төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа, ногдол хувь болон эд хөрөнгийн үнэлгээ, тэдгээрийн шилжүүлэх харьцааг дахин магадлах шаардлагатай гэж үзвэл эрх бүхий шинжээчийг зохих журмын дагуу сонгон ажиллуулна.

2. Шинжээч магадлан шалгасан тухайгаа тайлан бичиж түүнд хувьцаа, ногдол хувь болон эд хөрөнгийн үнэлгээ, шилжүүлэх харьцааг тогтооход хэрэглэсэн арга, тэдгээр нь үнэн зөв хийгдсэн эсэхийг тодорхой тусгана.

3. Шинжээчийг шаардлагатай баримт бичгээр хангах үүргийг тухайн компани хүлээнэ.

4. Дүгнэлтийн үнэн зөвийг шинжээч хариуцна.

82 дугаар зүйл. Баримт бичиг бүрдэл болгох

Нэгдэж, нийлж байгаа компаниуд дор дурдсан баримт бичиг бүрдүүлж 30 хоногийн дотор бүртгэх байгууллагад өгнө:

1/ нэгдэх, нийлэх төсөл, төлөөлөн удирдах зөвлөл болон шинжээчийн тайлан;

2/ нэгдэж, нийлж байгаа компаниудын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, төлөөлөн удирдах зөвлөл болон хянан шалгагчдын тайлан, шаардлагатай гэж үзвэл санхүүгийн тайланг тушаасныг гэрчилсэн баримт;

3/ нэгдэж, нийлж байгаа компани тус бүрийн хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэр.

83 дугаар зүйл. Хуваах, тусгаарлах

1. Нэг компанийг хэд хэдэн компани болгож хуваах, эсхүл нэг компаниас өөр компани шинээр тусгаарлах аргаар компанийг өөрчлөн байгуулж болно.

2. Компани хуваагдах, тусгаарлах нөхцөлд тухайн компанийн гишүүний хувьцаа болон ногдол хувь эзэмших эрх хэвээр байна.

3. Энэ хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэг энэ зүйлд нэг адил хамаарна.

84 дүгээр зүйл. Хуваах, тусгаарлах төсөл

1. Хувааж, эсхүл тусгаарлаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийн 76 дугаар зүйлд заасантай адил хуваах, тусгаарлах төсөл боловсруулах бөгөөд түүнд компани тус бүрд шилжиж байгаа хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээг нарийвчлан тусгана.

2. Хуваах, тусгаарлахад энэ хуулийн 80, 81 дүгээр зүйлд заасан тайлан гаргаж, энэ хуулийн 82 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад өгнө.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани

85 дугаар зүйл. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн онцлог

1. Төрийн өмчийн компанийн захирал, хянан шалгагчийг төрийн нэрийн өмнөөс өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гэрээ байгуулж, томилно.

2. Төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн өмчийн оролцооны хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хянан шалгагчийг төрийн эрх бүхий байгууллагаас томилох эрх олгохоор дүрэмд заана.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хянан шалгагчийг гагцхүү түүнийг томилсон байгууллагын шийдвэрээр өөрчилнө.

86 дугаар зүйл. Бусад харилцааг зохицуулах

Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн онцлогтой холбогдон энэ хуулийн 85 дугаар зүйлд зааснаас бусад нийтлэг харилцаа энэ хуулийн 1 дүгээр бүлгээр, бусад харилцаань III хэсгийн IV, V, VI, VII, VIII, X бүлгээр тус тус зохицуулагдана.

АРАВДУГААР БҮЛЭГ

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

87 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1. Дүрмийн сан нь ногдол хувьд хуваагддаг, хүлээсэн үүргээ өөрийн эд хөрөнгөөр хариуцдаг, гишүүн нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг хуулийн этгээдийг хязгаарлагдмал хариуцлагатай компани гэнэ.

2. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн оноосон нэрийн ард "ХХ" гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

88 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, бүртгүүлэх

1. Хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид компани гэнэ/ энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулагдана. Гэрээнд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зүйлийг тусгана. Компани энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгасан дүрэмтэй байна.

2. Компани ганц гишүүнтэй байж болох бөгөөд ийм нөхцөлд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зүйлийг дүрэмд тусгана.

3. Компани байгуулахад дор дурдсан нөхцөл бүрдсэн байна:

1/ мөнгөн хэлбэрээр оруулах хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн;

2/ эд хөрөнгөөр оруулах хөрөнгө бүрэн оруулсан;

3/ шаардлагатай бол энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авсан;

4/ зохион байгуулах хурлаа хийж дүрмээ батлалсан байх.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бүрдсэн бол энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл гаргана.

5. Гэрээ, дүрэм нотариатаар гэрчлэгдсэн байна.

89 дүгээр зүйл. Дүрмийн сангийн хэмжээ

1. Дүрмийн сангийн хэмжээ 10 сая төгрөгөөс доошгүй байна.

2. Дүрмийн сан бүрдүүлэхэд гишүүдээс оруулах хөрөнгийн хэмжээ өөр өөр байж болно.

90 дүгээр зүйл. Ногдол хувь

1. Ногдол хувь нь гишүүний саналын болон ногдол ашиг авах эрхийг тодорхойлох бөгөөд компани гишүүндээ ногдол хувь эзэмших эрхийн гэрчилгээ олгоно.

2. Ногдол хувь тутам саналын эрхтэй байна.

3. Эд хөрөнгийн хэлбэрээр оруулж байгаа хөрөнгийн хэмжээ саналын эрхээр тооцсон үнэлгээтэй тэнцүү биш бол зөрүүг мөнгөөр нэмж /хасаж/ саналын эрхийг тэгшитгэнэ.

91 дүгээр зүйл. Ногдол хувь шилжүүлэх, худалдах

1. Дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол хувийг бусдад шилжүүлж болно. Гэхдээ заавал бусад гишүүдийн зөвшөөрлийг авсан байна.

2. Ногдол хувь шилжүүлснийг гишүүдийн бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн үеэс эхлэн ногдол хувь шилжсэнд тооцно.

3. Ногдол хувийг хэд хэдэн этгээд хамтран эзэмшиж болох бөгөөд хамтран эзэмшигчид энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасантай адил эрх, үүрэгтэй байна.

4. Нас барсан буюу сураггүй алга болсонд тооцогдсон гишүүний ногдол хувийг хууль ёсны болон гэрээслэлээр өв залгамжлагч гарч ирээгүй нөхцөлд тухайн этгээдэд ногдох хувийг төрийн өмчлөлд шилжүүлэх тухай хуульд тусгайлан заагаагүй бол гишүүдэд хуваан эзэмшүүлж болно.

5. Гишүүн гэрээнд заасан хугацаанд хөрөнгө оруулаагүй бол хөрөнгө оруулах хугацааг зөвхөн нэг удаа 30 хоногоор сунгаж болно. Хэрэв дээр заасан хугацаанд хөрөнгөө оруулаагүй бол гишүүнийг компаниас хасч түүний ногдол хувийг бусдад худалдаж болно. Уг ногдол хувь худалдагдсан бол тухайн гишүүний урьдчилан хийсэн төлбөрийг түүнд буцаан олгоно. Хэрэв ногдол хувь худалдагдаагүй бол төлбөрийг түүнд буцаан олгохгүй бөгөөд түүнээс компанид учирсан хохирол, гарсан зардлыг нөхөн авна.

6. Худалдагдаж байгаа ногдол хувийг тухайн компанийн гишүүд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй байна.

7. Тухайн гишүүнийг хассанаас хойш 1 жилийн дотор ногдол хувь бусдад худалдагдаагүй бол тухайн компанийн дүрмийн санг тэр хэмжээгээр хорогдуулах бөгөөд сан нь энэ хуульд заасан дүрмийн сангийн доод хэмжээнээс бага байхыг хориглоно.

92 дугаар зүйл. Компанийн эрх барих байгууллага, удирдлага

1. Компанийн эрх барих байгууллага нь гишүүдийн хурал байна. Гишүүдийн хурал энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хувьцаат компанийн гишүүдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Гишүүдийн хурлаас компанийг удирдуулахаар захирлыг, шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоно. Тухайн компанийн гишүүн биш этгээдийг захирлаар сонгож болно.

3. Шаардлагатай гэж үзвэл захирлыг гишүүдийн хурлаас хэдийд ч өөрчилж болно. Энэ тухайгаа бүртгэх байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

4. Компанийн захирал өөр нөхөрлөл компанийн удирдлагад сонгогдож болох эсэхийг дүрэмд заана.

93 дугаар зүйл. Захирлын бүрэн эрх

Захирал нь гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг шийдвэрлэнэ. Захирал нь ажлаа гишүүдийн хуралд хариуцан тайлагнана.

94 дүгээр зүйл. Төлөөлөлт

1. Захирал компанийг төлөөлөх эрхтэй.

2. Компанийн үйл ажиллагаатай холбогдсон бүх гэрээ хэлэлцээрийг компанийг төлөөлж захирал хийнэ.

95 дугаар зүйл. Захиралд хүлээлгэх хариуцлага

1. Захиралд хариуцлага хүлээлгэх асуудлыг гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хариуцлага хүлээлгэх үндэслэл нь баланс, тайлангийн үр дүнгээр батлагдсан байвал зохино.

2. Компанийн дүрмийн сан батлагдсан хэмжээнд байгаа боловч харилцагчдын нэхэмжлэлийн шаардлагыг хангаж хүрэхээргүй бол гишүүдийн хурал уг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Захирал хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглан гэрээ, хэлцэл хийхийг хориглоно.

4. Хуурч мэхлэх, хайхрамжгүй хандах зэрэг хууль бус үйл ажиллагааны улмаас компанийн гишүүд болон бусад этгээдэд ямар нэг хохирол учруулбал захирал уг хохирлыг биечлэн хариуцна.

96 дугаар зүйл. Компанийн бусад харилцааг зохицуулах

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн онцлогтой холбогдон энэ бүлэгт зааснаас бусад нийтлэг харилцааг энэ хуулийн 1 дүгээр бүлгээр, удирдлагатай холбогдон үүсэх харилцааг 5 дугаар бүлгээр, хяналт шалгалттай холбогдон үүсэх харилцааг 6 дугаар бүлгээр, санхүү, бүртгэл тайлантай холбогдон үүсэх харилцааг 7 дугаар бүлгээр, өөрчлөн байгуулахтай холбогдон үүсэх харилцааг 8 дугаар бүлгээр тус тус зохицуулна.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хууль нь хоршооны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршоог үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь дуусгавар болгох, удирдлагын зохион байгуулалт, гишүүний эрх, үүрэг болон хоршооны санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл. Хоршооны тухай хууль тогтоомж

1. Хоршооны тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад ахтаас бүрдэнэ.

2. Хуулийн этгээд байгуулахгүйгээр иргэд, хуулийн этгээдүүд хамтран ажиллах асуудал энэ хуулиар зохицуулагдахгүй.

3 дугаар зүйл. Хоршооны зорилго

Хоршоо нь гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, тэдний эдийн засгийн нийтлэг ашиг сонирхол, хэрэгцээг хангах зорилготой байна.

4 дүгээр зүйл. Хоршооны зохион байгуулалтын болон үйл ажиллагааны зарчим

Хоршоо нь дараахь зарчмаар зохион байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулна:

1) хоршоог сайн дурын үндсэн дээр байгуулж, гишүүнээр элсэх, гишүүнээс гарах нь чөлөөтэй байх;

2) хоршооны үйл ажиллагааны удирдлага, хяналтад гишүүн бүр тэгш эрхтэй оролцох, хоршоо нь гишүүдээрээ удирдуулсан өөрөө удирдах ёсны зарчмаар ажиллах;

3) гишүүн хөдөлмөр, эд хөрөнгөө нэгтгэх замаар хоршооны үйл ажиллагаанд оролцох;

4) орлогоо гишүүдэд шударгаар хуваарилах;

5) хоршоо нь хуулийн хүрээнд бүх асуудлаа бие даан шийдвэрлэж байх;

6) хоршоог удирдах, аж ахуйг эрхлэн хөтлөх талаархи гишүүдийнхээ мэргэшил, боловсролыг байнга дээшлүүлэх.

5 дугаар зүйл. Хоршооны төрөл, хэлбэр

1. Хоршоо нь үйлдвэрлэлийн, үйлчилгээний, хэрэглэгчдийн гэсэн үндсэн төрөлтэй байна.

2. Хоршоо нь үйл ажиллагааныхаа чиглэлээр хөдөө аж ахуйн ханган борлуулах, мал аж ахуйн, түүхий эд боловсруулах, газар тариалангийн, эд хэрэглэгчдийн, аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн, ахуйн үйлчилгээний, гар урчуудын, ажиллах хүчний, мөнгөн хадгаламж, зээлийн, даатгалын, орон сууцны, тээврийн, эрчим хүчний, барилгын, соёл, боловсрол, эмнэлэг, эрүүл ахуйн үйлчилгээний зэрэг болон эдгээрийн хосолмол хэлбэртэй байж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хоршоог байгуулах, бүртгүүлэх

6 дугаар зүйл. Хоршоог байгуулах

Хоршоог иргэн, хуулийн этгээдүүд санаачилж 3-аас доошгүй гишүүнтэйгээр байгуулж болно.

7 дугаар зүйл. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг, түүнийг бүрдүүлэх журам

1. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна.

2. Үүсгэн байгуулагчид бүх гишүүдийн хурал хийж, дүрмээ батална.

3. Дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

1) хоршооны оноосон нэр, орших газар;

2) үүсгэн байгуулагчдын нэр, хаяг;

3) хоршооны зорилго, үйл ажиллагааны чиглэл, хоршооны төрөл, хэлбэр;

4) хоршооны эд хөрөнгийн хэмжээ, түүнийг бүрдүүлэх хугацаа, хэлбэр;

5) хоршоонд гишүүнээс нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, түүнийг бүртгэх журам;

6) хоршооны орлогыг тооцох, бүртгэх, түүнийг гишүүдэд болон хоршооны эд хөрөнгөд хуваарилах журам;

7) хоршооны эд хөрөнгийг ашиглах журам;

8) гишүүнээр элсэх, гишүүнээс гарах, хасах нөхцөл, гишүүний эрх, үүрэг, сахилгын хариуцлага;

9) хоршооны эд хөрөнгийн хариуцлага, түүнд гишүүдийн нөхөх хариуцлага;

10) гишүүнд үйлчлэх хэлбэр;

11) санал хураах, санал тэнцсэн үед шийдвэр гаргах журам;

12) хоршоог өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг дуусгавар болгох, эцсийн тооцоо хийх журам;

13) хоршооны удирдлага, түүний бүрэн эрх;

14) хоршоо салбар, төлөөлөгчийн газартай байх эсэх, түүний эрх, үүрэг;

15) хуульд заасан бусад зүйл.

8 дугаар зүйл. Хоршоог бүртгүүлэх журам

1. Хоршоог үүсгэн байгуулагчид дүрмээ баталснаас хойш 30 хоногийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлэх өргөдөл гаргана. Өргөдөлд дүрмийг хавсаргана.

2. Бүртгэх байгууллага өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

3. Дүрмийг хууль тогтоомжид нийцээгүй гэж үзвэл бүртгэх байгууллага зохих үндэслэлийг зааж бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргана. Энэ шийдвэрийг үүсгэн байгуулагчид эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

4. Хоршоо улсын бүртгэлд бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

5. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 14-т заасан асуудлаар хоршооны дүрэмд өөрчлөлт орвол энэ тухайгаа

14 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ. Бүртгэх байгууллага энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмаар энэ өөрчлөлтийг бүртгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Хоршооны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа

9 дүгээр зүйл. Хоршооны эд хөрөнгө

1. Хоршооны эд хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

1) гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө;

2) дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар;

3) хоршооны үйл ажиллагааны орлогоос хоршооны эд хөрөнгөд үлдээхээр хуваарилсан хөрөнгө;

4) хандив, тусламж.

2. Хоршооны эд хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжид зааснаар зохих бүртгэлтэй байх бөгөөд түүнийг гишүүн тус бүрийн нэр дээр хуваарилан дараахь байдлаар давхар бүртгэнэ:

1) гишүүний нийлүүлсэн хувь хөрөнгийг үнийн дүнгээр болон биет байдлаар;

2) хоршооны эд хөрөнгөд үлдээхээр хуваарилсан хөрөнгийг гишүүдэд орлого хуваарилах журмаар тооцсон үнийн дүнгээр;

3) хандив, тусламжийг гишүүдэд тэнцүү хуваасан үнийн дүнгээр.

3. Хоршооны эд хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийж болно.

4. Хоршооны эд хөрөнгийг бүх гишүүдийн хурлаар тогтоосон зориулалтаас өөрөөр зарцуулах, зээлдүүлэхийг хориглоно.

5. Хоршооны эд хөрөнгө нь гишүүд дундаа хэсгээр өмчлөх өмчийн хэлбэртэй байна.

10 дугаар зүйл. Хоршооны орлого хуваарилах

1. Хоршоо орлогоо дүрмээр тогтоосон журмын дагуу бүх гишүүдийн хурлын шийдвэрээр гишүүдэд хуваарилна. Орлогоос хоршооны эд хөрөнгөд үлдээх эсэхийг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

2. Хоршоо орлогоо гишүүдэд хуваарилах шийдвэр гаргахдаа хөдөлмөрөөрөө хоршооны үйл ажиллагаанд оролцсон оролцоо, хоршоогоор үйлчлүүлсэн байдал, нийлүүлсэн хувь хөрөнгийн хэмжээг харгалзан үзнэ.

11 дүгээр зүйл. Хоршооны эд хөрөнгийн хариуцлага түүнд гишүүдийн нөхөх хариуцлага

1. Хоршоо үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцна.

2. Хоршооны эд хөрөнгө тухайн үүргийг хариуцахад хүрэлцэхгүй бол гишүүд өөрийн эд хөрөнгөөр бүрэн нөхөж хариуцна. Гишүүн бүрт ногдох нөхөх хариуцлагын хэмжээг гишүүдэд орлого хуваарилах зарчмыг харгалзан тогтооно.

12 дугаар зүйл. Хоршооны гадаад харилцаа

Хоршоо нь эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцож болно.

13 дугаар зүйл. Хоршооны хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хөлс

1. Хоршоонд ажиллаж байгаа хоршооны гишүүн иргэний хөдөлмөрийн харилцаа нь энэ хууль болон хоршооны дүрмээр зохицуулагдана.

2. Хоршоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гишүүн бус иргэний хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

14 дүгээр зүйл. Хоршооны гишүүн иргэн, ажиллагчдын нийгмийн даатгал

1. Хоршоонд ажиллаж байгаа хоршооны гишүүн иргэн нь нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдана.

2. Хоршоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэн хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалд заавал хамрагдана.

15 дугаар зүйл. Хоршооны нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл

Хоршоо хууль тогтоомжийн дагуу хоршооны эд хөрөнгө, түүний эх үүсвэр болон үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний санхүүгийн үр дүн, мөнгөн хөрөнгийн хөдөлгөөний талаар нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан тэнцэл гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

Хоршооны гишүүн

16 дугаар зүйл. Хоршоонд гишүүнээр элсэх

1. Дор дурдсан тохиолдолд хоршооны гишүүнээр элссэнд тооцно:

1) хоршоог үүсгэн байгуулагчид бүртгэх байгууллагад бүртгүүлсэн;

2) хоршоонд гишүүнээр элссэн тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр гарсан;

3) хуульд заасан бусад үндэслэл.

2. Хоршоонд гишүүнээр элсэх асуудлыг бүх гишүүдийн хурал буюу удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

3. Хоршоо бүх гишүүдийн бүртгэлтэй байна. Бүртгэлд гишүүн бүрийн овог, нэр, оршин сууж байгаа байнгын хаяг, гишүүний нийлүүлсэн хувь хөрөнгө, түүний төлөгдсөн байдал, хоршооны орлогоос болон бусад эд хөрөнгөөс хуваарилсан хэмжээг бүртгэнэ.

17 дугаар зүйл. Хоршооны гишүүний эрх

Хоршооны гишүүн дараахь эрх эдэлнэ:

1) хоршооны орлогоос энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хуваарилан авах;

2) хоршооны ажил хэргийг удирдахад биечлэн оролцох;

3) хоршооны үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл авах;

4) хоршооны гүйцэтгэх байгууллага болон хяналтын зөвлөлд сонгох, сонгогдох;

5) хоршооноос гарах;

6) хууль тогтоомжид заасан бусад эрх.

18 дугаар зүйл. Хоршооны гишүүний үүрэг

Хоршооны гишүүн дараахь үүрэг хүлээнэ:

1) хоршооны дүрмийг дагаж мөрдөх;

2) хоршооны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх;

3) хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

19 дүгээр зүйл. Хоршооны гишүүнээс гарах, хасах

1. Гишүүн сайн дураар хоршооноос гарч болно. Энэ тухайгаа хоршоонд нэг сарын өмнө мэдэгдэж, хүсэлтээ бичгээр гаргана.

2. Гишүүн хоршооноос гарах тохиолдолд түүний гарсан өдрөөр тасалбар болгон холбогдох төлбөр, тооцоог хийж, гишүүний анх нийлүүлсэн хувь хөрөнгө, ногдох бусад эд хөрөнгийг тооцож, санхүүгийн тайлан батлагдсанаас хойш 3 сарын дотор олгоно.

3. Гишүүн хоршооноос гарахдаа биет байдлаар нийлүүлсэн хувь хөрөнгөө буцаан авах эрхтэй. Тухайн эд хөрөнгийг биет байдлаар буцаан олгох боломжгүй, эсхүл ийнхүү олгох нь хоршооны үйл ажиллагааг шууд зогсооход хүргэх тохиолдолд түүний зөвшөөрснөөр тухайн үеийн үнээр тооцож олгоно. Хэрэв зөвшөөрөхгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

4. Хоршооны гишүүнийг дүрэмд заасан үндэслэлээр бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хасаж болно. Гишүүнийг хоршооноос хасах тохиолдолд түүнд анх нийлүүлсэн хувь хөрөнгийг энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар олгоно. Түүнд ногдох бусад эд хөрөнгийг олгох эсэхийг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл. Хоршооны гишүүнд хүлээлгэх хариуцлага

1. Хоршооны дүрмийг зөрчсөн гишүүнд дүрэмд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Хоршооны гишүүнээс хоршоонд учруулсан эд хөрөнгийн хохирлыг дүрэм болон хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ.

Хоршооны удирдлагын зохион байгуулалт

21 дүгээр зүйл. Хоршооны бүх гишүүдийн хурал

1. Хоршооны удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал мөн.

2. Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

3. Дор дурдсан асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ:

1) хоршооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

2) хоршооны удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, хоршооны даргыг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэлт өгөх;

3) хоршооны эд хөрөнгийг захиран зарцуулах талаархи хоршооны даргын эрх хэмжээг тогтоох;

4) Гишүүн элсүүлэх, гишүүнээс гарах, хасах;

5) хоршооны эд хөрөнгийг захиран зарцуулах зориулалтыг тогтоох;

6) гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгийг буцааж олгох;

7) хоршооны тайлан тэнцлийг баталж, орлогыг хуваарилах;

8) дундын хоршоо байгуулах, холбоонд эвлэлдэн нэгдэх;

9) хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох;

10) удирдах зөвлөл байгуулаагүй бол энэ хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 4-т заасан асуудал;

11) дүрэмд заасан бусад асуудал.

4. Гишүүдийн дийлэнх олонхи оролцож байвал бүх гишүүдийн хурлыг хүчинтэйд тооцно.

5. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг удирдах болон хяналтын зөвлөл (хянан шалгагч)-ийн, удирдах зөвлөл байгуулаагүй тохиолдолд хоршооны даргын санаачилга, түүнчлэн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн шаардлагаар хуралдуулна.

6. Бүх гишүүдийн хуралд хэлэлцэх асуудлыг гишүүдэд хурал эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

7. Хуралд хэлэлцэхээр товлоогүй асуудлыг зөвхөн бүх гишүүн хуралд оролцож байгаа тохиолдолд тэдний олонхийн зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

8. Бүх гишүүдийн хурлаас удирдах болон хяналтын зөвлөл, хоршооны даргыг сонгох, чөлөөлөх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох тухай асуудлыг дийлэнх олонхийн саналаар, дүрэмд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9. Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг тухайн хоршооны гүйцэтгэх байгууллага, хяналтын зөвлөл, гишүүн бүр биелүүлэх үүрэгтэй.

10 Бүх гишүүдийн хурлын шийдвэрийн бүртгэлийг хоршооны дарга хөтөлнө.

11. Бүх гишүүдийн хуралд гишүүн бүр нийлүүлсэн хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамааран нэг саналын эрх эдэлнэ.

22 дугаар зүйл. Хоршооны гүйцэтгэх байгууллага

1. Хоршооны гүйцэтгэх эрх мэдлийг бүх гишүүдийн хурлаас сонгосон удирдах зөвлөл болон хоршооны дарга хэрэгжүүлнэ.

2. Удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хоршооны эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;

2) хоршооны удирдлагын аппаратын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалин, урамшууллын журмыг батлах;

3) бүх гишүүдийн хурлаас баталсан зориулалтын дагуу хөрөнгийг захиран зарцуулах;

4) хоршооны боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх;

3. Хоршооны дарга дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1) хоршооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, удирдах зөвлөлд танилцуулах;

2) бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хязгаарласнаас бусад асуудлаар хоршоог төлөөлөх, итгэмжлэл олгох;

3) хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай хоршоог төлөөлөн гэрээ байгуулах;

4) хоршооноос гарсан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

5) дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

4. Хоршооны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог болон гишүүдийн тооноос хамаарч удирдах зөвлөл байгуулахгүйгээр зөвхөн хоршооны даргыг сонгож болно.

5. Удирдах зөвлөл байгуулаагүй тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бүрэн эрхийг хоршооны дарга хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл. Хяналтын зөвлөл

1. Хоршооны гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих бүрэн эрх бүхий хяналтын зөвлөлийг хоршооны гишүүний тоо, үйл ажиллагааны хүрээ, онцлогийг харгалзан 3-аас доошгүй гишүүнтэйгээр бүх гишүүдийн хурлаас сонгоно.

2. Хоршооны удирдах албан тушаалтан (хоршооны дарга, удирдах зөвлөлийн гишүүд), түүнчлэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдыг хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохгүй.

3. Хяналтын зөвлөл жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хэдийд ч хуралдаж болно.

4. Хяналтын зөвлөл илэрсэн дутагдлыг тухай бүр нь удирдах болон гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авахыг шаардах эрхтэй.

5. Удирдах зөвлөлийн хуралд хяналтын зөвлөлийн гишүүд зөвлөх эрхтэй оролцоно.

6. Хяналтын зөвлөл хоршооноос санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон аливаа мэдээ, материалыг саадгүй гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүнийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.

7. Хяналтын зөвлөл тухайн жилийн санхүүгийн тайлан, орлого, алдагдлыг хуваарилах саналын талаар дүгнэлт гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлнэ.

8. Хоршооны гишүүдийн тоо цөөхнөөс шалтгаалан хяналтын зөвлөл байгуулахгүйгээр 1 хянан шалгагчийг сонгон ажиллуулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох

24 дүгээр зүйл. Хоршооны үйл ажиллагааг өөрчлөн байгуулах

1. Хоршоог өөрчлөн байгуулах (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах) тохиолдолд бүртгэх байгууллагад мэдэгдэж, хоршооны дүрэм, бүртгэлд зохих өөрчлөлт хийлгэнэ.

2. Хоршоог өөрчлөн байгуулах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий өөрчлөн байгуулах комиссыг бүх гишүүдийн хурлаас томилно.

3. Хоршоог өөрчлөн байгуулах комисс энэ хуулийн 25 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл. Хоршоог татан буулгах

1. Хоршоог дор дурдсан тохиолдолд татан буулгана:

1) үйл ажиллагаа явуулахаар тогтоосон хугацаа дууссан, эсхүл байгуулагдсан зорилгодоо хүрсэн учраас цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэр гарсан;

2) дампуурлыг зарласан, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

2. Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгаж байгаа бол тухайн хурлаас татан буулгах комисс томилно.

3. Татан буулгах комисс хоршоо татан буугдсан тухай нийтэд мэдээлж, татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

4. Татан буулгах комисс хоршооны эд хөрөнгийг үнэлж, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд заасан дарааллаар харилцагчдын нэхэмжлэл хангах ажиллагааг гүйцэтгэн, дуусгалтын тайлан тэнцлийг гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлнэ.

5. Татан буулгах комисс эцсийн тооцоо хийж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг энэ хууль болон хоршооны дүрэмд заасан нөхцөл, журмаар хоршооны гишүүдэд хуваана.

26 дугаар зүйл. Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцогдох

Хоршооны үйл ажиллагааг өөрчлөн байгуулсан болон хоршоог татан буугдсан тухай улсын бүртгэлд бүртгэснээр тухайн хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцогдоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Үйлдвэрлэл, үйлчилгээний болон хэрэглэгчдийн хоршоо, дундын хоршоо, холбоонд эвлэлдэн нэгдэх

27 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний хоршоо

Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний хоршоонд бүх гишүүн хөдөлмөрөө холршин, шаардлагатай бол эд хөрөнгөө нэгтгэж, биечлэн хөдөлмөрлөх замаар оролцоно.

28 дугаар зүйл. Хэрэглэгчдийн хоршоо

1. Хэрэглэгчдийн хоршоонд гишүүд хөрөнгөө нэгтгэж, хөдөлмөрөө хоршин, гишүүдийнхээ хэрэгцээг хангахыг гол зорилго болгоно. Дүрэмд заасан бол гишүүн биш этгээдэд үйлчилж орлогоо нэмэгдүүлж болно.

2. Хэрэглэгчдийн хоршоонд эд хөрөнгөө нэгтгэсэн гишүүн тухайн хоршоонд биечлэн хөдөлмөрлөхгүй байж болно.

29 дүгээр зүйл. Дундын хоршоо

1. Хоршоод аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран явуулах, харилцан туслах зорилгоор дундын хоршоо байгуулж болно.

2. Дундын хоршооны эд хөрөнгө нь гишүүн хоршооноос дундын хоршооны эд хөрөнгөд нийлүүлсэн хувь хөрөнгөтэй хувь тэнцүүгээр хоршоодод хуваагдана. Энэ тухай гишүүн хоршооны бүртгэлд бүртгэнэ.

3. Дундын хоршооны эд хөрөнгө нь хоршоод дундаа хэсгээр өмчлөх өмчийн хэлбэртэй байна.

30 дугаар зүйл. Хоршоод эвлэлдэн нэгдэх

Үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн буюу бусад шинжийг үндэслэн үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллага, түүнчлэн олон улсын байгууллагад төлөөлүүлэх зорилгоор хоршоод нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу эвлэлдэн нэгдэж холбоо байгуулж болно. Энэ нь

ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэртэй байна. Энэхүү хуулийн этгээдийн үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл.

31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1) дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх журмыг зөрчсөн албан тушаалтныг бүртгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан 2000-20000 төгрөгөөр торгох;

2) дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан бол шүүгч олсон орлогыг хурааж, хоршоог 100000-250000 төгрөгөөр торгох.

3) энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зааltыг зөрчсөн албан тушаалтныг шүүгч 30000-50000 төгрөгөөр торгох;

4) энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 2, 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зааltыг зөрчиж, өөрчлөн байгуулах буюу татан буулгах комисс томилоогүй бол хоршоог шүүгч 50000-150000 төгрөгөөр торгох;

5) өөрчлөн байгуулах буюу татан буулгах комисс нь энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 3, 4, 5 дахь хэсэгт заасан зааltыг зөрчсөн бол комиссын дарга, гишүүдийг шүүгч 30000-50000 төгрөгөөр торгох;

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан зааltыг удаа дараа зөрчсөн бол хоршоог татан буулгахаар шүүх шийдвэрлэж болно.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн ургамал /цаашид "ургамал" гэх/ ашигласны төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж

Ургамал ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Байгалийн ургамлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төлбөр төлөгч

1. Ургамал ашиглагч Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлөгч байна.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Байгалийн ургамлын тухай хуульд заасны дагуу ургамал ашиглах зөвшөөрөл авна.

4 дүгээр зүйл. Төлбөр ногдох зүйл.

Төлбөр төлөгчийн бэлтгэж ашигласан дараахь ургамалд төлбөр ногдуулна:

1/ нэн ховор ургамал;

2/ ховор ургамал;

3/ элбэг ургамал.

5 дугаар зүйл. Төлбөр тооцох үзүүлэлт

Ургамал ашигласны төлбөрийн хэмжээг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгжээр тооцно.

6 дугаар зүйл. Төлбөрийн хэмжээ

1. Төлбөрийн хэмжээг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараахь хязгаарт багтаан төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн : ургамал :	Төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид ногдуулах төлбөрийн хязгаар /төг-өөр/	
:	доод :	дээд
1. Нэн ховор	300	1000
2. Ховор	150	500
3. Элбэг	50	300

2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтэний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

7 дугаар зүйл. Төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

1. Дор дурдсан зориулалт, хэрэгцээгээр ургамал ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

1/ элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэн;

2/ ховор болон элбэг ургамлыг шинжилгээ судалгааны зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

3/ байгалийн ургамлыг хадлан, бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

2. Ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болно. Төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

8 дугаар зүйл. Төлбөр төлөх, тайлагнах

1. Сум, дүүргийн Засаг дарга ургамал ашигласны төлбөрийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

2. Төлбөр төлөгч ургамал ашиглах зөвшөөрлийн эрхийн бичиг авах тухай бүрдээ төлбөрийг бэлнээр сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтанд, эсхүл бэлэн бусаар сум, дүүргийн төсөвт тус тус төлнө.

3. Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бэлнээр хураасан төлбөрийг тухай бүр сум, дүүргийн төсөвт оруулна.

4. Ургамал ашигласны төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

1/ сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан бэлэн болон бэлэн бусаар төсөвт оруулсан төлбөрийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор сум, дүүргийн татварын албанд;

2/ сум, дүүргийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

3/ аймаг, нийслэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор Улсын татварын ерөнхий газарт;

4/ Улсын татварын ерөнхий газар төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

5. Төлбөрийн тайлангийн маягтын загварыг Улсын татварын ерөнхий газар батална.

9 дүгээр зүйл. Төлбөрийг буцаан олгох

Төлбөр төлөгчийн төлсөн төлбөрийг дараахь тохиолдолд буцааж олгоно:

1/ тогтоосон хэмжээнээс илүү төлсөн;

2/ зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтан зөвшөөрлөө хүчингүй болгосон.

10 дугаар зүйл. Төлбөрийн талаар гомдол гаргах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөртэй холбогдсон гомдлоо төлбөр төлснөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргана. Зохих шатны татварын албаны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

11 дүгээр зүйл. Ургамал ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр хураах эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

1/ төлбөрийг аваагүй буюу дутуу авсан, төлбөрийн данс, баримтыг будлиантуулсан, бэлнээр хураасан төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Энэ хуульд заасан төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын татварын алба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр /цаашид "төлбөр" гэх/-ийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Ойн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх

1. Монгол Улсын төрийн өмчийн ойн нөөцөөс аливаа зориулалтаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашиглаж байгаа Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлөгч байна.

2. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглах зөвшөөрөл олгох асуудлыг Ойн тухай хуулиар зохицуулна.

3. Сум, дүүргийн Засаг дарга ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр хураах эрх бүхий ажилтныг томилон ажиллуулна.

4. Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан хэрэглээний мод, түлээ бэлтгэх ажлыг байнга эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын талаархи мэдээллийг зөвшөөрөл олгосноос хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгнө. Татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

5. Мэдээлэлд ойн нөөц ашиглах аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, ойн нөөцийн байршил, ашиглах хугацаа, хэмжээ зэрэг татварын хяналтад шаардлагатай үзүүлэлтийг тусгана.

4 дүгээр зүйл. Төлбөр ногдох зүйл.

Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулна.

5 дугаар зүйл. Төлбөр тооцох үзүүлэлт

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг дор дурдсан үзүүлэлтээр тооцно:

1/ ургаа мод огтолж, түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоометрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоометрээр;

2/ ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоометрээр;

3/ иргэн заг түүж түлш бэлтгэхэд тонноор.

6 дугаар зүйл. Төлбөрийн хэмжээ

1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээнээс энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасан хэрэглээний модонд 6,0-30,0 хувь, мөн зүйлийн 1, 2, 3-т заасан түлээнд 2,0-10,0 хувиар тооцно.

2. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг ойн нөөцийн экологи- эдийн засгийн үнэлгээ, бэлтгэж тээвэрлэх зай, модны төрлийг харгалзан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаарт багтаан Засгийн газар ойн мужлал бүрээр ялгавартай тогтооно.

3. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагын мод тээврийн зайг мод бэлтгэлийн талбайгаас доод агуулах хүртэл, ийм агуулахгүй бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрсөн цэг хүртэл, ийм төвлөрсөн цэггүй бол уг мод бэлтгэсэн талбайд хамгийн ойр орших сумын буюу аймгийн төв хүртэлх зайгаар тус тус тооцно.

4. Аж ахуйн нэгж, байгууллага хуш модыг түсгай зөвшөөрлөөр бэлтгэх тохиолдолд түүнд тухайн ойн бүс нутагт шинэс мод бэлтгэж ашиглахад ногдуулдаг төлбөрийг 3 дахин өсгөсөнтэй тэнцүү хэмжээний төлбөр ногдуулна.

7 дугаар зүйл. Төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

1. Дараахь зориулалтаар ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

1/ ойжуулалтын талбай болон булаг шандын эхийг хамгаалах;

2/ хилийн бүсийн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч өөрийн албан ажлын байр барих.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр,, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болно. Хөнгөлөлтийн хувь хэмжээг Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл. Төлбөр төлөх, тайлагнах

1. Хэрэглээний мод, түлээ бэлтгэх ажлыг байнга эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрлийн дагуу бэлтгэх модны төрөл, хэмжээнд ногдож төлбөрийг улирал бүрийн эцсийн сарын 25-ны дотор сум, дүүргийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг орон нутаг дахь байгаль орчны асуудал эрхэлсэн албан тушаалтнаар хянуулан дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, эцсийн тооцоо хийнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг эрхийн бичиг авах бүрдээ сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтанд бэлнээр, эсхүл сум, дүүргийн төсөвт бэлэн бусаар тус тус төлнө.

3. Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бэлнээр хураан авсан төлбөрийг тухай бүр сум, дүүргийн төсөвт оруулна.

4. Хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

1/ сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан элэн болон бэлэн бусаар сум, дүүргийн төсөвт оруулсан төлөөрийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор сум, үүргийн татварын албанд;

2/ сум, дүүргийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны отор аймаг, нийслэлийн татварын албанд;

3/ аймаг, нийслэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний отор Улсын татварын ерөнхий газарт;

4/ Улсын татварын ерөнхий газар төлбөрийн улсын нэгдсэн айланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

5. Төлбөрийн тайлангийн маягтын загварыг Улсын татварын ерөнхий газар батална.

9 дүгээр зүйл. Төлбөрийг буцаан олгох

1. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төлсөн төлбөрийг дараахь тохиолдолд буцаан олгоно:

1/ тогтоосон хэмжээнээс илүү төлсөн;

2/ зөвшөөрөл, эрхийн бичиг олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олгосон зөвшөөрлөө хүчингүй болгосон.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг буцаан олгох асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Төлбөрийн талаар гомдол гаргах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөртэй холбогдсон гомдлоо төлбөр төлснөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргана. Зохих шатны татварын албаны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

11 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр хураах эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

1/ төлбөрийг аваагүй буюу дутуу авсан, төлбөрийн данс, баримтыг будлиантуулсан, бэлнээр хураасан төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Энэ хуульд заасан төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын татварын алба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус, рашаан ашигласны төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж

Ус, рашаан ашигласны төлбөр /цаашид "төлбөр" гэх/-ийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Усны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх

1. Ус, рашаан, тэдгээрийн орчинг аливаа зориулалтаар ашиглаж байгаа Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлөгч байна.

2. Ус, рашаан ашиглагчдад зөвшөөрөл олгох асуудлыг Усны тухай Монгол Улсын хуулиар зохицуулна.

3. Ус, рашаан ашиглах зөвшөөрөл олгогч нь ус, рашааны нөөцийг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын талаархи мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногт багтаан татварын албанд гаргаж өгнө. Татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

4. Мэдээлэлд ус, рашаан ашиглах аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, ус, рашааны байршил, ашиглах хугацаа, тоног төхөөрөмжийн хүч чадал зэрэг татварын хяналтад шаардлагатай үзүүлэлтийг тусгана.

4 дүгээр зүйл. Төлбөр ногдох зүйл.

1. Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан, тэдгээрийн орчин байна:

1/ хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;

2/ эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;

3/ эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.

5 дугаар зүйл. Усны нөөцийн үнэлгээг тогтоох

Усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

6 дугаар зүйл. Төлбөр тооцох үзүүлэлт

1. Ус, усан орчин ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараахь байдлаар тодорхойлно:

1/ усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс;

2/ хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усыг шоометрээр;

2. Рашаан ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараахь байдлаар тодорхойлно:

1/ эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашигласны төлбөрийг эмчлэн сувилуулсан хүн-хоногийн тоогоор;

2/ үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласны төлбөрийг шоометрээр;

3/ халааltын зориулалтаар ашигласны төлбөрийг эзлэхүүнээр.

7 дугаар зүйл. Төлбөрийн хувь, хэмжээ

1. Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараахь хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох ус	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар			
		Гадаргын болон гар худгийн усанд		Газрын доорхи усанд	
		доод	дээд	доод	дээд
1. Усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамирын зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс	хувь	0,1	0,5	-	-
2. Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	төг	-	-	1,00	10,00
3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	төг	1,00	5,00	1,00	20,00

2. Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараахь хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох рашаан	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/			
		Халуун		Хүйтэн	
		доод	дээд	доод	дээд
1. Эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглахад	хүн-хоног	10	50	5	40
2. Үйлдвэрлэлийн үндсэн болон туслах түүхий эд болгон ашиглахад	шоо-метр	500	1500	1000	3000

3. Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаарт багтаан Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

4. Халуун рашааныг үндсэн ашиглалтад нь нөлөө үзүүлэхгүйгээр халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хувиар тогтооно.

5. Байгалийн халуун усыг халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хүртэл хувиар, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашиглавал ус ашигласны төлбөрийн 50 хүртэл хувиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

6. Энэ зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасан төлбөрийн хувь, хэмжээг ус, рашааны нөөц, чанар, ашиглалтын хэлбэр, зориулалтыг харгалзан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, онцлогтой уялдуулан ялгавартай тогтооно.

8 дугаар зүйл. Төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

1. Дараахь зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

1/ хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

2/ түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

3/ усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

2. Дараахь зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийн төлбөрийг Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр хөнгөлж болно:

1/ усны эрдэсжилт, хатуулгийг нь цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан;

2/ ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх.

9 дүгээр зүйл. Төлбөр ногдуулах, төлөх, тайлагнах

1. Усны нөөцийг зохих зөвшөөрлийн дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа төлбөр төлөгч ашигласан усны хэмжээг хэмжих хэрэгслийн заалтаар, хэмжих хэрэгсэлгүй бол олборлох байгууламж, тоног төхөөрөмжийн хүч чадал буюу нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээг үндэслэн тооцож тухайн сард ногдох төлбөрийг өөрөө тодорхойлж дараа сарын 10-ны дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд тушааж, эцсийн тооцоо хийнэ.

2. Рашааны нөөцийг байнга ашиглах зөвшөөрөл бүхий төлбөр төлөгч нь эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашигласан рашааны төлбөрийн хэмжээг эмчилгээ, сувилгаа хийлгэсэн хүн-хоногийн бүртгэлээр, халаалтад зориулан ашигласан рашааны төлбөрийн хэмжээг халаасан эзлэхүүний хэмжээгээр, үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашигласан рашааны хэмжээг хэмжих хэрэгслийн заалтаар, хэмжих хэрэгсэлгүй бол олборлох байгууламж, тоног төхөөрөмжийн хүч чадал буюу нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээг үндэслэн тооцож тухайн сард ногдох төлбөрийг өөрөө тодорхойлон, дараа сарын 10-ны дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд тушааж, эцсийн тооцоо хийнэ.

3. Эмчлэн анагаах чанар, бүтэц найрлага нь тогтоогдсон орон нутгийн хэмжээнд байнга ашиглагддаг рашааны нөөцийг хувийн журмаар ашиглах иргэн эмчилгээ, сувилгаанд байх хоногт ногдох төлбөрийг бэлнээр сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтанд, эсхүл бэлэн бусаар орон нутгийн төсөвт тус тус төлнө.

4. Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бэлнээр хураасан төлбөрийг тухай бүр сум, дүүргийн төсөвт оруулна.

5. Ус, рашааны нөөц, тэдгээрийн орчинг ашигласны төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана.

1/ сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан бэлэн болон бэлэн бусаар төсөвт оруулсан төлбөрийн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор сум, дүүргийн татварын албанд;

2/ сум, дүүргийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

3/ аймаг, нийслэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор Улсын татварын ерөнхий газарт;

4/ Улсын татварын ерөнхий газар төлбөрийн улсын нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

6. Төлбөрийн тайлангийн маягтын загварыг Улсын татварын ерөнхий газар батална.

10 дугаар зүйл. Төлбөрийг буцаан олгох

1. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төлсөн төлбөрийг дараахь тохиолдолд буцаан олгоно:

1/ тогтоосон хэмжээнээс илүү төлсөн;

2/ хүндэтгэн үзэх шалтгаанаар рашаан ашиглах боломжгүй болсон.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан төлбөр төлөгчид төлбөрийг буцаан олгох асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Төлбөрийн талаар гомдол гаргах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөртэй холбогдсон гомдлоо төлбөр төлснөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргана. Зохих шатны татварын албаны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

12 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр хураах эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

1/ төлбөрийг аваагүй буюу дутуу авсан, төлбөрийн данс, баримтыг будлиантуулсан, хураан авсан төлбөрийг төсвийн орлогод

тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Энэ хуульд заасан төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын татварын алба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина.

14 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан, шувуу, загас /цаашид ан "амьтан" гэх/ агнах, барих, зөвшөөрлийн хураамж ногдуулах, уг төлбөр, хураамжийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль тогтоомж

Агнуурын нөөц ашигласны төлбөр /цаашид "төлбөр" гэх/ ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж /цаашид "хураамж" гэх/-ийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Ан агнуурын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төлбөр, хураамж төлөгч, түүнийг бүртгэх

1. Дор дурдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр, хураамж төлөгч байна:

1/ ан амьтныг үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих болон амьдаар нь барьж гадаад оронд гаргах аж ахуйн нэгж, байгууллага;

2/ ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж ашиглах болон төрөөс худалдан авч өмчлөх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

3/ ан амьтныг тусгай зөвшөөрөлтэйгээр агнах, барих гадаадын иргэн.

2. Дор дурдсан иргэн хураамж төлөгч байна:

1/ ахуйн зориулалтаар ан амьтныг агнах, барих Монгол улсын иргэн;

2/ ахуйн зориулалтаар загас барих Монгол улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох асуудлыг Ан агнуурын тухай хуулиар зохицуулна.

4. Агнуурын нөөц ашиглах үйл ажиллагааг байнга эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн татварын албанд бүртгүүлнэ.

4 дүгээр зүйл. Төлбөр, хураамжийг тооцох үзүүлэлт

1. Төлбөрийг дараахь үзүүлэлтээр тооцно:

1/ үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограммаар;

2/ ан амьтныг амьдаар нь барьж эзэмшин, гаршуулан үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоор;

3/ ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

4/ гадаадын иргэнд агнуулсан болон гадаад оронд амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр.

2. Хураамжийг дараахь үзүүлэлтээр тооцно:

1/ ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих иргэнээс хураамжийг нэг удаагийн эрхийн бичгээр;

2/ иргэний ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны хураамжийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр.

3/ энэ хэсгийн 1, 2-д зааснаас бусад зориулалтаар ан амьтныг агнах, барих зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээгээр.

5 дугаар зүйл. Төлбөр, хураамжийн хэмжээ

1. Агнуурын нөөц ашигласны төлбөрийн дээд, доод хязгаарыг дараахь байдлаар тогтооно:

1/ үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограмм тутамд 20-30 төгрөгөөр;

2/ үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

3/ ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг уг түүхий эдийн борлуулалтын орлогын 10-20 хувиар;

4/ ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 90-100 хувиар;

5/ гадаадын иргэнд агнуулсан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 60-70 хувиар;

6/ амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.

2. Ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн дээд, доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

1/ ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийг нэг удаагийн эрхийн бичигт 400-600 төгрөг;

2/ ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний

20-40 хувиар;

3/ энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-д заасан ан амьтныг агнах, барих зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 2-4 хувиар;

4/ энэ зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан ан амьтныг агнах зөвшөөрлийн хураамжийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 20-30 хувиар;

5/ энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасан ан амьтныг барих зөвшөөрлийн хураамжийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 5-8 хувиар.

3. Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ, ан олзворын жишиг үнэ, түүнчлэн агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тодорхой хувь хэмжээг тухайн ан амьтны нөөц, тархац, экологи-эдийн засгийн ач холбогдол, эрэлт хэрэгцээ, зориулалтыг харгалзан энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.

6 дугаар зүйл. Төлбөр хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх

1. Төлбөр, хураамжаас дараахь тохиолдолд чөлөөлнө:

1/ ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;

2/ халдварт өвчний голомтыг устгах зорилгоор эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ан амьтныг мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;

3/ мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;

4/ сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлөх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээний зориулалтаар түр барих.

2. Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөр, хураамжийг хөнгөлж болно. Төлбөр, хураамжийг хөнгөлөх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

7 дугаар зүйл. Төлбөр, хураамж төлөх, тайлагнах, зарцуулах

1. Төлбөр, хураамжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ан амьтныг агнах, барих гэрээ хийх, тусгай зөвшөөрөл, эрхийн

бичиг авах бүрдээ бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлнө.

2. Ан амьтныг үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж барьснаас болон энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-д зааснаас бусад төлбөр, хураамжийг ан амьтан агнах, барих гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох эрх бүхий байгууллагын шийдвэрээр томилогдсон албан тушаалтан хурааж авна.

3. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6-д болон 2 дахь хэсгийн 4, 5-д заасан төлбөр, хураамжийг гадаадын иргэнд ан амьтан агнуулах болон ан амьтанг амьдаар гадаад оронд гаргах аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлнө. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь уг төлбөр, хураамж зохих дансанд орсноос хойш хуанлийн 15 хоногт багтаан төлбөрийг төвлөрсөн төсөвт, хураамжийг холбогдох сум, дүүргийн төсөвт тус тус шилжүүлнэ.

4. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-д болон 2 дахь хэсгийн 1-3-д заасан төлбөр, хураамжийг сум, дүүргийн төсөвт төлнө. Төлбөр, хураамж хураах эрх бүхий албан тушаалтан төлбөр, хураамжийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

5. Ан амьтныг үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих болон амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж ашиглах аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-д заасан төлбөрийн улирлын хэмжээг өөрөө тодорхойлон, дараа улирлын эхний сарын 10-ны дотор сум, дүүргийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, эцсийн тооцоо хийнэ.

6. Төлбөр, хураамжийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

1/ ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох, төлбөр, хураамж хураан авах эрх бүхий байгууллага, албан тушаалтан төлбөр, хураамжийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд;

2/ сум, дүүргийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

3/ аймаг, нийслэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор Улсын татварын ерөнхий газарт;

4/ Улсын татварын ерөнхий газар төлбөр, хураамжийн улсын нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

7. Төлбөр, хураамжийн тайлангийн маягтын загварыг Улсын татварын ерөнхий газар батална.

8. Төлбөр, хураамжийн зохих хувийг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах арга хэмжээнд зориулан зарцуулж болно.

9. Төвлөрсөн төсөвт орсон төлбөрийн 10 хувийг байгаль хамгаалах санд төвлөрүүлнэ.

8 дугаар зүйл. Төлбөрийг буцаан олгох

1. Төлбөрийг дараах тохиолдолд буцаан олгоно:

1/ төлбөл зохих хэмжээнээс илүү төлсөн;

2/ агнуур хийх нутаг дэвсгэрт хүн, мал, амьтны халдварт өвчин гарсны улмаас хорио цээр тогтоогдож, агнуур хийх боломжгүй болсон;

3/ хууль, гэрээнд заасан бусад нөхцөл.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийг буцаан олгох асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

9 дүгээр зүйл. Төлбөр, хураамжийн талаар гомдол гаргах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр, хураамжтай холбогдсон гомдлоо төлбөр, хураамж төлснөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргана. Зохих шатны татварын албаны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

10 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр, хураамж хураах эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараах шийтгэл ногдуулна:

1/ төлбөр, хураамжийг аваагүй буюу дутуу авсан, төлбөр, хураамжийн данс бүртгэл, баримтыг будлиантуулсан, хураан авсан төлбөр, хураамжийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Энэ хуульд заасан төлбөр, хураамж төлөгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг Татварын ерөнхий хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын татварын алба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина.

12 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. "Үйлдвэрийн газарт хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн эрхийг хамгаалах ба тэдэнд бололцоо олгох тухай" Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1971 оны 135 дугаар конвенцид Монгол Улс нэгдэн орсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар

хоорондын хэлэлцээр"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 14-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"14/ автобензин, дизелийн түлшний албан татвар;"

Хоёрдугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "1-13-т" гэснийг "1-14-т" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "14-19-д" гэснийг "15-19-д" гэж тус тус өөрчилсүгэй.

Гуравдугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь автобензин, дизелийн түлшинд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль тогтоомж

Автобензин, дизелийн түлшний албан татвар /цаашид энэ хуульд "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Албан татвар төлөгч

Монгол Улсын нутаг дэвсгэрт автобензин, дизелийн түлш импортлон оруулж байгаа өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага болон Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/ албан татвар төлөгч байна.

4 дүгээр зүйл. Албан татвар ногдох автобензин, дизелийн түлш

Дараахь автобензин, дизелийн түлшинд албан татвар ногдуулна:

1/ бүх төрлийн автобензин;

2/ бүх төрлийн дизелийн түлш.

5 дугаар зүйл. Албан татвар тооцох үзүүлэлт

Албан татвар тооцох үзүүлэлтийг энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан импортын автобензин, дизелийн түлшний биет хэмжээгээр тодорхойлно.

6 дугаар зүйл. Албан татварын хэмжээ

Албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан албан татвар тооцох үзүүлэлтийн тонн тутамд дараахь хэмжээгээр ногдуулна.

Албан татвар ногдуулах автобензин, дизелийн түлш	Нэг тоннд ногдуулах албан татварын хэмжээ /төгрөгөөр/
1. Автобензин	
90 хүртэл октантай	20350
90-ээс дээш октантай /шинжилгээний аргаар тодорхойлсноор/	25700
2. Дизелийн өвөл, зуны түлш	2140

7 дугаар зүйл. Албан татвар ногдуулах

Албан татварыг автобензин, дизелийн түлшийг Монгол Улсын хилээр оруулж ирсэн тухай бүрд энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хэмжээгээр гаалийн байгууллага ногдуулна.

8 дугаар зүйл. Албан татвар төлөх, тайлагнах

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь импортоор авсан автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг уг автобензин, дизелийн түлш Монгол Улсын хилээр орж ирсэн өдрөөс хойш хуанлийн 60 хоногийн дотор гаалийн байгууллагад төлнө.

2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн импортоор авсан автобензин, дизелийн түлшинд ногдсон албан татварын улирлын гайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаалийн байгууллагад гарган өгч албан татварын эцсийн тооцоо хийнэ.

3. Гаалийн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлсөн автобензин, дизелийн түлшний албан татварыг уг албан татвар дансанд орсноос хойш хуанлийн 3 хоногт багтаан улсын төвлөрсөн төсөвт шилжүүлнэ.

Энэхүү албан татварын орлогоос замын санд төвлөрүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

9 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй.

"3. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4-т заасан бараанд импортлон оруулж байгаа хилийн боомтоос хамааран, тонн тутамд дараахь хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна.

Хилийн боомт	Онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/		
	Автобензин /шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ/		Дизелийн түлш
	90 хүртэл	90-ээс дээш	
1. Цагааннуур, Ярант, Тэс, Хандгайт	1720	2030	3430
2. Ханх	4310	6010	5070
3. Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав	12940	15220	17180

2 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "1-д" гэснийг "1,4-т", 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "4 дүгээр зүйлд" гэснийг "4 дүгээр зүйлийн 1, 2-т" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "4" гэснийг, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дугаар заалтыг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 6-наас эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 13 дахь заалтын "хэрэг бүртгэлт" гэсний дараа "мөрдөн байцаалт" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэг, 125 дугаар зүйл, 192 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсэг, 231, 255 дугаар зүйл, 327 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 329 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 362, 368 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"Хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд, түүнчлэн өөр аймгийн буюу нийслэлийн шүүхэд Улсын дээд шүүхийн танхимын Тэргүүн шүүгчийн захирамжаар, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, түүнчлэн өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүхийн

харьяалал тогтоон шилжүүлнэ. Хэргийг шүүхийн харьяалал тогтоон шилжүүлсэн захирамжийн талаар гарсан маргааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч эцэслэн шийдвэрлэнэ."

2/72 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэг:

"Гэрч нь гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.

Энэ зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь өөрийн гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийн гэм буруутай үйлдлийн улмаас хохирсон хохирогчид нэгэн адил хамаарна."

3/125 дугаар зүйл:

"Эрүүгийн хуулийн 60-66, 67, 68, 70-74, 79-84, 291 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт Тагнуулын төв газрын мөрдөн байцаагч, бусад зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулна."

4/192 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсэг:

"Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үндэслэлээр түдгэлзүүлэх тогтоолыг хэрэг бүртгэгч, 1-4-т заасан үндэслэлээр түдгэлзүүлэх тогтоолыг мөрдөн байцаагч гаргана. Хэрэв хоёр буюу хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх сэжигтэн, яллагдагчид хамаарахгүй байвал зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлан түдгэлзүүлж болно.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,4-т заасан тохиолдолд мөрдөн байцаалтыг уг хэргийг мөрдөх хугацаа дуусмагц түдгэлзүүлнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан тохиолдолд мөрдөн байцаалтын хугацаа дуусахын өмнө түдгэлзүүлж болно. Сэжигтэн сэтгэл мэдрэлийн өвчтэй болох нь хэрэг бүртгэлтийн шатанд тогтоогдвол хэргийг түдгэлзүүлэх тухай асуудлыг мөрдөн байцаалтад шилжүүлсний дараа шийдвэрлэнэ.

Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийн байхгүйд гүйцэтгэж болох мөрдөн байцаалтын бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй."

5/231 дүгээр зүйл:

"231 дүгээр зүйл. Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах

Дор дурдсан тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана:

1/урьд сонсгосон ял дээр өөр ял нэмж сонсгох, эсхүл ялыг хүндрүүлэх;

2/уг хэрэгт холбогдуулан өөр этгээдийг эрүүгийн хариуцлагад татах үндэслэл байгаа бөгөөд түүний хэргийг тусгаарлах боломжгүй байх;

3/хэргийг буруу нэгтгэсэн буюу тусгаарласан;

4/яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн.

Шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаахдаа хэргийг буцааж байгаа үндэслэл, нэмж шалгах асуудлыг тодорхой зааж, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний асуудлыг шийдвэрлэсэн байвал зохино."

6/255 дугаар зүйл:

"255 дугаар зүйл. Шүүх хуралдаанаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох

Дор дурдсан тохиолдолд шүүх хуралдаанаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно:

1/Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан байдал тогтоогдвол;

2/ Энэ хуулийн 196 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан үндэслэл байвал;

3/яллагч энэ хуулийн 244 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан үндэслэлээр яллахаас татгалзсан бол.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,3-т дурдсан учир байдал Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд заасан хугацааны дотор арилсан бол шүүх хэргийг ердийн журмаар хэлэлцэнэ."

7/327 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"Дээр дурдсан хүмүүс давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлт гаргавал тэдэнд хэрэг хэлэлцэх өдөр, цаг, газрыг заавал мэдэгдэнэ. Оролцогчид шүүх хуралдаанд ирээгүй явдал нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй. Гэвч энэ тохиолдолд тэдгээрийн урьд өгсөн мэдүүлэг, гаргасан хүсэлт, саналыг заавал уншин сонсгоно."

8/329 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"Оролцогчид давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцож байгаа бол нарийн бичгийн дарга энэ хуулийн 105 дугаар зүйлд заасан журмыг баримтлан протокол үйлдэнэ. Протоколд засвар оруулах саналыг энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан журмаар гаргах буюу хэлэлцэнэ."

9/362 дугаар зүйл:

"362 дугаар зүйл. Хяналтын журмаар эсэргүүцэл бичих

Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолд; Улсын Дээд шүүхийн шүүгч сум буюу сум дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй.

Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй.

Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын Ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч бичсэн эсэргүүцлээ хяналтын журмаар хянан хэлэлцэхээс өмнө буцаан авч болно."

10/368 дугаар зүйл:

"368 дугаар зүйл. Хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэх

Хяналтын журмаар хэлэлцэх хэргийг шүүх хүлээн авснаас хойш 15 хоногоос хэтрүүлэхгүйгээр хянан хэлэлцэнэ.

Хяналтын шүүх хуралдаанд прокурор оролцох эрхтэй. Хэргийг хянасан шүүгч хуралдаанд илтгэнэ. Илтгэгч хэргийн байдал, таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоол болон эсэргүүцлийн агуулгыг танилцуулна. Хуралдаанд оролцож байгаа шүүгчид хэрэг илтгэгчид асуулт тавьж болно. Үүний дараа прокурор тухайн хэргийн талаар санал хэлнэ.

Дараа нь шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж тогтоол гаргана. Хэргийн талаар гарах тогтоолыг хуралдаанд оролцож байгаа шүүгчдийн олонхийн саналаар батлах бөгөөд хэрэв санал тэнцсэн бол эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгоно.

Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тогтоол эцсийн шийдвэр болно. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тогтоол хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч түүнд нэг удаа эсэргүүцэл бичиж хэлэлцүүлэх эрхтэй."

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дор дурдсан агуулгатай 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 58 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 196 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 244 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг , 254, 320, 321, 362 дүгээр зүйлийг тус тус нэмсүгэй.

1/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"Аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ."

2/42 дугаар зүйлийн 3 дах хэсэг:

"Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй бол дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар зохих шатны өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд олонхи шүүгч нь оролцож байгаа шүүхээр хэргийг хянан хэлэлцүүлнэ."

3/58 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт дурдсан журам Улсын дээд шүүхийн шүүгч хяналтын шүүх хуралдаанд оролцоход хамаарахгүй."

4/196 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар хэрэгсэхгүй болгосон хэргийн талаархи нотлох баримт Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд дурдсан хугацааны дотор шинээр илэрвэл дахин эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж болно."

5/244 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"Яллагч шүүх хуралд яллах дүгнэлт уншин сонсгохоос өмнө аль ч үед яллахаас татгалзаж болох боловч нэгэнт шүүхийн шинэчилсэн байцаалт эхэлсэн бол энэ хуулийн 289 дүгээр зүйлд заасан шүүх хуралдааны шүүмжлэлийн шатанд саналаа илэрхийлнэ."

6/254 дүгээр зүйл:

"254 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх саналыг яллагчид тавих

Мөрдөн байцаалт явуулахдаа нэг талыг барьсан буюу гүйцэт биш хийсэн, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөнөөс шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг бүрэн нотолж чадаагүй гэж шүүх хуралдааны явцад үзвэл шүүх хэргийг хянан хэлэлцэхийг 30 хүртэл хоногоор хойшлуулж, нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх саналыг яллагчид тавьж болно.

Энэ тохиолдолд шүүх нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх саналынхаа үндэслэлийг тодорхой зааж тогтоол, захирамж гаргах бөгөөд шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний асуудлыг шийдвэрлэсэн байвал зохино.

Яллагч шүүхийн саналын дагуу нэмэлт мөрдөн байцаалт хийх бол энэ хуульд заасан журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэтгүүлж, тогтоол, захирамжид заасан хугацаанд нотлох баримтыг шүүхэд шилжүүлнэ.

Нэмэлт мөрдөн байцаалт хийх шаардлагагүй гэж үзвэл яллагч үндэслэл бүхий тайлбараа 7 хоногийн дотор шүүхэд ирүүлнэ.

Шүүх яллагчийн ирүүлсэн нэмэлт нотлох баримт буюу тайлбарыг хүлээн аваад оролцогч талуудад мэдэгдсэний үндсэн дээр шүүх хуралдааны товыг наашлуулах буюу эсхүл товлосон хугацаандаа шүүх хуралдааныг эхэлж, энэ хуульд заасан ердийн журмаар хэргийг хянан хэлэлцэнэ."

7/320 дугаар зүйл:

"320 дугаар зүйл. Таслан шийдвэрлэх тогтоолд гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих хугацаа

Анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд гомдол, эсэргүүцлийг таслан шийдвэрлэх тогтоол уншин сонсгосон өдрөөс хойш арав хоногийн дотор гаргаж болох'бөгөөд хэрэв шийтгэгдсэн этгээд цагдан хоригдож байгаа бол таслан шийдвэрлэх тогтоолын хуулбарыг түүнд гардуулан өгсөн өдрөөс эхлэн хугацааг тоолно.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор хэргийг шүүхээс шаардан авч болохгүй. Прокурор, түүнчлэн шийтгэгдсэн ба цагаатгагдсан этгээд, тэдгээрийн өмгөөлөгч хууль ёсны төлөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч болон тэдгээрийн төлөөлөгч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагаа ба гарсан гомдол, эсэргүүцэлтэй танилцах эрхтэй.

Хугацаа хожимдуулж гаргасан гомдол, эсэргүүцлийг буцаана."

8/321 дүгээр зүйл:

"321 дүгээр зүйл. Гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих хугацааг сэргээх

Таслан шийдвэрлэх тогтоолд гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол давж заалдах гомдол буюу эсэргүүцэл бичих эрх бүхий хүмүүс хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтийг тогтоол гаргасан шүүхэд гаргаж болно.

Хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг захирамжаар шийдвэрлэх бөгөөд шүүгч тайлбар авахын тулд хүсэлт гаргасан этгээдийг дуудах эрхтэй.

Хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон тухай шүүгчийн захирамжид гомдол буюу эсэргүүцлийг дээд шатны шүүхэд ердийн журмаар гаргаж болох бөгөөд дээд шатны шүүх хэтэрсэн хугацааг сэргээн, хэргийг гомдол буюу эсэргүүцлийн дагуу хянан хэлэлцэх эрхтэй."

9/362[1] дүгээр зүйл:

"362[1] дүгээр зүйл. Хяналтын журмаар бичсэн эсэргүүцлийг ямар шүүх хэлэлцэх

Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчээс сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолд бичсэн эсэргүүцлийг зохих аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокуророос анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд бичсэн эсэргүүцлийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ."

3 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16[1] дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "123 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг" гэснийг "123 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг", "239 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг" гэснийг "239 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг", "260 дугаар зүйлийн 1 дэх хэсэг" гэснийг "260 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг", 121 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага" гэснийг "Тагнуулын төв газар", "323 дугаар зүйлийн гарчгийн "Анхан шатны", 1дэх хэсгийн "анхан шатны", 2, 3 дахь хэсгийн "шүүхийн тогтоол," гэснийг "таслан шийдвэрлэх тогтоол,", YI хэсгийн гарчиг "Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянах" гэснийг "Хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоолыг хянах" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 3 дах хэсгийг 4 дэх хэсэг, 244 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсгийг 5, 6 дахь хэсэг болгосугай.

5 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "...шаардаж болохгүй." гэсний дараа "Хэрэв эдгээр хүмүүс өөрсдөө мэдүүлэг өгөх хүсэлтээ гаргавал тэдгээрт мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэйг нь тайлбарласны эцэст мэдүүлэг авна.", 323 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "253" гэсний дараа "254[1]", 369 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтын "давж заалдах" гэсний өмнө "таслан шийдвэрлэх тогтоол, тогтоол,"; мөн зүйлийн 3 дахь заалтын "давж заалдах" гэсний өмнө, 370 дугаар зүйлийн "үзвэл" гэсний дараа "тогтоол, эсхүл"; 369 дүгээр зүйлийн 3 дахь заалтын "болгож" гэсний дараа "магадлал,"; мөн зүйлийн 4 дэх заалтын, 370 дугаар зүйлийн гарчгийн "давж заалдах" гэсний өмнө, мөн зүйлийн "түүнээс", 371 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "таслан шийдвэрлэх тогтоол буюу", 4 дэх хэсгийн "хяналтын шатны шүүх", 374 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн " болон" гэсний дараа, 2 дахь хэсгийн 1, 4 дэх заалт, 379 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтын "магадлал" гэсний өмнө "тогтоол,"; 370 дугаар зүйлийн "давж заалдах" гэсэн эхний 2 үгийн дараа, 371 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн эхний, 4 дэх хэсгийн эхний "давж заалдах" гэсний дараа ", хяналтын"; 372 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "шүүх" гэсний өмнө "Аймаг, нийслэлийн шүүхийн тогтоолд шүүх бүрэлдхүүн, Дээд шүүхийн тогтоолд" гэж тус тус нэмсүгэй.

6 дугаар зүйл. Эрүүгийн байцаан[1] шийтгэх хуулийн 71 дүгээр зүйлийн 3 дахь заалт, 367, 367[1] дүгээр зүйл, 369 дүгээр зүйлийн 4 дэх заалтын "хэлэлцүүлэхээр" гэсний дараахь "анхан шатны шүүхэд" 371 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "анхан шатны" гэсэн сүүлчийн 2 үг, 4 дэх хэсгийн "тогтоолд", 372 дугаар зүйлийн "гаргасан" гэсний дараахь "Дээд" гэснийг тус тус хассугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 29 | Улаанбаатар хот

Төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7-ийн "в"-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан "Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолын төслийг дахин боловсруулахаар Засгийн газарт буцаасугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын12-ны өдөр | Дугаар 31 | Улаанбаатар хот

Байгаль орчны тухай багц хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Байгаль орчны тухай багц хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

1/Байгаль орчны тухай багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг баталж мөрдүүлэх, мэргэжлийн албадыг хуульд нийцүүлэн 1995 онд багтаан өөрчлөн зохион байгуулах;

2/байгалийн бүх-төрлийн баялгийн нөөцийг тогтоох, үнэлэх ажлыг хуульд заасан хугацаанд зохион байгуулж байх;

3/байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх, байгаль орчны мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг 1996 онд багтаан гүйцэтгэх;

4/Байгаль орчны тухай багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон сургалт, сурталчилгааны ажлыг төв, орон нутагт зохион байгуулж, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэх;

5/Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэрийг 1995 онд багтаан Байгаль орчны тухай багц хуультай нийцүүлэх.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 33 | Улаанбаатар хот

5000-тын дэвсгэрт болон 20, 50, 100, 200 төгрөгийн зоосон мөнгөн тэмдэгтийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцох, гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах, эрх олгох тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 9-ний 46, 48 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "5000 төгрөг"-ийн дэвсгэрт болон "20 төгрөг", "50 төгрөг", "100 төгрөг", "200 төгрөг"-ийн зоосон мөнгөн тэмдэгтийг Монгол улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай.

2. Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "5000 төгрөг"-ийн дэвсгэрт болон "20 төгрөг", "50 төгрөг", "100 төгрөг","200 төгрөг"- ийн зоосон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргахыг Монголбанк /Д. МОЛОМЖАМЦ/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автобензин дизелийн түлшний албан татварын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/нефтийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ, төгрөгийн чөлөөт валюттай харьцах ханшны өөрчлөлтийг харгалзан нефтийн бүтээгдэхүүний дотоодын үнийг тогтвортой байлгах зорилгоор шаардлагатай үед Улсын Их Хурлаас олгогдсон эрхийнхээ хүрээнд түүнд ногдох гаалийн болон худалдааны татварыг өөрчлөн, шуурхай зохицуулалт хийж байх:

2/ Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд хуримтлагдсан байвал зохих замын хураамжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх арга хэмжээ авах.

ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ

Улсын Их Хурлын 35 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Төрийн захиргааны албаны зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ нь төрийн захиргааны албан хаагчийн стандартын удирдлагыг улсын хэмжээнд нэгдсэн аргачлалаар хангаж хэрэгжүүлэх ажлыг эрхлэх төрийн албаны төв байгууллага мөн.

2. Зөвлөлийн зорилт нь төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, төрийн захиргааны албыг мэргэшсэн албан хаагчаар хангах, төрийн албаны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд оршино.

3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт тусган улсын төсвөөс санхүүжүүлнэ.

5. Зөвлөлийн санхүү, аж ахуйн үйлчилгээг Төрийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар хариуцах бөгөөд түүний ажлын албаны

үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийн зохих салбар нэгжүүд тус тус гүйцэтгэнэ.

6. Зөвлөлийн дарга, орон тооны гишүүний цалин хөлс, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад хангамжийг Засгийн газрын санал болгосноор Улсын Их Хурал тогтооно.

7. Зөвлөл нь яам, тусгай газрын ажлын алба болон аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын албаны дэргэд орон тооны бус салбартай байна. Зөвлөл нь тэдгээр салбараараа дамжуулан Төрийн албаны тухай хуульд тодорхойлсон чиг үүрэг, энэ дүрэмд заасан үйл ажиллагаагаа яам, тусгай газар, орон нутгийн төрийн байгууллагад хэрэгжүүлнэ.

8. Зөвлөл нь яам, тусгай газар, аймаг, нийслэл дахь орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтооно.

9. Зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа

10. Зөвлөл нь Төрийн албаны тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/удирдлагын үндэсний чадавхийг хөгжүүлэх бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх;

2/төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх нэгдсэн журам тогтоож, мөрдүүлэх;

3/төрийн захиргааны албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний үлгэрчилсэн заавар боловсруулж, түүнийг дагаж мөрдүүлэх ажилд хяналт тавих:

4/Төрийн захиргааны албаны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал боловсруулан холбогдох байгууллагад оруулах;

5/Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан шаардлага, мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан, төрийн захиргааны албанд орох хүсэлтэй Монгол Улсын иргэнээс мэргэшлийн шалгалт авах болон төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх асуудлаар журам тогтоож, эдгээр ажлыг арга зүй зохион байгуулалтын удирдлагаар хангах;

6/төрийн захиргааны албан хаагчийн хэрэгцээг төлөвлөх, төрийн захиргааны албыг мэргэшлийн албан хаагчаар хангах ажлыг зохион байгуулах;

7/зөвлөлийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар яам, тусгай газар, төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шалган зааварлаж, мэргэшил, аргачилсан туслалцаа үзүүлэх;

8/Төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдол бүхий шаардлагатай мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл шаардлагатай бол төрийн бусад байгууллагыг хангах ажлыг зохион байгуулах.

9/улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал, хүсэлт гаргах;

10/төрийн байгууллага болон төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд гарсан Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан маргааныг хянан шийдвэрлэх;

11/төрийн байгууллагын бүтэц, албан тушаалын орон тоо, төсөв, цалингийн сан, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишиг тогтооход холбогдох эрх бүхий байгууллагад санал өгөх;

12/төрийн алба, төрийн албан хаагчийн хувийн хэрэг, бүртгэлтэй холбогдсон шаардлагатай мэдээ, судалгаа, материалыг яам, тусгай газар, төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагаар гаргуулан авах;

13/Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны болон яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын албаны удирдах албан тушаалд томилогдох төрийн захиргааны албан хаагчтай биечлэн уулзах, мэдээлэл авах үндсэн дээр дүгнэлт гаргаж уг албан хаагчийг томилох эрх бүхий байгууллагад өгөх;

14/төрийн захиргааны албан хаагчийн сургалтыг зохион байгуулж төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдсон судалгаа, шинжилгээ хийж санал дэвшүүлэх;

15/яам, тусгай газар, аймаг, нийслэл дэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж тэдгээрийн ажлыг уялдуулан зохицуулах.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

11. Зөвлөлийн үйл ажиллагааны хамтын удирдлагын хэлбэр нь хуралдаан мөн. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хуралдаан хүчин төгөлдөр болно. Хуралдаанаар Зөвлөлийн чиг үүрэг, төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэнэ. Асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

12. Хуралдаан хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

13. Хуралдаанд зөвлөлийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцоно.

14. Зөвлөлийн хуралдааныг ажлын шаардлагыг харгалзан Зөвлөлийн дарга, гишүүдийн олонхийн саналаар хийнэ.

15. Зөвлөлийн ажиллах журам, хуралдааны дэгийг Зөвлөл тогтооно. Хуралдааны хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлнө.

16. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдах, зохицуулах, хуралдааны бэлтгэл хангуулах, хуралдаан даргалах, гишүүдийн ажил, үүргийн хуваарийг баталж мөрдүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, төсвөө захиран зарцуулах, зөвлөлийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцаж, дотоод, гадаадад зөвлөлийг төлөөлнө. Зөвлөлийн дотоод асуудлаар тушаал гаргана.

17. Зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг Зөвлөлийн шийдвэрээр орон тооны аль нэг гишүүн орлон гүйцэтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

"Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

2. Энэхүү баримт бичигт тодорхойлсон бодлогыг чанд баримтлан дэвшүүлсэн зорилтыг дэс дараатай хэрэгжүүлэх ажил зохион байгуулж гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнаж байхыг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1995 оны
36 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Монгол Улсын оршин тогтнох, хөгжин дэвших эх сурвалж бол монгол хүний тасралтгүй хөгжиж байх, оюун ухааны чадавхи, боловсрол мөн.

Монгол улсын хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн шинэ харилцаанд шилжин орж байгаа энэ үед иргэдийн боловсролын хэрэгцээ, боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг тодорхойлж байна.

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн. Үүнийг үндэслэн боловсролыг төрөөс нийгмийн ТЭРГҮҮЛЭХ САЛБАР болгон хөгжүүлнэ.

Хүн ам цөөн, ажиллах хүч дутмаг манай орны нөхцөлд үндэсний эдийн засгийн өсөлтийг хангах, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх нэг гол үндэс нь хүн амын боловсролын түвшин, хувь хүний мэргэжлийн ур чадварыг хэлбэрэлтгүй дээшлүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн ололт амжилтад тулгуурласан оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх явдал гэж үзнэ.

Боловсролын үндсэн зорилго нь хүн бүрийг шинжлэх ухааны мэдлэгийг зохих түвшинд эзэмшсэн, шударга ёс, хуулийг дээдлэн сахидаг, эх оронч, соёлч, хамтач, эрүүл чийрэг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, бие даан суралцах, ажиллаж амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Төрөөс боловсрол, хүний хүчин зүйлийг харилцан шүтэлцээтэй хөгжүүлнэ.

II. БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР

1.Төрөөс боловсролыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг дор дурдсанаар тодорхойлж байна:

1/боловсролыг төрийн ивээл, дэмжлэг, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгах;

2/иргэдийг сурч боловсроход үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх;

3/төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг иргэдэд төлбөргүй олгох;

4/иргэдэд суурь боловсролыг заавал эзэмшүүлэх;

5/хүүхдэд зохих шатны боловсрол эзэмшүүлж, тэднийг ажил, амьдралд бэлтгэх нь эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг гэж үзэх;

6/Боловсролын үйл ажиллагааг хэвийн жигд явуулах нөхцөл, орчин бүрдүүлэх, багш мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлж, багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх;

7/Боловсролын тогтолцоог иж бүрэн, түүний үйл ажиллагаа, агуулгыг тогтвортой бөгөөд тасралтгүй, залгамж холбоотой байлгаж, боловсрол эзэмших арга, хэлбэрийг олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй болгох;

8/өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил шаардлага тавьж, зохих дэмжлэг үзүүлэх;

9/ иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахууны хүмүүжил, нийгмийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулахыг хориглох;

10/Боловсролыг хөгжүүлэх үйл хэрэгт төр, олон нийтийн болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд, тэдний хувь нэмрийг хөхүүлэн дэмжих.

2. Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ:

1/ Монгол орны эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, нутаг дэвсгэрийн бодлого;

2/судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, олон нийтийн санал, хүсэлт;

3/боловсролын хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн байдал;

4/боловсролын удирдлага, багшлах боловсон хүчин, санхүүгийн чадавхи, материаллаг нөөц;

5/боловсролын эрх зүйн харилцааны зохицуулалт;

6/өөрийн орны онцлог, олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөл, боломж.

III. ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ТАЛААР

1.Үндсэн хуульд заасны дагуу иргэдийн боловсрол эзэмших эрхийг баталгаажуулахад дараахь чиглэл баримтална:

1/иргэдийн сурч боловсрох эрх зүйн харилцаа, боловсролын тогтолцоо, түвшин, шатлал, суралцах хугацааг хуулиар тогтоох;

2/бүх шатны боловсролын агуулгыг иргэдийн нас, хүйс, сэтгэхүйн онцлог, авьяас сонирхол, хувь хүний хэрэгцээ, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн шаардлага, чиг хандлага, үндэсний онцлог, олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцүүлэх;

3/сургуулийн өмнөх боловсролын агуулгыг хүний хөгжил, төлөвшлийн идэвхтэй хөгжлийн үе болох бага, балчир насанд нь хүмүүжлийн зөв хэвшил, орчны амьдрал, үзэгдэл, юмсын тухай анхдагч төсөөлөл олгох, өөртөө үйлчлэх дадалд сургах, сургуульд суралцах бэлтгэлийг хангахад чиглүүлэх;

4/өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийг ердийн, асрамжийн, сувиллын хэв шинжтэй хөгжүүлэх;

5/бага боловсролын агуулгыг суралцагчдад эх хэлээрээ унших, бичих, тоо бодох анхны мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, хүмүүнлэгийн ёс заншил, соёлын өв уламжлал, байгалийн үзэгдэл, юмсын талаар анхдагч ойлголт төлөвшүүлэхэд чиглүүлэх;

6/суурь боловсролын агуулгыг суралцагчдад мэдлэг, авьяас чадвараа цаашид хөгжүүлэх, бие даан амьдрах, хөдөлмөрлөхөд

шаардагдах байгаль, нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлэх, үндэсний ёс заншил, эх оронч, хамтач хүмүүжил төлөвшүүлэхэд чиглүүлэх;

7/бүрэн дунд ерөнхий боловсролын агуулгыг суралцагчдад суурь боловсролын агуулгатай залгамж холбоотойгоор суралцагчдын авьяас сонирхлын дагуу шинжлэх ухааны ерөнхий мэдлэг эзэмшүүлж, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрал, хөдөлмөр болон дараагийн шатны сургуульд элсэн суралцахад бэлтгэхэд чиглүүлэх;

8/ерөнхий боловсролын сургуулийг төрөлжүүлж, гүнзгийрүүлсэн хэв шинжтэйгээр хөгжүүлэхийг дэмжих;

9/хүүхэд сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын зэрэгцээ зохих насандаа суурь боловсрол эзэмшээгүй хүүхэд, залуучуудад суурь боловсрол нөхөн олгох сургалтын тогтолцоо бий болгох, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг, эх, асран хамгаалагчид хариуцлага хүлээлгэж байх;

10/бүх шатны сургалтыг кирилл монгол бичгээр явуулж, уйгаржин монгол бичгийг суурь боловсролын агуулгад багтаан бүх нийтэд эзэмшүүлэх;

11/суурь боловсрол эзэмшсэн суралцагчдыг тэдний авьяас, сонирхлыг харгалзан дараахь шатны ерөнхий боловсролын буюу техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны сургуульд сургах, мэргэжил олгох түр сургалтанд хамруулан ажил эрхлүүлэх зэргээр тэднийг ажил, сургуультай байлгах;

12/техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын агуулгыг суралцагчдад техник, технологи, мэргэжлийн суурь боловсрол олгохын зэрэгцээ тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх мэргэжил эзэмшүүлэхэд чиглүүлэх;

13/хүүхэд, залуучуудын онцгой авьяас, чадварыг багаас нь илрүүлж, тодорхой чиг зорилготой сургаж мэргэшүүлэх замаар үндэсний урлаг, спорт, соёлын авьяастан, зохион бүтээгч, инженер, судлаач, сэтгэгчдийг төрүүлэх үйл ажиллагааг дэмжих;

14/хүүхдийн авьяас чадварыг багаас нь илрүүлэн хөгжүүлэх зорилгоор суурь боловсролын хүрээнд зарим хичээлийг гэрийн буюу шавь сургалтаар төлбөртэй эзэмшүүлэх боломжийг дэмжих;

15/дээд боловсролын агуулгыг суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд

мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, иргэний өндөр ухамсар, хүмүүжил төлөвшүүлэхэд чиглүүлэх;

16/бүх шатны сургуулийн үйл ажиллагааг дангаар ноёрхох, ялгаварлан гадуурхах, ашгийн хойноос хөөцөлдөх, аль нэг нам, эвслийг дэмжих, харгис онолыг сурталчлан дэлгэрүүлэх хэрэглүүр болохыг хориглох;

17/хараагүй, дүлий, оюун ухаан хомсдолтой, бие эрхтний согогтой хүүхэд, залуучуудад зохих түвшний боловсрол, мэргэжил эзэмшүүлэх;

18/сургуулиар эзэмшүүлэх боловсролоос гадна иргэдэд амьдарч, хөдөлмөрлөхөд зайлшгүй шаардлагатай нийгэм, эдийн засаг, эрх зүй, байгаль орчин, соёл, гоо зүй, эрүүл мэнд, бие бялдар, гэр бүлийн болон охид, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмшүүлэх;

19/бүх нийтийн боловсрол, мэргэжлийн тасралтгүй чанарыг хангахын тулд албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, санхүү, материалын туслалцаа үзүүлэх, энэ ажилд нийгмийн нөөц бололцоог өргөн ашиглах;

20/бага, дунд, дээд боловсролын стандартыг төрөөс тогтоож, түүнийг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад нэгэн адил мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, үнэлэх механизмыг бий болгох;

21/зохих түвшний боловсрол эзэмшсэн, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, цол хүртсэн, мэргэжил дээшлүүлсэн иргэдэд түүнийг нь батламжилсан баримт бичиг олгох.

2. Боловсрол эзэмших эдийн засгийн баталгааг дараахь байдлаар хангана:

1/боловсролын байгууллага нь өмчийн аль ч хэлбэрт үндэслэсэн байж болох бөгөөд төдгээр нь ашгийн төлөө бус байгууллага байна. Төрийн өмчийн сургалтын байгууллагын эдийн засгийн баталгаа нь төрийн ивээл, дэмжлэгээр хангагдана. Өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагад материаллаг баазыг бэхжүүлэх, багшлах боловсон хүчнээр хангахад төрөөс зохих дэмжлэг үзүүлэх;

2/боловсролын үйл ажиллагааг нормативаар санхүүжүүлэх зарчимд шилжүүлж, төрийн өмчийн сургуульд норматив зардлыг төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг мэргэжлийн чиглэл, онцлогийг харгалзан ялгавартай тогтоож мөрдүүлэх;

3/бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургуулийн нэг суралцагчид ногдох зардал, дээд боловсрол эзэмшүүлэх

сургуулийн нэг суралцагчид ногдох сургалтын хөтөлбөрийн зардлын доод хэмжээг мэргэжил, сургалтын онцлогийг харгалзан Засгийн газраас тогтоож байх;

4/ясли, цэцэрлэгийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлого болон эцэг, эх, асран хамгаалагчийн төлбөрийн орлого зэргээс бүрдүүлэх;

5/ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлогоос; их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн сургуулийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, суралцагчдын төлбөр зэргээс бүрдүүлэх;

6/бололцоотой техникийн болон мэргэжлийн сургууль, их, дээд сургууль, коллежийн зарим барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг зориулалтаар нь түрээслүүлэх, хувьчлах, аж ахуйн нэгж, байгууллагатай хоршиж ажиллуулах чиглэлийг дэмжих;

7/боловсролын үйл ажиллагааг санхүүжүүлэх зардлыг улсын төсөвт тусгахдаа үнэ, мөнгөний ханшийн өөрчлөлттэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн зардлыг өмнөх оныхоос нэмэгдүүлж байх зарчмыг баримтлах;

8/өмчийн хэлбэр харгалзахгүйгээр багш, суралцагчдад зохих журмын дагуу хөнгөлөлт үзүүлэх, нөхөх төлбөр, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил олгох;

9/сургалтын төлбөрийн хэмжээг боловсролын түвшин, мэргэжлийн онцлогийг харгалзан ялгавартай тогтоох;

10/сургалт, хүмүүжлийн ажлын орчин үеийн агуулга, шаардлагад нийцсэн сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр сургуулийг хангах, энэ чиглэлээр гадаад, дотоод хөрөнгө оруулагчдад санхүү, зээл, татварын тааламжтай нөхцөл бүрдүүлэх замаар сургуулийг хөгжүүлэх;

11/боловсролын үйл ажиллагааны онцлогийг харгалзан санхүү, зээл, татварын уян хатан механизмыг бий болгож, сургууль, боловсролын байгууллагыг хөгжүүлэх төвлөрсөн болон орон нутгийн сан байгуулж, түүнд хөрөнгө оруулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх;

12/бүх шатны сургуульд суралцагчдын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн, тоног

төхөөрөмжийн хүрэлцээг сайжруулах, оюутан, суралцагчдын тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх, замын зардал, орон байрны хөнгөлөлт үзүүлэх, дотуур байраар хангах зэргээр төдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төрийн халамж анхаарлыг чиглүүлэх;

13/ боловсролын удирдлагын шат дамжлагыг цөөлөх, нэг багшид ногдох оюутан, суралцагчдын тоог мэргэжлийн онцлогийг харгалзан ялгавартай тогтоох зэргээр төсвийн зардлыг хэмнэх, түүнийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

14/суралцагчдын сурлагын амжилт, авьяас, чадварыг хөхүүлэн дэмжих, тахир дутуу, ончин болон амьдралын түвшин доогуур оюутан, сурагчдад төрөөс хөнгөлөлт, халамж үзүүлэх;

15/хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг суралцагчдын алжаалыг тайлах, бие бялдрыг хөгжүүлж чийрэгжүүлэх, тэдэнд хамт олонч, нөхөрсөг харьцааг төлөвшүүлэхэд чиглүүлэх, тэдгээрийг материаллаг баазаар бэхжүүлэх.

IY БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР

Өөрийн орны өвөрмөц онцлог, боловсролын олон улсын нийтлэг жишиг, хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын удирдлагыг дараахь чиглэлээр төгөлдөржүүлнэ:

1/боловсролыг хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, төлөвлөлтийг улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хөдөлмөр, хүн ам зүйн бодлоготой нягт уялдуулах;

2/боловсролын төвлөрсөн болон төвлөрсөн бус удирдлагын хүрээнд төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, цэцэрлэг, бүх шатны сургуулийн удирдлагын үйл ажиллагааны зааг ялгаа, бүрэн эрх, төдний харилцан уялдаа холбоог нарийвчлан тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах;

3/бүх шатны сургуулийн үйл ажиллагаагаа явуулах эрхийг баталгаажуулах үүрэг бүхий олон нийтийн төлөөлөлтэй магадлан итгэмжлэх байгууллага бий болгох;

4/бүх шатны боловсролын стандартын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих мэргэжлийн хяналтын эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх;

5/боловсролын мэдээллийн дэд сүлжээг бий болгож хөгжүүлэх, боловсролын удирдах ажилтан, судлаачдыг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэх;

6/боловсролын байгууллагын бүтэц, байршил, харьяаллыг оновчтой тогтоох;

7/дээд боловсролыг шинжлэх ухаан, үйлдвэрлэлтэй интеграцчилах замаар бий болсон оюуны болон хөдөлмөр, санхүү, материалын чадавхийг үр өгөөжтэй ашиглахуйцаар зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

8/дээд боловсрол эзэмшүүлэх байгууллагыг төдгээрийн зорилго, онцлогтой уялдуулан сургалт-эрдэм шинжилгээний, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн, эрдэм шинжилгээ-сургалтын, сургалт-үйлдвэрлэлийн, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг хэлбэрээр хөгжүүлэх;

9/хичээл, түүнээс гадуурхи сургалт-хүмүүжлийн ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үүднээс боловсролын болон хүүхэд, залуучуудын соёл, хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, боловсролын төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг төв, орон нутагт өргөжүүлэх;

10/хүүхэд, залуучуудын үүсгэл санаачлагын байгууллагыг дэмжих, төдэнд туслалцаа үзүүлэх, эрх ашгийг нь хамгаалахад төрөөс анхаарах;

11/боловсролын онол, арга зүй, хөгжлийн асуудлаархи судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, түүний шинжлэх ухааны үндэслэл, үр дүнг дээшлүүлэх, боловсрол судлаачдыг бэлтгэх.

Ү. БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧИЙН ТАЛААР

Багш бол ард түмний соён гэгээрүүлэгч, хүүхэд, залуучуудын оюун ухааныг хөгжүүлж, авьяас билгийг нээн илрүүлэгч, төднийг амьдарч, хөдөлмөрлөх арга ухаанд сургаж, өөрийн биеэр үлгэрлэн хүмүүжүүлэгч гэж үзэж төдний талаар дараахь бодлогыг баримтална:

1/багшийн нийгэм, бие хүний хөгжилд оруулж буй хувь нэмэр, хөдөлмөрийг бодитой үнэлж, боловсрол нийгмийн төргүүлэх салбар болохын хувьд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн, багш, сурган хүмүүжүүлэгчдийн цалингийн хэмжээг тухайн орон нутгийн төрийн захиргааны албан хаагчийн цалингийн дундач түвшингээс доошгүй байлгах;

2/багш болох сонирхолтой хүүхэд, залуучуудыг сонгон шалгаруулж, багшийн мэргэжлээр сургах, багш мэргэжлийг өвлүүлэх, тэдэнд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3/багш бэлтгэх сургуулийн бүтэц, зохион байгуулалт, мэргэжлийн чиглэл, сургалтын агуулга, арга, технологийг боловсронгуй болгох;

4/хөдөөгийн сургуулийг багшлах боловсон хүчнээр хангах, тэдний тогтвор суурьшилыг сайжруулахын тулд нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн захиалга, гэрээгээр багш бэлтгэх, дунд сургуулийн багш нарт хос мэргэжил эзэмшүүлэх;

5/багшийн сурган хүмүүжүүлэх ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх;

6/багшийн мэдлэг, чадвар, ажлын ур дүнг харгалзан тэдэнд "Багшийн мэргэшлийн зэрэг", "ур чадварын нэмэгдэл" олгох;

7/хичээлээс гадуур зохиох сургалт хүмүүжлийн ажилд зарцуулсан хөдөлмөрийг үнэлгээтэй болгох;

8/ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн дунд сургуульд зохих диплом буюу бакалаврын зэрэгтэй; их, дээд сургууль, коллеж /үндсэн мэргэжлийн хичээлийг/-д магистраас доошгүй зэрэгтэй багшийг ажиллуулах;

9/багшид нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нэмэгдэл (нэрэмжит) цалин олгох, орон байраар хангах, зээл, тусламж олгох, бусад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх ажлыг бүх талаар дэмжих;

10/багшийн амралт, сувилал, тэтгэвэр, тэтгэмжийг тэдний хөдөлмөрийн онцлог, ажилласан хугацааг харгалзан шийдвэрлэж байх.

VI. БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР

Боловсролыг хөгжүүлэх үйл хэрэгт төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог бүх талаар өргөжүүлж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, урамшуулах, дэмжих талаар дараахь чиглэл баримтална:

1/боловсролыг хөгжүүлэхэд оролцогчдын үйл ажиллагааг өргөжүүлэх, зохицуулах, хөхүүлэн дэмжих эрх зүйн баталгаа бий болгох;

2/бүх шатны сургуулийн хичээлийн болон дотуур байр, сургалт-хүмүүжил, эрдэм шинжилгээний зориулалттай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, багш, сурагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үүсгэл санаачлагыг чиглүүлж хөхүүлэн дэмжих;

3/бүх шатны боловсролын агуулгыг боловсронгуй болгоход аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрэлт, хэрэгцээ, санал, бодлыг тусгаж байх;

4/хүүхдэд сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэхэд нутгийн захиргааны байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

5/аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс цэцэрлэг байгуулж ажиллуулахыг дэмжих замаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг мэргэжлийн багшаар хангаж, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6/аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажиллагчдын боловсрол, мэргэжлийн түвшинг байнга дээшлүүлэх үүрэг хүлээх;

7/эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ боловсрол эзэмших нөхцөл бололцоог бүрдүүлж, суурь боловсрол заавал эзэмшүүлэх, ажил, мэргэжлээ зөв сонгоход нь туслах;

8/дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн сурч, хүмүүжих нөхцөл бололцоог сайжруулах, тэднийг хоол, хүнсээр хангахад нутгийн захиргааны болон эрүүл мэнд, соёлын байгууллага, аж ахуйн нэгж, эцэг, эх, иргэдийн туслалцааг нэмэгдүүлэх;

9/иргэдэд нийтийн боловсрол олгоход хэвлэл, мэдээлэл, мэргэжлийн болон соёл, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх.

VII. БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР

Боловсролын гадаад харилцааг хөгжүүлэх талаар дор дурдсан чиглэл баримтална:

1/боловсролыг хөгжүүлэх хоёр болон олон талын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2/олон улсын болон бүс нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтарсан хөтөлбөр, төсөл

хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, боловсролын бодлогыг уялдуулан зохицуулах;

3/мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалт, эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах, түүний үр өгөөжийг дээшлүүлэх;

4/боловсролын байгууллага хоорондын шууд хамтын ажиллагааг өргөжүүлж, тал бүрээр дэмжих;

5/олон улсын болон гадаад орны боловсролын байгууллагатай боловсролын түвшин, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөлцөх;

6/гадаад оронд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх арга хэмжээг урт, богино хугацаагаар хэрэгжүүлэх;

7/ дэлхийн болон олон улсын боловсролын төрөлжсөн байгууллагад гишүүнээр элсэх, конвенцид нэгдэн орох;

8/дэлхийн болон олон улс, бүс нутгийн боловсролын төв байгууллагуудын зарим салбар, нэгжийг өөрийн оронд нээж ажиллуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

Боловсролын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Боловсролын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/боловсролын салбарт ажиллагчид, суралцагчид, нийт иргэдэд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг сурталчлах ажлыг зохион байгуулах;

2/Засгийн газраас баталсан бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж байгаа холбогдох тогтоол, шийдвэрийг 1995 онд багтаан боловсролын тухай хуулиудтай нийцүүлэх;

3/боловсролын тухай хуулиудад заасан дүрэм, журам, норматив болон холбогдох бусад баримт бичгийг 1996 оны эхний хагас жилд багтаан баталж, мөрдүүлэх;

4/боловсролын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

5/боловсролын мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож, үр нөлөөг нь дээшлүүлэх;

6/одоо ажиллаж байгаа цэцэрлэг, бүх шатны сургуулийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгох ажлыг 1996 оны 1 улиралд багтаан зохион байгуулах;

7/сургалтын агуулга, стандартад нийцүүлэн цэцэрлэг, бүх шатны сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын материаллаг баазыг бэхжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцон жил бүрийн төсөвт тусгах;

8/бүх шатны сургуулийн байршлыг оновчтой тогтоож, сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулах нөхцөлийг хангах, малчдын хүүхдийн дотуур байрны хоол, хүнсний хангамж, эрчим хүч, халаалтын асуудалд холбогдох байгууллагуудын хүч, анхаарлыг төвлөрүүлэн үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээ авах;

9/их, дээд сургуульд кредит цаг нэвтрүүлэх ажлыг 1996-1998 онд багтаан дуусгах;

10/бүх шатны сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгчдийг 1995-1996 оны хичээлийн жилд багтаан шалгаруулалтад хамруулж, тэдэнд багшлах эрх, мэргэшлийн болон ур чадварын зэрэг олгох, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг системтэйгээр авч хэрэгжүүлэх;

11/багшийн нийгмийн баталгаатай холбогдсон асуудлыг "Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуульд заасан хугацаатай уялдуулан үе шаттайгаар шийдвэрлэх;

12/ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны загварыг 1995 оны IY улиралд багтаан баталж, түүнийг 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглүүлэх арга хэмжээ авах;

13/боловсролын тухай хуульд сургалтын байгууллагуудыг ашгийн төлөө бус байгууллага гэж заасантай уялдуулан татварын

тухай болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж 1995 онд багтаан Улсын Их Хуралд оруулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргыг томилох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Лхамсүрэнгийн Жавзмааг Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргаар томилсугай.

2. Энэ тогтоолыг 1995 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Осорын Амархүү, Пандийн Бямбацэрэн, Доржцэдэнгийн Дуламсүрэн, Галсангийн Зинамядар, Дансрангийн Мужаан, Бумбуугийн Шарбанди нарыг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 1995 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот

Цалингийн санг батлах тухай

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны хорооны 1995 оны сарын цалингийн санг 441,4 мянган төгрөгөөр баталсугай.

2. Үнэт цаасны хорооны цалингийн санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг 1995 оны төвлөрсөн төсвөөс гарган санхүүжүүлэхийг Засгийн газар /П.ЖАСРАЙ/-т даалгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 71 | Улаанбаатар хот

Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай

Монгол Улсаас Израиль Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ишцогийн Очирбалыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **П.ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 72 | Улаанбаатар хот

Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай

Монгол Улсаас Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ишцогийн Очирбалыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **П.ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

Б.Должинцэрэнг элчин сайдаар томилох тухай

Монгол Улсаас Бруней Даруссалам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Бадам-Очирын Должинцэрэнг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 74 | Улаанбаатар хот

Чимэддоржийн Цэрэндоржийг Сүхбаатарын одонгоор шагнах тухай

МИ-8 нисдэг тэрэг, АН-24 онгоцны борт-техникчийн мэргэжлийг чадамгай эзэмшиж, МИ-8 нисдэг тэрэгний хөдөлгүүр, зарим эд ангийн нарийн төвөгтэй засвар, тохируулгын ажлыг өөрийн орны нөхцөлд анх удаа чанарын өндөр түвшинд хийж, нислэгийн аюулгүй болон бэлэн байдлыг хангаж залуу нисгэгч, инженер, техникийн ажилтныг сургаж дадлагажуулахад үр бүтээлгарган ажиллаж байгаагнь үнэлж Хилийн цэргийн удирдах газрын Нисэхийн хорооны АН-24 онгоцны борт-техникч Чимэддоржийн Цэрэндоржийг Сүхбаатарын одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 75 | Улаанбаатар хот

Намсрайн Ёндонд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгох тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж техникийн хүч чадлыг бүрэн ашиглах, эдэлгээний нормыг уртасгах, сүүлийн жилүүдэд нэгж талбайгаас авах ургацын хэмжээг улс, аймгийн дунджаас давуулан арвин ургац хурааж хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, залуу механикжуулагчдыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Их булаг" хувьцаат компанийн тракторч-комбайнч Намсрайн Ёндонд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **П.ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 76 | Улаанбаатар хот

Жанчивын Баатарсүрэнг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай

Ой ангийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ойг нөхөн сэргээх, тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах, сүүлийн жилүүдэд үслэг ангийн аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төрхурахын үслэг ангийн сангийн аж ахуйн

дарга Жанчивын Баатарсүрэнг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Дугаар 84 Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Намсрайн Гачмааг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчээр, Пандийн Долгормааг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Цэрэннадмидын Батсүрэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Түмээгийн Байгалмааг Дорнод аймаг дахь сумын шүүхийн шүүгчээр, Шилэгийн Михайг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Сосорбарамын Энхжаргалыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

ОХУ-ын иргэн, зарим ахмад дайчдыг Цэргийн гавьяаны одонгоор шагнах тухай

Фашизмын эсрэг байлдаж явсан болон тус улсад байнга оршин сууж манай орны бүтээн байгуулалтад гар бие оролцон олон жил үр бүтээлтэй ажилласныг нь үнэлж ОХУ-ын иргэн дор дурдсан ахмад дайчдыг Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Цэргийн гавьяаны одонгоор шагнасугай.

1.Николай Иванович Власов - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1-р хороонд оршин сууж байгаа

2.Василий Васильевич Алексеев - Нийслэлийн Баянгол дүүргийн 14-р хороонд оршин сууж байгаа

3.Василий Иванович Бурдуковский - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд оршин сууж байгаа

4.Яков Аристархович Куприянов - Мөн аймгийн мөн сумандоршин сууж байгаа

5.Дмитрий Васильевич Шульгин - Нийслэлийн Баянгол дүүргийн 14-р хороонд оршин сууж байгаа

6.Леонид Михайлович Емельянов - Нийслэлийн Баянгол дүүргийн 17-р хороонд оршин сууж байгаа

7.Игорь Павлович Мельников - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд оршин сууж байгаа

8.Иннокентий Александрович Брилев	-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6-р хороонд оршин суух байгаа
9.Галина Яковлевна Етобаева	-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3-р хороонд оршин суух байгаа
10.Афанасий Васильевич Емельянов	-Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд оршин суух байгаа
11. Иван Акимович Бурдуковский	-Дархан-Уул аймгийн Дархан суманд оршин суух байгаа
12.Анфиса Николаевна Ашинова	-Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1-р хороонд оршин суух байгаа
13.Владимир Пантелеймонович Феодоров	-Нийслэлийн Баянгол дүүргийн 1-р хороонд оршин суух байгаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

ОХУ-ын иргэн зарим ахмад дайчдыг медалиар шагнах тухай

Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалан 1939 оны Халхын голын байлдаанд оролцож явсан ОХУ-ын иргэн дор дурдсан ахмад дайчдыг Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 50 жилийн ойг тохиолдуулан медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

Михаил Иванович Бурцев -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

НАЙРАМДАЛ МЕДАЛИАР:

1.Евгений Николаевич Степанов -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

2.Федор Васильевич Олешко -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

3.Лаврентий Алексеевич Олейников -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

4.Петр Иванович Калинин -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

5.Николай Дорофеевич Кравец -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

6.Арсений Васильевич Ворожейкин -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

7.Мария Михайловна Сафинова -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

8.Алексей Митрофанович Кривель -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

9.Николай Матвеевич Широбоков -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

10.Иван Иванович Коновалов -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

11.Тихон Григорьевич Буряк -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

12.Николай Иванович Ганин -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

13.Даниил Прокофьевич Дубель -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

14.Николай Григорьевич Богданов -Москва хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Дугаар87 Улаанбаатар хот

Украин улсын иргэн зарим ахмад дайчдыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалан 1939 оны Халхын голын байлдаанд оролцож явсан Украин улсын иргэн дор дурдсан ахмад дайчдыг Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын "Найрамдал" медалиар шагнасугай.

1.Александр Борисович Подвойский -Киев хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

2.Евгений Григорьевич Горбатенко -Киев хотод өндөр насны тэтгэвэрт байгаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 4 | Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 14 цагт Төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэв. Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Л.Баасан даргалж, гишүүдэд Ц.Цолмон, Н.Жанцан, Д.Чилхаажав, Ч. Энхбаатар /илтгэгч/ нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд маргагч талыг төлөөлж иргэн Д.Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Ц. Товуусүрэн оролцов.

Иргэн Д. Ламжав 1995 оны 5 дугаар сарын 22, мөн оны 6 дугаар сарын 5-нд гаргасан өргөдлүүддээ: "Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг гурван талт эвлэрүүлэх хороогоор болон шүүхээр хянан шийдвэрлэх шатанд ажил хаяхыг хориглоно", 3 дахь хэсгийн "Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн хүн тээвэр, улс, хот хоорондын болон цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагад ажил хаях нь улс орны аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн дурдсан заалтууд нь хөдөлмөрчид ажлын таатай

нөхцөлөөр хангуулахын төлөө тэмцэх, тухайлбал тэдний ажил хаях эрхийг онц болон дайны байдал зарлаагүй нөхцөлд ч, зарим тохиолдолд хуулиар бус Засгийн газрын шийдвэрээр хязгаарлаж болохыг зөвшөөрсөн байна. Хуулийн энэхүү хоёр заалт Үндсэн хууль зөрчиж байгаа тухай миний өргөдлүүдийг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Товуусүрэн, Ж.Бямбажав нар бичгээр ирүүлсэн тайлбартаа:

"1. Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна гэж үзжээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн арбитрын болон сайн дураар эвлэрэх тухай 92 дугаар зөвлөмжийн 4-д "Хэрэв санал зөрүүтэй асуудлаар харилцагч талууд эвлэрэх тухай тохиролцсон байвал талуудад ажил хаях, локаутыг эвлэрэх үйл ажиллагаа явагдаж буй хугацаанд зогсоох нь зүйтэй" гэж заасан байна. Энэ байдлаас авч үзвэл энэ заалт нь хүний эрхийг хязгаарласан бус харин талууд харилцан зөвшилцөлд хүрэхэд саад болохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд харин зөвшилцөлд хүрч чадахгүй бол цаад талд нь ажил хаях эрх нь хадгалагдаж байгаа гэж ойлгох нь зүйтэй болов уу.

2. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзжээ. Уг асуудлыг Улсын Их Хурал ихээхэн анхааралтай хэлэлцэж, төсөлд ажил хаялтыг хориглох заалт байсныг Засгийн газраас тодорхой арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор: "...1 сарын хугацаагаар хойшлуулж болно" гэж хуульчилсан юм. Бидний үзэж байгаагаар энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, НҮБ-ын иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлийн заалттай нийцэж байна гэж үзэж байна. Иймд хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэж үзэж байна" гэжээ.

Иргэн Д.Ламжав цэцийн хуралдаанд өгсөн тайлбартаа: Нэхэмжлэлээ дэмжиж байна. Үндсэн хуулинд маш тодорхой нөхцөл байдалд хүний эрхийг хязгаарлаж болно гэж заасан. Гэтэл Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн маргаж

буй заалтад ийм нөхцөл, болзолгүйгээр, зөвхөн Засгийн газрын үзэмжээр хүний ажил хаях эрхийг хязгаарлах боломж нээж байгаа нь хүний эрхэнд аюултай заалт мөн. Цахилгаан станц зэрэгт ажил хаях нь улс орны аюулгүй байдалд хохирол учруулахуйц хүнд байдал бий болгож болно. Энэ нөхцөлд онц байдал зарлаж хуулиар ажил хаялтыг зогсоож болно шүү дээ гэв.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Товуусүрэн Цэцийн хуралдаанд оролцож өгсөн тайлбартаа: Бид яригдаж байгаа асуудлыг тал бүрээс нь авч үзэх хэрэгтэй. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т ажил хаяхыг хойшлуулах асуудлыг улс орны аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөтэй холбож тогтоосон. Тэгэхлээр энэ нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-ын: "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэсэн заалттай шууд холбоотой. Нөгөөтэйгүүр хуулийн аль аль заалтад ажил хаях эрх хадгалагдаж байна шүү дээ. Ажил хаях асуудлыг хойшлуулж байгаа нь зөвхөн маргаан зохицуулах, маргагчдыг эвлэрүүлэх, маргааны зүйл болсон асуудлыг боломжоор хангах арга хэмжээ авах л хугацаа юм гэв.

Хянавал:

1. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтууд нь иргэдийн ажил хаях эрхийг хязгаарлах юм уу хориглоход бус, харин маргагч талуудыг эвлэрүүлэх, нэгэнт гаргасан хамтын маргааныг зохицуулахад чиглэгдсэн процессын ажиллагааг тусгасан заалтууд байна.

2. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн заалттай Хөдөлмөрийн маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтууд агуулгаараа нийцэж байна.

3. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг нь үйлчлэх хүрээний хувьд гагцхүү онц болон дайны байдал зарласан тохиолдлыг хамрах нь уг хэсгийн агуулгаас харагдаж байна. Иймд Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтууд нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах дүгнэлт:

1. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай харилуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

ДАРГА
ГИШҮҮД

Л.БААСАН
Ц.ЦОЛМОН
Н.ЖАНЦАН
Д.ЧИЛХААЖАВ
Ч.ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын ёсоор, "Сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлалсугай.

2. Энэхөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн жилийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж байхыг Үндэсний хөгжлийн газар /Ч. УЛААН/, Сангийн яам /Э. БЯМБАЖАВ/, Шинжлэх ухаан, боловсролын яам /Н. ӨЛЗИЙХУТАГ/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг Засгийн газарт жил тутам тайлагнаж байхыг Шинжлэх ухаан, боловсролын яам /Н. ӨЛЗИЙХУТАГ/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — П. ЖАСРАЙ
Шинжлэх ухаан, боловсролын сайд — Н. ӨЛЗИЙХУТАГ

Засгийн газрын 1995 оны 46 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ" ХӨТӨЛБӨР / 1995-2000 он/

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, хамрах хүрээ

1.1. Удиртгал

Улс орны хөгжил нь хүний хүчин зүйлээс хамаарах бөгөөд хүний хөгжлийн үндэс нь хүүхэд ахуй насандаа бүрэлдэн тогтдогийг

харгалзан хөгжлийн хэтийн төлөвийн талаар явуулах төрийн бодлогын салшгүй хэсэг нь хүүхэд багачуудын хүмүүжил, боловсролын асуудалд чиглэгддэг. Харьцангуй өргөн уудам нутаг дэвсгэртэй, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон, хүн ам цөөн, нийт хүн амын 23 хувь нь сургуулийн өмнөх насны хүүхэд эзэлдэг, эмэгтэйчүүдийн олонхи нь хөдөлмөр эрхэлдэг, хүүхэд ихэвчлэн 8 насандаа сургуульд орж боловсрол олж эхэлдэг Монголорны хувьд хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бодлогыг цэгцтэй, тодорхой чиглэлээр хэрэгжүүлэх нь нэн ач холбогдолтой юм.

Хүүхдэд аливаа зүйлийг амархан тусгаж хүлээн авах, танин мэдэхийн оргилуун хүсэл эрмэлзэл бий болох идэвхтэй байдал 5-7 насандаа илүүтэй илэрдэг бөгөөд энэ үед тэдний хүмүүжил, төлөвшилд нөлөөлөхөд хялбар байдаг учир хөгжингүй орнууд хүүхдийг 5-6 насанд нь сургуульд элсүүлж сургадаг байна. Хөгжингүй орнуудын ерөнхий боловсролын сургуулийн 1,2 дугаар ангийн хүүхдийн сургалтын хөтөлбөр нь манай цэцэрлэгийн хүүхдийн ахлах, бэлтгэл бүлгийн хүмүүжил, сургалтын хөтөлбөртэй төстэй байдаг байна. Гэвч цэцэрлэгийн хүрээнд явагддаг хүмүүжил, сургалтын ажилд хүүхдийг хамруулж чадахгүй байгаа нөхцөлд бага насны хүүхдийг идэвхтэй хөгжлийн үед нь зохих ёсоор хөгжүүлж төлөвшүүлэх тааламжтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд эцэг эх, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, олон нийтийн анхаарлыг хандуулах шаардлагатай байгааг харгалзан үзэж энэ талаар баримтлах зорилт, бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг хөтөлбөрт тусгалаа.

Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдэд бага наснаас нь сурах, мэдэх эрмэлзэл төрүүлж, сурах үйл ажиллагааны анхны чадвар дадал эзэмшүүлэх, сургуульд амжилттай суралцах үндсэн суурийг тавьдгаараа онцгой ач холбогдолтойг үндэс болгож хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, сэтгэцийн чадварыг багаас нь хөгжүүлж, тэднийг хүрээлэн байгаа байгаль, нийгмийн талаар зохих ойлголттой, тоолох, бодох, зурах, урлан бүтээх, дуулах, бүжиглэх, хөгжимдөх анхны мэдэгдэхүүнтэй болгох, өнгө, хэлбэр дүрс, хэмжигдэхүүн, орон зай, цаг хугацааны төсөөлөл олгох, ардын зан үйл, ёс горимыг эрхэмлэдэг, орчныхоо эд юмс, хүмүүс, уе тэнгийнхэнтэйгээ зөв харьцдаг болгон хөгжүүлж хүмүүжүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Сургуулийн өмнөх боловсролыг олгож ирсэн үндсэн байгууллага-цэцэрлэгүүд барилга, бусад материаллаг баазын хувьд

бэхжиж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдан, хүмүүжил сургалтын ажлын агуулга, арга зүй боловсронгуй болж хөгжлийн зохих түвшинд хүрсэн хэдий ч зах зээлд шилжиж буй өнөөгийн нөхцөлд цэцэрлэгүүдийн хэвийн ажиллагаа алдагдаж, түүнд хамрагдах хүүхдийн тоо цөөрсөөр байгаа нь өмнө олсон амжилтаасаа ухрахад хүргэж байна. Цэцэрлэгийн тоо 1994 оныг 1990 онтой харьцуулахад 16,6%, түүнд хамрагдах хүүхдийн тоо 38,4%-иар буурчээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилд дараахь бэрхшээл, дутагдал оршиж байна:

-сургуулийн өмнөх боловсролын үнэ цэнийг хүмүүс тэр бүр гүнзгий мэдрэхгүй, ухаарахгүй байгаа;

-цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох ажил урсгалаар явж ирсэн;

-гэр бүлд хүүхдийг хөгжүүлж, хүмүүжүүлж ирсэн уламжлалыг орчин үеийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэслэлтэй хослуулан хэрэглэж чадаагүй;

-манай орны хүн амын олонхийн амьжиргааны түвшингээс шалтгаалж цэцэрлэгт зарцуулж байгаа хөрөнгийн эцэг эхэд ногдох хэсгийг нэмэгдүүлэх боломжгүй байгаа;

-төсөв хүрэлцэхгүйгээс орон нутгийн зарим цэцэрлэгийн хэвийн ажиллагаа алдагдсан;

-сургуулийн өмнөх насны хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн нэмэгдэл арга хэмжээнд хөрөнгө гаргах боломж хязгаарлагдмал байгаа эдгээр болно.

1.2. Сургуулийн өмнөх боловсролын талаар явуулах төрийн бодлого, зорилт

Хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох талаар төрөөс явуулах бодлогын зорилт нь сургуулийн өмнөх боловсролыг зөвхөн цэцэрлэгийн хүмүүжил сургалтын ажилтай холбон үзэж ирсэн явцуу ойлголтыг өөрчилж, нийт хүүхдийг хөгжүүлэхэд эцэг эх, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, төр засаг, олон түмний хүч анхаарлыг төвлөрүүлэхэд оршино.

Хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг төв, суурин газар /нийслэл, аймаг, сумын төв/-т "цэцэрлэг-гэр бүл", хөдөөд "гэр бүл-цэцэрлэг" гэсэн хувилбараар хэрэгжүүлэх чиглэл баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Дээрх хэлбэрээр сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг зохион байгуулахад цэцэрлэг нь тухайн

орон нутаг /тойрог/-ийнхаа сургуулийн өмнөх насны хүүхдийг хөгжүүлэх ажлыг хариуцах төв байгууллага байх ёстой. Өөрөөр хэлбэл "цэцэрлэг-гэр бүл" гэсэн хэлбэрээр төв, суурин газрын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгоход цэцэрлэг зонхилох үүрэгтэй байж, эцэг, эхчүүд дэмжлэг туслалцаа үзүүлэхээр, "гэр бүл-цэцэрлэг" гэсэн хэлбэрээр малчдын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгоход хүүхэд гол төлөв гэр бүлийн орчинд хөгжиж төлөвших, сум /баг/-ын цэцэрлэгээс эцэг эх, хүүхдэд мэргэжлийн туслалцаа үзүүлж, хүүхдийг богино хугацаагаар цэцэрлэгийн хүмүүжил, сургалтын ажилд хамруулж байхаар зохион байгуулахад чиглэх юм. Хүүхдийг багаас нь тодорхой хугацаагаар цэцэрлэгийн хүмүүжил, сургалтын ажилд хамруулах нь тэднийг хамтолны дунд зохион байгуулалттай үйл ажиллагаанд оролцуулж сургах, нийгмийн талаас нь төлөвшүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

"Цэцэрлэг-гэр бүл", "гэр бүл-цэцэрлэг" гэсэн хэлбэрээс гадна хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг эцэг, эх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд санаачилгаараа сайн дурын холбоо, өрхийн цэцэрлэг зэрэг арга хэлбэрээр хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг гүйцэтгэгч нь нутгийн захиргааны болон боловсролын асуудал эрхэлсэн байгууллагатай сургалтын агуулга, хөтөлбөрийг тохиролцсон байна.

Хөтөлбөрөөр дараахь зорилтыг шийдвэрлэнэ:

-нүүдлийн болон суурин соёл иргэншлийн нөхцөлд тохирсон сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог бий болгох;

-сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил, сургалтын ажлын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, хүмүүжил, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах;

-төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх насны боловсролын байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжих;

-хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгоход эцэг, эхийн үүргийг нэмэгдүүлэх, өрх гэрийн сургалтыг дэмжин өргөжүүлэх;

-сургуулийн өмнөх боловсролын байгууллагын боловсон хүчний шинэ нөхцөлд ажиллах чадавхийг сайжруулах.

1.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

-сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог 8/ Э-аас дээш хувьд хүргэх;

-нийт хүүхдийн 75-аас дээш хувь нь сургуульд элсэн суралцах бэлтгэл хангалтын түвшингийн жишиг /стандарт/-ийг хангасан байх;

-төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага, түүнд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх;

-хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох талаар нутгийн захиргааны байгууллагаас авсан чиглэлийг биелүүлэх ажлын агуулга, арга барилын шинэчлэл;

-тоглоом наадгай, хүмүүжил сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийн түвшин.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн зарчмыг баримтална:

-хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах;

-төр, засгийн болон Засгийн газрын бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, эцэг, эхчүүд, гадаадын хандивлагчдыг сургуулийн өмнөх насны хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад ергөн оролцох боломжоор хангах, тэдний олон талт үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хөрөнгө, хүчийг зохистой хуваарилах;

-хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд гүйцэтгэх;

-сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн өнөөгийн түвшинг хадгалахын зэрэгцээ олон хувилбартай шинэ тогтолцоог бүрдүүлэх;

-сургуулийн өмнөх боловсролыг олгох ажил гэр бүл, хүүхэд бүрт хүртээмжтэй байх.

1.4. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь зарчмаар шийдвэрлэнэ:

-төрийн өмчийн цэцэрлэгийн санхүүжилтийг захзээлийн харилцааны нийтлэг зарчимд нийцүүлэн зохицуулах, цэцэрлэгүүдийн хүч чадлыг бүрэн ашиглах, үйлчлэх хүрээ, үүргийг нэмэгдүүлэх /хагас өдрийн, цагийн, улирлын ажиллагаатай болон нүүдлийн

журмаар ажиллуулах зэрэг/ чиглэлээр хүүхдэд зориулсан хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах;

-бага насны хүүхдийг хөгжүүлж хүмүүжүүлэхэд тухайлбал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг санхүүжүүлэхэд бодитой туслалцаа үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд төрөөс эдийн засгийн урамшуулал, дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох;

-хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар гадаад орон, олон улсын байгууллагаас авах тусламж дэмжлэгийг өргөтгөж, санхүүжилтийн найдвартай эх үүсвэрийг бий болгох.

Хоёр. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтолцоо

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь дараахь тогтолцооноос бүрдэнэ:

-"Сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг Шинжлэх ухаан, боловсролын яам хариуцаж, сургуулийн өмнөх боловсролын тодорхой асуудлаар холбогдох яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан зохион байгуулна;

-орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцаж, удирдлага, зохион байгуулалт, хяналтын үүргийг гүйцэтгэх бөгөөд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсролын төв /Боловсролын газар/ буюу боловсролын асуудал хариуцсан ажилтан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна;

-дэвсгэр нутагтаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

2.2. Засгийн газрын бус байгууллага, олон түмний оролцоо

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг дараахь байдлаар оролцуулахыг дэмжинэ:

-Засгийн газрын бус байгууллагууд нь тодорхой төсөл, бусад ар-

га хэмжээг дангаараа болон олон улсын хийгээд Засгийн газрын бус бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, олон түмнийг өргөн оролцуулах;

-аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллагчдынхаа сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, тэдний цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг хөгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

-эцэг, эх үр хүүхдээ зөв хөгжүүлэх, хүмүүжүүлэхэд санаачлага, хүч чармайлт гаргаж, анхдагч үүрэгтэйгээр оролцох.

2.3. Олон улсын хамтын ажиллагаа

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дотоодын нөөц боломцоог дээд зэргээр ашиглахын зэрэгцээгээр хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг шийдвэрлэхэд хоёр талын болон олон улсын хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэн хөгжүүлж дараахь арга хэлбэрээр ажиллана:

-хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад орон, олон улсын байгууллагаас үзүүлэх тусламж дэмжлэгийг Монгол Улсын боловсролын шинэчлэлд үзүүлж буй туслалцааны нэг бүрэлдэхүүн хэсэг болгон зохион байгуулах;

-гадаадын тусламж дэмжлэгийг үр дүнтэй ашиглах зорилгоор Шинжлэх ухаан, боловсролын яамны дэргэд орон тооны бус Зохицуулах зөвлөл ажиллуулах.

2.4. Хэрэгжүүлэх хугацаа

Энэ хөтөлбөрийг дунд хугацаанд буюу 1995-2000 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн бүрэлдэхүүн

Сургуулийн өмнөх боловсролын шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээ нь дараахь үндсэн хэсгээс бүрдэнэ:

1/сургуулийн өмнөх боловсролын тогтолцоо, агуулга, арга зүйг боловсронгуй болгох;

2/төрийн бус өмчид су урилсан сургуулийн өмнөх боловсролын йгууллагыг дэмжих;
3/сургуулийн өмнөх б оловсролын төрийн өмчийн байгууллагын л ажиллагааг сайжру улах;
4/бага насны хүүхди йн гэрийн сургалтыг дэмжих;
5/нийгмийн эмзэг хө сэгт багтах бага насны хүүхдийг халамжлан ргуулийн өмнөх бо ловсрол олгох сургалтад хөнгөлттэй нөхцө өр хамруулах;
6/малчдын хүүхд айг сургуулийн өмнөх боловсролын сургалтад мруулах;
7/сургуулийн ө мнөх боловсролын байгуулагын боловсон хүч йг бэлтгэх, чадв аржуулах;
8/сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэ үн тоглоом наа дгайн хангамжийг сайжруулах.

3.1. Сур гуулийн өмнөх боловсролын тогтолцоо, аг /уулга, арга зүйг боловсронгуй болгох

Өнөөг хүрт эл манайд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуу йн өмнөх б оловсрол олгох оновчтой арга хэлбэр бүрэлдэн тог огүй байг а. Сургуульд элсэн суралцах хүүхдийг 1 сарын бэлт лд хамру улдаг боловч энэ нь тэднийг багаас нь системтэй хөг үүлж те левшүүлэх, сургуульд элсэхийн өмнө хүүхдийн хөгж йн түвш ингнь жигдрүүлэхэд тедний лэн нөлөөлж чадахгүй байна. үнээс г алтгаалан нэгдүгээр ангид харилцан адилгүй хөгжлийн вшин тэй хүүхэд элсч багшийн ажиллагаанд хүндрэл учрах, лтгэ л хангагдаагүй зарим хүүхэд сургуулиас тавигдах шаард гыг биелүүлж чадахгүй байх, цэцэрлэгээр дамжин орсон хүүх йн хөгжлийг саатуулах зэрэг сөрөг үр дагавар байнга илэрч йна.

Х етөлбөрийн энэ хэсэг нь сургуулийн өмнөх боловсролыг нийт /хдэд олгох олон хувилбарт шинэ тогтолцоог бий болгох, төв, урин газрын нөхцөл бүрдсэн орчноос эхлэн хүүхдийн сургуульд рох насыг /6 нас хүртэл/ урагшлуулах бэлтгэлийг хангах, үүнтэй олбо гдох судалгаа туршилт явуулах, сургуулийн өмнөх боловс олын агуулга, арга зүйг боловсронгуй болгоход чиглэнэ.

А. З орилтыг шийдвэрлэх

Сур гуулийн өмнөх боловсролын тогтолцоо, агуулга, арга зүйг оловс ронгуй болгох зорилтыг дараахь үндсэн дээр шийдвэрлэнэ:

-сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог шинэчлэн төлөвшүүлэх;

-сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил сургалтын ажлын агуулга, арга зүйг боловсронгуй болгох;

-хүүхдийн сургуульд элсэх насыг урагшлуулах зарим бэлтгэлийг хангах.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоо, агуулга, арга зүйг боловсронгуй болгох зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-төв, суурин газар /нийслэл болон аймаг, сумын төв/-ын болон хөдөө /малчид/-гийн бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, тэднийг сургуульд бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх;

-сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэц, бие бялдрын онцлогийг гүнзгийрүүлэн судлах;

-хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох шалгуурыг боловсруулан гаргах;

-хүүхдийн сургуульд элсэх насыг урагшлуулах чиглэлээр хүмүүжил, сургалтын ажлын агуулгад өөрчлөлт оруулах, туршилт явуулах;

-хүүхдийг сургуульд элсэх бэлтгэлийн түвшингийн жишиг /стандарт/-ийг тогтоох;

-цэцэрлэгт "хүүхэд төвт" хүмүүжил, сургалтын үйл ажиллагааг нэвтрүүлэх;

-цэцэрлэгийн багш нарын хүүхэдтэй ажиллах арга барил, ур чадварыг сайжруулах, шинэчилсэн агуулгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлууд зохион байгуулах.

3.2. Төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг дэмжих

1990 он хүртэл аж ахуйн нэгж, байгууллагын 130 цэцэрлэгт 3000 гаруй хүүхэд сурч хүмүүжиж байсан бол 1994-1995 оны хичээлийн жилд зөвхөн Улаанбаатар төмөр зам, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр л байгууллагынхаа хөрөнгөөр 3079 хүүхэд бүхий 23 цэцэрлэгийг ажиллуулж байна.

Өмчийн олон хэлбэр үүсэн бий болж буй өнөөгийн нөхцөлд төөөс

өргөжүүлэх, хүүхдийн төлөө анхаарал тавьж хөрөнгө зарцуулагчдад эдийн засгийн урамшуулал, дэмжлэг үзүүлэх механизм бий болгох, түүнчлэн цэцэрлэгийн насны хүүхдийг хөгжүүлж хүмүүжүүлэхэд санаачилга гарган ажиллаж байгаа эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, иргэд, байгууллагыг хөхүүлэн дэмжих тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг дэмжих зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагад үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх;

-хүүхдийн төлөө хөрөнгө, хүчээ зориулан ажиллагчдыг дэмжих.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ.

Төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг дэмжих зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-хүүхдийн төлөө хөрөнгө хуримтлуулан санаачлагатай ажиллагчдад эдийн засаг, боловсон хүчний талаар дэмжлэг үзүүлэх;

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын төрийн бус байгууллагын санхүү, материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-төрийн өмчийн цэцэрлэгийн байрыг зориулалтаар нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ашиглуулах зарчмыг тогтоон, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

-төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагын боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

3.3. Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах

1994-1995 оны хичээлийн жилд нийт 60,9 мянган хүүхэд бүхий 696 цэцэрлэг ажиллаж байгаагийн 57,9 мянган хүүхэд бүхий 673 цэцэрлэг нь төрийн өмчийнх байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн тоо, түүнд хамрагдах хүүхдийн тоо 1994 оныг 1990 онтой харьцуулахад ихээхэн буурлаа.

Цэцэрлэгээр дамжин сургуульд элсэн суралцаж буй хүүхэд гэрийн нөхцөлөөс сургуульд элсэн суралцаж байгаа хүүхдээс сэтгэц, хэл ярианы хөгжил, нийгмийн төлөвшлөөр давуу байдгийг амьдрал

нотлон харуулж байгааг харгалзан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүч чадлыг бүрэн ашиглах, үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Цэцэрлэгүүдийн барилгыг бүрэн хүч чадлаар нь ашиглах тохиолдолд цэцэрлэгт 90 гаруй мянган хүүхдийг хамруулах боломжтой, боловсон хүчний бэлэн нөөц бүрэлдсэн байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-цэцэрлэгүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

-санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан тогтоож, аж ахуй, хангамжийн хувьд бэхжүүлэх;

-цэцэрлэгт хамрах хүүхдийн хүрээг өргөтгөх;

-сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагчдын шинэ нөхцөл байдалд ажиллах чадамжийг сайжруулах.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах арга хэмжээг өргөжүүлэх;

-цэцэрлэгийн барилгыг зориулалтын дагуу ашиглах зохицуулалтын арга хэмжээ авах;

-төрийн өмчийн цэцэрлэгүүдийг санхүүжүүлэх журмыг боловсронгуй болгох;

-цэцэрлэгийн үйл ажиллагааг тухайн орон нутаг /дүүрэг, сум, баг/-ийн сургуулийн өмнөх насны хүүхдийг хөгжүүлэх төв болгох чиглэлээр өөрчлөн зохион байгуулах;

-сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлага, төлөвлөлт, хяналтын тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгох;

-цэцэрлэгүүдийн туслах аж ахуйг бэхжүүлэх;

-хүүхдийн хоол, хүнсний хангамжийг сайжруулах;

-эмзэг хэсэгт багтах хүүхдүүдийн цэцэрлэгт хамрах хүрээг өргөжүүлэхэд орон нутгийн халамжийн сан, хүмүүнлэгийн туслалцаа, буяны хандивыг ашиглах.

3.4. Бага насны хүүхдийн гэрийн сургалтыг дэмжих

Сургуулийн өмнөх насны хүүхдийн олонхи нь гэрийн нөхцөлд өсч хүмүүжиж байгаа манай орны өнөөгийн нөхцөлд бага насны хүүхдийг хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэх талаархи эцэг, эхчүүдийн мэдлэг, арга барилыг сайжруулах шаардлагатай байна. Эцэг, эхчүүдийн нэг хэсэг нь хүүхдээ аль болох багаас нь хөгжүүлэх, авьяас билгийг нь нээн илрүүлэхэд анхаарч бүхийл нөөц боломжоо дайчлан ажиллаж байхад нөгөө хэсэг нь хүүхэддээ хайхрамжгүй хандах, тэднийг цэцэрлэгт даатгаад орхих явдал цөөнгүй гарч байгаагийн зэрэгцээгээр хүүхдийн материаллаг хэрэгцээг голлоод оюуны хэрэгцээг нь анхаарахгүй байгаа зэргээс бага насны хүүхдийн хөгжлийн түвшин харилцан адилгүй байна.

Ялангуяа залуу эцэг, эхчүүдийг бага насны хүүхэдтэй ажиллах, тэднийг хөгжүүлж хүмүүжүүлэх арга барилд сургах талаар анхаарч эцэг, эхэд зориулсан гарын авлага, зөвлөмж гаргах, гэрийн сургалтыг дэмжсэн радио, телевизийн нэвтрүүлгийг өргөтгөх, гэр бүлд хүүхдийг хөгжүүлж хүмүүжүүлж ирсэн уламжлалыг сурган хүмүүжүүлэх ухааны онол, практиктай хослуулан баяжуулж хэрэглэж сурахад тусламж дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Бага насны хүүхдийн гэрийн сургалтыг дэмжих зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-эцэг, эхчүүдэд бага насны хүүхэдтэй ажиллах, сурган хүмүүжүүлэх арга барил эзэмшихэд нь туслах;

-гэрээр хүмүүжиж буй бага насны хүүхдийг зохих түвшинд нь хүртэл хөгжүүлэх, сургуулийн өмнөх боловсрол эзэмшихэд туслах.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Бага насны хүүхдийн гэрийн сургалтыг дэмжих зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-бага насны хүүхдийг хөгжүүлж сургуульд бэлтгэх талаар эцэг, эх, иргэдээс гаргаж буй үүсгэл санаачлагыг дэмжих;

-эцэг, эхэд хүүхдийнхээ хөгжлийн түвшинг тодорхойлох анхдагч мэдлэг, арга барил эзэмшүүлэх;

-хүүхдээ хэрхэн хөгжүүлэх талаар эцэг эхэд зориулсан гарын авлага, зөвлөмж гаргах;

-сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт-таниц мэдэхүйн телевизийн нэвтрүүлэг явуулах;

-цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд, ялангуяа хөдөөгийн хүүхэд, тэдний эцэг, эхэд зориулсан радио нэвтрүүлгийн хүрээг өргөтгөх;

-эцэг, эхэд сурган хүмүүжүүлэх зөвлөлгөө өгөх албыг боловсролын төв буюу тодорхой цэцэрлэг түшиглүүлэн зохион байгуулах;

-хүүхдийг гэр бүлд сурган хүмүүжүүлж ирсэн уламжлалыг судлах, тэдгээрийг дэлгэрүүлэх.

3.5. Нийгмийн эмзэг хэсэгт багтах бага насны хүүхдийг халамжилж сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтад хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах

Ядуу, бага орлоготой айл өрхийн хүмүүс өдөр тутмын хоол унд, наад захын хэрэгцээндээ түүртэн хүүхэддээ тавих анхаарал халамжаа орхигдуулах хандлага их байна. Манай орны өрх тэргүүлсэн эхчүүдийн 51,5 хувь нь хөдөөд, 48,5 хувь нь хот, сууринд амьдарч байгаа бөгөөд тэдний 39,7 хувьд 0-3 насны, 36,3 хувьд нь 3-5 насны хүүхэд зонхилж байна.

Түүнчлэн ухаан мэдрэлийн согогтой, дүлий буюу сонсгол муутай, ха-раагүй 0-6 насны 1300 гаруй хүүхэд бүртгэгдээд байгаа боловч эдгээр хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол эзэмших сургалт, хүмүүжлийн хүрээнд хамрагдаж чадахгүй байна.

Аймгийн төв, нийслэлийн дүүргүүдэд халамжийн цэцэрлэг, бүлгүүд нээж, түүнд бүтэн ба хагас өнчин хүүхэд, ядуу айл өрхийн хүүхдийг хамруулан хүүхдийн хоолны зардлын эцэг эхэд ногдох хэсгийг нь орон нутгийн халамжийн сангаас гаргаж байгаа боловч энэ арга хэмжээнд нийгмийн эмзэг хэсгийн бага насны хүүхдийн цөөн хэсгийг л хамруулж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Нийгмийн эмзэг хэсэгт багтах бага насны хүүхдийг халамжилж сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтад хөнгөлттэй нөхцөлөөр хамруулах зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-бүтэн ба хагас өнчин хүүхэд, ядуу ба нэн ядуу өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтад хамруулах нөхцөлийг бүрдүүлэх;

-сургуулийн өмнөх насны тахир дутуу, эмгэг согогтой хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийгмийн эмзэг хэсэгт багтах бага насны хүүхдийг хөгжүүлэх зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-тахир дутуу, эмгэг согогтой хүүхэд, түүнчлэн бүтэн ба хагас өнчин, ядуу, нэн ядуу өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийн судалгааг аймаг, сум, нийслэл, дүүргээр нарийвчлан гаргаж тэднийг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалт, хүмүүжлийн ажилд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах арга хэмжээ авах;

-тахир дутуу, эмгэг согогтой сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын агуулга, арга хэлбэрийг туршин тогтоох;

3.6. Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах

Манайд малчин өрх нийт өрхийн дотор 30-аад хувийг эзэлдэг, тэд харьцангуй олон /3-7/ хүүхэдтэй, хүүхдүүд нь 0-2 насандаа эцэг, эхийн асрамжинд төрж, 3-5 насандаа хурга, ишиг эргүүлэх, аргал түлш ойртуулах зэргээр эцэг, эхдээ тус дэм болж, 5 наснаасаа мал хариулах, морь ойртуулах зэргээр гэр ахуйн ажилд нэлээд идэвхтэй бие даан оролцож эхэлдэг онцлогтой.

Малчид хүүхдээ бага наснаас нь өөрсдийн хараа хяналтад ойр байлгаж, хамтын хөдөлмөрт оролцуулан, тэднийг багаас нь ажил хөдөлмөрөөр дамжуулан хөгжүүлж, ёс заншил, нүүдэлчний соёлын өвөөр хүмүүжүүлж ирсэн уламжлалтай боловч хүүхдүүд нь 8,9 нас хүртлээ чиглэсэн зорилготой, системтэй сургалтад хамрагдаж чадахгүй байгаагаас сурах үйл ажиллагааны энгийн дадал эзэмшээгүй, нийгэм, сэтгэл зүйн хувьд бэлтгэгдээгүйгээр сургуульд элсэн суралцаж байна. Энэ нь хүүхэд сургуульд ороод сурах үйл ажиллагаанд идэвхгүй хандах, сурлагаар хоцрох, цаашилбал сургууль завсардахад түлхүү нөлөөлж байна. Тухайлбал, дээрх шалтгаанаас сүүлийн 3 жилд жил тутам малчдын 6000-7000 хүүхэд нэгдүгээр ангид элсэлгүй үлдэж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Малчдын хүүхдийг хөгжүүлэх, тэднийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-малчдын хүүхдийг хөгжүүлэх, сургуульд бэлтгэх ажлын агуулга, арга зүйн үндсийг боловсруулах;

-малчдын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох тогтолцоог бүрдүүлэх.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

-сургуулийн өмнөх насны малчдын хүүхдийн судалгааг аймаг, сум, багаар нарийвчлан гаргах;

-малчдын хүүхэд сургуульд элсэн суралцахад саад болж байгаа асуудлыг тогтоох;

-малчдын хүүхдийг хөгжүүлэх, сургуульд бэлтгэх сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулан гаргаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

-малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх ажлын хэлбэр, зохион байгуулалтыг туршин тогтоох;

-малчдын хүүхдэд зориулсан дасгалын дэвтэр, сургалтын хэрэглэгдэхүүн, эцэг, эхэд зориулсан зөвлөмж, гарын авлага боловсруулан гаргах;

-зайны сургалтын тохиромжтой хэлбэрийг туршин тогтоох.

3.7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын боловсон хүчний хөгжлийг хангах

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшлах, удирдах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах талаар манай оронд багагүй туршлага хуримтлагдаж, боловсон хүчний хангамж, хүрэлцээ харьцангуй өндөр түвшинд хүрсэн чгэсэн тэдгээр боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах талаар хийж байгаа ажлыг боловсронгуй болгож энэ чиглэлийн боловсон хүчнийг дэмжих, шинэ нөхцөл байдалд ажиллах чадварыг сайжруулах нь чухал гэж үзэж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын боловсон хүчний хөгжлийг хангах зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-сургуулийн өмнөх боловсролын удирдах, багшлах боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

-сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгчдийг давтан бэлтгэх;

-сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагчдын ажлын арга хэлбэрийг өөрчлөн шинэчлэх.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын боловсон хүчний хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/сургуулийн өмнөх боловсролын удирдах ажилтнуудыг давтан бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг дараахь чиглэлээр зохион байгуулна:

-сургуулийн өмнөх боловсрол олгох арга зам, сургуулийн өмнөх боловсролд олон түмний хүчанхаарлыг төвлөрүүлэх асуудлаар үндэсний семинар явуулах;

-хүүхдийн цэцэрлэг дэх "Хүүхэд төвт" үйл ажиллагаа гэсэн сэдвээр олон улсын семинар явуулах;

-"Төслийн удидлага", эрх зүй, эдийн засгийн асуудлаар удирдах ажилтнуудын сургалт хийх;

-хөгжингүй зарим орны сургуулийн өмнөх боловсролын агуулга, арга зүй болон багш бэлтгэх, давтан сургах, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай үйлдвэрлэх ажлын туршлага судлах;

-олон улсын хурал, семинар, зөвлөлгөөнд оролцох;

-багш бэлтгэдэг коллеж, их сургуулийн багш нарыг хөгжингүй орнуудад бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх ажил зохион байгуулах;

б/сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж буй багш сурган хүмүүжүүлэгчдийг давтан бэлтгэх, ур чадварыг нь сайжруулах ажлыг дараахь чиглэлээр зохион байгуулах:

-менежментийн онол, харилцааны сэтгэл зүй, хүүхдийн цэцэрлэг дэх хүүхэд төвт үйл ажиллагаа, хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, оношлох арга, хүүхдийг сургуульд бэлтгэх ажлын арга хэлбэр, холимог бүлэгт явуулах хүмүүжил, сургалтын ажил зэрэг сэдвээр давтан бэлтгэх сургалт зохион байгуулах;

-багш нарын мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох арга, шалгуурыг тогтоох;

-багшийн ур чадварын улсын уралдаан, сурган хүмүүжүүлэх уншлага зохион байгуулах;

-багш нарт коллежийн боловсрол олгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх.

в/багш, удирдах ажилтан бэлтгэх ажлын агуулга, технологийг дараахь чиглэлээр шинэчлэн боловсронгуй болгох:

-цэцэрлэгийн багшийн коллежийн эрдэм шинжилгээний ажлын хүрээг өргөтгөж, материаллаг баазыг нь бэхжүүлэх;

-цэцэрлэгийн багшийн коллежийн сургалтын агуулга, арга зүйг бакалаврын зэрэгтэй боловсон хүчин бэлтгэхээр шинэчлэн боловсронгуй болгох;

-Улсын багшийн их сургуулийн өмнөх салбарыг магистрийн зэрэгтэй удирдах боловсон хүчин бэлтгэхээр шинэчлэх.

3.8. Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг сайжруулах

Хүүхдийн хэл яриа, сэтгэц, ой тогтоолт, бие бялдар, бие даасан байдал, зан харилцаа гэхчилэн бүхий л талын хөгжил, төлөвшилд тоглоом ихээхэн ач холбогдолтой бөгөөд хүүхдийн тоглоом наадгай нь сурган хүмүүжүүлэх шаардлагыг хангасан, нэр төрөл нь олон байх тусмаа хүүхдийн хөгжлийн аятай орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Гэтэл манайд хүүхдийн тоглоом наадгайн дагнасан үйлдвэрлэл үндсэндээ байхгүй бөгөөд худалдааны шугамаар цөөн нэр төрлийн тоглоом наадгай гадаадаас оруулан ирж байна. Зарим сургууль, цэцэрлэг, иргэд цөөн тооны үндэсний тоглоом наадгай, гар урлалын зүйл хийж, мөн цэцэрлэгийн багш нар эцэг, эхийн оролцоотой зарим тоглоом наадгай хийж хүмүүжил, сургалтын ажилдаа ашиглаж байгаа нь тэр бүр хүрэлцэхгүй байна.

Үүнээс үндэслэн Монгол үндэсний тоглоом наадгайг сургуулийн өмнөх боловсролд оновчтой ашиглах онол, арга зүйн үндсийг боловсронгуй болгох, хүүхдийн тоглоом наадгайн зохион бүтээгч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх, сургалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулж тоглоом наадгайн үйлдвэрлэл зохион байгуулах, эхний ээлжинд хуванцар болон резинэн тоглоом наадгай үйлдвэрлэх тоног төхөөрөмж, технологийг шийдэх зэрэг ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Түүнчлэн сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан олон өнгийн зураг чимэглэлтэй, эдэлгээ сайтай ном, сургалтын хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх ажлыг өргөтгөх, хүүхдийн сургалтад хэрэглэгдэх баримлын шавар, өнгийн цаас, будаг, бийрний хангамжийг

сайжруулах талаар шуурхай арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

А. Зорилтыг шийдвэрлэх

Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг сайжруулах зорилтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

-хүүхдийн тоглоом наадгайн хангамжийг сайжруулах;

-сургуулийн өмнөх боловсролд ашиглах монгол үндэсний тоглоом наадгайн хүрээг тодорхойлох;

-сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан өнгөт зурагтай ном, үзүүлэн таниулга гаргах, материал, хэрэглэгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах.

Б. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг сайжруулах зорилтыг шийдвэрлэх үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-тоглоом наадгай үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх;

-сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан өнгөт зурагтай ном, сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом наадгайн жижиг үйлдвэрлэлийг гадаадын зээл тусламжаар байгуулах;

-хүүхдийн цэцэрлэгийн багш, эцэг, эхэд зориулсан тоглоом наадгай хийх аргачлал, зөвлөмж гаргах;

-хүүхдийн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн хийх арга ажиллагаанд цэцэрлэгийн багш нарыг сургах;

-тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх;

-цэцэрлэг, гэр бүлд байх тоглоом наадгайн үлгэрчилсэн жагсаалт гаргах;

-хүүхдийн ном, дуу, хөгжим, бүжиг, хүүхэлдэйн кино, диафильм, тоглоомын эх загвар зохиох улсын уралдаан зарлан дүгнэж байх.

Засгийн газрын 1995 оны 46 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	"Сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийг сурталчлах	1995 оноос	Шинжлэх ухаан, боловсролын болон мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
2.	Хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд төслүүдийг шалгаруулах, хэрэгжүүлж эхлэх	1995-1996 он	Шинжлэх ухаан, боловсролын болон хүн амын бодлого, хөдөлмөрийн, үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд
3.	Аймаг, нийслэлийн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	1995 он	Засаг дарга нар
4.	Төрийн бус өмчид суурилсан хүүхдийн цэцэрлэгийг дэмжих эрх зүйн актуудыг боловсруулан гаргах	1995-1996 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга нар, Хувийн үйлдвэрийн эздийн холбоо
5.	Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоо, агуулга, арга зүйг боловсронгуй болгохтой холбогдох ажлуудыг зохион байгуулах	1995-2000 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

6.	Бага насны хүүхдийг хөгжүүлэх асуудлаар эцэг, эхэд зориулсан сурталчилгаа, сургалт явуулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх	1995 оноос	Шинжлэх ухаан, боловсролын болон мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
7.	Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт-танин мэдэхүйн нэвтрүүлэг явуулах	1995 оноос	Шинжлэх ухаан боловсролын яам болон мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
8.	Бүтэн, хагас өнчин, тахир дутуу хүүхэд болон нийгмийн эмзэг хэсэгт багтах хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших нөхцөл бүрдүүлэх, төднийг төрийн өмчийн цэцэрлэгт хамруулан хөгжүүлэх	1995-2000 он	Шинжлэх ухаан, боловсролын болон хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сумын ядуурлыг бууруулах зөвлөл
9.	Бага насны хүүхдийг хөгжүүлэх үүсгэл санаачлагыг хөхүүлэн дэмжих	1995 оноос	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
10.	Малчдын хүүхдийг хөгжүүлэх, сургуульд бэлтгэх сургалтын агуулга, арга хэлбэрийг тушин тогтоох	1995-1996 он	Шинжлэх ухаан, боловсролын болон хүн амын бодлого, хөдөлмөрийн, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд, нутгийн захиргааны байгууллага
11.	Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлж чийрэгжүүлэх талаархи эх, эцгийн	1995 он	Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

	мэдлэг, чадварыг сайжруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулах		
12.	Хүүхдийн хоол, хүнсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	1995-1997 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага
13.	Цэцэрлэгийн багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох	1995-2000 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага
14.	Хүүхдийн дуу, хөгжим, уран зохиол, хүүхэлдэйн кино, жүжиг зэрэг хүүхдэд зориулсан уран бүтээлийн нэр төрлийг олшруулах, чанарыг сайжруулах	1995 оноос	Шинжлэх ухаан, боловсролын болон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
15.	Хүүхдийн урлаг, уран сайхан, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх	1995 оноос	Нутгийн захиргааны байгууллага
16.	Багш, эцэг, эх, бага насны хүүхдэд зориулсан гарын авлага, зөвлөмж, дасгалын дэвтэр, өнгөт зурагтай ном, үзүүлэн таниулах, тараах материал боловсруулан гаргах	1995-2000 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

17.	Хүүхдийн тоглоом наадгайн үйлдвэрлэлийг зохион байгуулах	1995-2000 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон Засгийн газрын бус байгууллага
18.	Хүүхдийн тоглоом наадгай хийх арга ажиллагаанд багш нарыг сургах, холбогдох гарын авлага, зөвлөмж боловсруулан гаргах	1995-1996 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
19.	Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг зориулалтаар нь ашиглах ажлыг зохицуулах арга хэмжээ авах	1995-1996 он	Шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын стандартчилал, хэмжил зүйн албаны дүрмийг хавсралтын ёсоор батлсугай.

2. Стандартчилал, чанарын баталгаажуулалт болон Хэмжлийн

нэгдмэл байдлыг хангах тухай монгол Улсын хуулиудыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын "Бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, стандартын хяналтыг хүчтэй болгох тухай" 1991 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 251 дүгээр тогтоол, "Дүрэм батлах тухай" 1992 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 89 дүгээр тогтоол, "Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв байгуулах тухай" Засгийн газрын 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1,2,3,4,5 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн "а" заалтыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын дарга Ч. УЛААН

Засгийн газрын 1995 оны 47 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН АЛБАНЫ ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Улсын стандартчилал, хэмжил зүйн албаны үндсэн зорилт нь "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1994 оны 94 дүгээр тогтоолд заасны дагуу стандартчилал, чанарын баталгаажуулалтын, хэмжил зүйн үйл ажиллагааг төв болон орон нутагт нэг байгууллага хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ (цаашид бүтээгдэхүүн гэнэ)-ний чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл мэнд, байгаль орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангахад тус дэмжлэг үзүүлэх зорилгоор стандартчилал, чанарын баталгаажуулалт, зорилт, хэмжил зүйг хөгжүүлэхэд оршино.

2. Улсын стандартчилал, хэмжил зүйн алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын "Үндсэн хууль", "Монгол Улсын хэмжлийн

нэгдмэл байдлыг хангах тухай хууль", "Монгол Улсын Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль", "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

ХОЁР. Улсын стандартчилал, хэмжил зүйн албаны зохион байгуулалт

3. Улсын стандартчилал, хэмжил зүйн алба нь Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв, түүнээс стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, хэмжил зүйн ажил эрхлэх эрх авсан аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвөөс бүрдэнэ.

4. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв нь стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын, аймаг, нийслэлийн төв нь тэдгээрийн Засаг даргын удирдлагын дор үйл ажиллагаагаа бие даан хариуцан явуулна.

5. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв нь аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төв нь төр, олон нийт шинжлэх ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчдөөс бүрдсэн орон тооны бус Зөвлөлтэй байна. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн зөвлөлийн гишүүдийг Засгийн газар, аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн зөвлөлийн гишүүдийг тухайн Засаг дарга томилно. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа дүрэм, хуралдааны дэгийг өөрөө батална.

7. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн зөвлөлийг Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн ерөнхий захирал толгойлох бөгөөд түүнийг стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын санал болгосноор Засгийн газраас томилно.

8. Зөвлөл нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцүүлэн шийдвэр гаргах бөгөөд түүнийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэх үүрэгтэй.

9. Хариуцсан сайд Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн дэд захирал, улсын ерөнхий байцаагч, улсын ахлах болон улсын байцаагч нарыг томилж, чөлөөлнө.

Хэмжил зүйн болон стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь батлсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10. Аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн захирал /улсын ахлах байцаагч/-ыг Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн удирдлагатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

11. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн ерөнхий захирал, аймаг, нийслэлийн төвийн захирал нь дотоод ажлын хүрээний асуудлаар тушаал гаргана.

12. Аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

13. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв нь тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг; аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төв нь тэмдэг хэрэглэх бөгөөд зөвлөл болон төвүүд нь албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ГУРАВ. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн үүрэг, эрх

14. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а)улсын хэмжээнд стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, хэмжил зүйн болон хэрэглэгчдийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, стандартчилсан загвар, гарын авлага боловсруулах, батлах, нийтийн хүртээл болгох;

б)улсын стандарт боловсруулах ажлыг эрхэлсэн стандартчиллын техникийн хороодыг байгуулах, тэдгээрийн дүрмийг баталж, үйл ажиллагааг нь зохицуулах, улсын стандартыг батлах, улсын бүртгэлд бүртгэх, хэвлэн олшруулах, олон нийтэд зарлан мэдээлэх;

в)стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай болон хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, хэрэглэгчдийн

эрх ашгийг хамгаалах хууль, бусад хууль тогтоомжийн холбогдох зааltын биелэлт, улсын стандартын мөрдөлт, экспорт, импортын бүтээгдэхүүний чанар, чанарын баталгаажуулалтын журам, хэмжил зүйн дүрэм, журмын мөрдөлтөд төрийн хяналт тавих;

г)бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтыг нэгдсэн арга зүй, зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэх, сорилт хийх;

д)хэмжлийн нэгж, нэгжийн эталоныг бий болгох асуудлыг боловсруулж холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хэмжлийн нэгжийн эталоныг хадгалах, ашиглах, харьцуулан дүйлгэж баталгаажуулах;

е)төрийн хяналт шалгалтад заавал хамрагдах хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт, тохируулга хийх;

ж)аймаг, нийслэлийн стандарчилал, хэмжил зүйн төв, мэргэжлийн байгууллагуудын сорилтын болон хэмжлийн лабораторыг итгэмжлэх;

з)монголын болон олон улс, бүс нутаг, гадаад улсын стандарт, норматив-техникийн бусад баримт бичгээр төв санг бүрдүүлэн төрөлжсөн архивын хэлбэрээр ажиллуулах;

и)зохих журмын дагуу төсөл боловсруулж эрдэм шинжилгээ, судалгаа, зохион бүтээлтийн ажил хийх;

к)эрхэлсэн асуудлаараа олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

л)хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийж баталгаажуулах;

м)эрхэлсэн асуудлаараа мэдээлэл-арга зүйн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн удирлагаар хангах;

н)үйл ажиллагааны явц, үр дүнг стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдад танилцуулж байхын зэрэгцээ олон нийтэд мэдээлж байх.

15. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв дор дурдсан эрх эдэлнэ:

а)хууль тогтоомжоор хүлээсэн эрх хэмжээний асуудлаар төрийн захиргааны байгууллагын үүргийг гүйцэтгэж холбогдох зардлаа Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай болон Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулиудад заасны дагуу улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх;

б)эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутгийн болон гадаад орнуудын мэргэжлийн байгууллагагуудтай харилцаж, тогтсон журмын дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;

в)холбогдох байгууллагын сорилтын болон хэмжлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, материаллаг баазыг харилцан тохиролцсоны үндсэн дээр ашиглах, мөн гадаад орны холбогдох лабораторид сорилт, харьцуулалт, шалгалт хийлгэх;

г)зохих журмын дагуу өөрийн харьяанд аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллах байгууллага байгуулах, дүрмийг батлаж удирдлагыг томилох, өөрчлөн байгуулах, татан буулгах;

д)хэмжих хэрэгсэлд засвар, тохируулга, баталгаажуулалт хийх зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн байгууллагад олгох;

е)аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төв болон мэргэжлийн байгууллагад чанарын баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх эрх олгох;

ж)хэмжих хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, худалдаалах болон бусдад хэрэглүүлэх, стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилтын тодорхой ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох;

з)стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээний талаар санал бэлтгэж хариуцсан сайдаар батлуулан мөрдүүлэх;

и)стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн дагуу хөгжлийн сан бий болгож зохих журмын дагуу ажиллуулах;

к)иргэдийн захиалга, гэрээний дагуу эрхэлсэн асуудлын тодорхой чиглэлээр төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалтыг явуулах;

л)улсын стандарт, арга зүйн материал болон олон улс, бүс нутаг, гадаад орны шаардлагатай стандарт, баримт бичгийг борлуулах;

м)мэргэжлийн хяналтын байгууллага, албадын үйл ажиллагааг стандарт, чанарын хяналтын төрийн хяналтын асуудлаар зохицуулах;

н)хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

ДӨРӨВ. Аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн үүрэг, эрх

16. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвөөс эрх авсан аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төв дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:

а)нутаг дэвсгэртээ энэ дүрмийн 14 дүгээр зүйлийн "в, г, м"-д заасан үүргийг гүйцэтгэнэ;

б)тухайн нутаг дэвсгэрт хэрэглэх улсын болон байгууллагын стандарт боловсруулах ажлыг удирдан зохицуулж бүртгэл хөтлөх;

в)стандартын салбар сан ажиллуулах;

г)тухайн нутаг дэвсгэрт хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, хэмжих хэрэгсэлд засвар, тохируулга, баталгаажуулалт хийх;

д)нутаг дэвсгэртээ бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх жагсаалтад орсон экспортын бараанд чанарын гэрчилгээ, импортын болон бусад бараа, бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд худалдах бөөнөөр үйлдвэрлэх зөвшөөрөл олгох;

е)анхдагч болон ажлын эталоныг хадгалах, ашиглах, тэдгээрийг улсын эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулах;

ж)тухайн нутаг дэвсгэрийн стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт, сорилт, төрийн хяналтын ажлыг нэгтгэн дүгнэж, дутагдал зөрчлийг арилгах, тайлан мэдээг тогтоосон журмын дагуу гаргаж Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвд ирүүлэх;

з)зохих стандартад тохироогүй чанар муутай буюу сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчийн талаар болон итгэмжлэгдсэн лаборатори, чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний тухай олон нийтэд мэдээлэх.

17. Аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төв дор дурдсан эрх эдэлнэ:

а)хууль тогтоомжоор хүлээсэн төрийн захиргааны байгууллагын үүргийг гүйцэтгэж холбогдох зардлаа Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай болон Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулиудад заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;

б)холбогдох байгууллагын сорилтын болон хэмжлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, материаллаг баазыг харилцан тохиролцсоны үндсэн дээр ашиглах, мөн гадаад орны холбогдох лабораторид сорилт, харьцуулалт, шалгалт хийлгэх;

в)иргэдийн захилга, гэрээний дагуу эрхэлсэн асуудлын тодорхой чиглэлээр төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалт явуулах;

г)олон улс, бүс нутаг, гадаад орны шаардлагатай стандарт, баримт бичиг болон улсын стандарт, арга зүйн материалыг борлуулах;

д)мэргэжлийн хяналтын байгууллага, албадын үйл ажиллагааг стандарт, чанарын төрийн хяналтын асуудлаар улсын ерөнхий байцаагчийн арга зүйн удирдлагын дор зохицуулах.

18. Стандартчилал, хэмжлийн нэгдмэл байдлын хангалт, чанарын баталгаажуулалт, сорилт, хэрэглэгчдийн эрх ашгийн хамгаалалт, хэмжил зүйн болон стандарт, чанарын төрийн хяналттай холбогдсон мэдээ, судалгаа бусад материалыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд нь Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвд хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

ТАВ. Стандарт, чанарын болон хэмжилзүйн төрийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх, хариуцлага

19. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а)заавал мөрдөх улсын стандарт, улсын стандартын заавал мөрдөх үзүүлэлт, шаардлагын мөрдөлтөд хяналт тавих;

б)импорт, экспортын бүтээгдэхүүний чанарт хяналт тавих;

в)бүтээгдэхүүний чанарын ангилал, зэрэглэл, сорилт, баталгаажуулалтын үнэн зөв байдлыг хянах;

г)чанарын гэрчилгээтэй болон бөөнөөр үйлдвэрлэх зөвшөөрөлтэй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж холбогдох арга хэмжээ цаг алдалгүй авахуулах;

д)стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах;

20. Хэмжил зүйн төрийн хяналтын улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж, хэмжил зүйн дүрэм, журам, хэмжил гүйцэтгэх аргачлалын мөрдөлтийг шалгах;

б)хэмжлийн нэгж нь хэрэглэхийг зөвшөөрсөн нэгжтэй тохирч байгаа эсэхийг шалгах;

в)хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, техникийн бэлэн байдал болон тухайн хэмжих хэрэгслийн ашиглалтын нөхцөл, баталсан загварын шаардлагад тохирч байгаа эсэхийг шалгах;

г)хэмжих хэрэгслийг баталгаажулахад ашиглаж байгаа эталоны техникийн байдалд хяналт тавих;

д)савласан бүтээгдэхүүнд тоон хэмжээний хяналт хийх.

21. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а)хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах, импортоор нийлүүлэх, улсын стандартад тохирохгүй хөдөлмөрийн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг зогсоох, уг бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу устгуулах;

б)стандартгүй бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах, эсвэл заавал мөрдөх улсын стандарт зөрчих буюу хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, улсын хилээр нэвтрүүлэхийг тус тус хориглох;

в)стандарт, чанарын төрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, мэдээ баримт авч танилцах, шаардлагатай багаж төхөөрөмж хэрэглэх;

г)илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих, хугацаатай үүрэг өгч, гүйцэтгэлийн хариуг тогтоосон хугацаанд авах;

д)стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх.

22. Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а)баталгаагүй буюу загвар нь батлагдаагүй, түүнчлэн батлагдсан загвартаа тохирохгүй байгаа хэмжих хэрэгсэл ашиглах, худалдах, бусдад хэрэглүүлэхийг хориглох;

б)баталгаажуулалтын хугацаа дууссан буюу буруу заалттай хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лац, тэмдгийг хүчингүй болгох, гэрчилгээг нь хураах;

в)иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах, бусдад хэрэглүүлэхдээ зохих журмыг зөрчсөн бол эдгээр ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтанд уг зөвшөөрлийг хүчингүй болгохыг шаардах;

г)хэмжил зүйн төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн зөрчлийг арилгах талаар заавал биелүүлэх хугацаатай үүрэг өгөх;

д)хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж, хэмжил зүйн дүрэм, журмыг зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх.

23. Стандарт, чанарын болон хэмжил зүйн төрийн хяналтын улсын байцаагч албан тушаалаа урвуулан ашигласан, төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд зориулан олгосон эд хөрөнгө, техник хэрэгслийг өөр зориулалтаар ашигласан бол түүнд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

24. Стандартчилал, чанарын баталгаажуулалт болон хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зохих хариуцлага хүлээлгэх тухай бүх шатны улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас баримтлах "Нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг 1 дүгээр хавсралтын, "Хүн амын ахуйн үйлчилгээний салбарыг дэмжин хөгжүүлэх үндсэн чиглэл" -ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн яам (Р. САНДАЛХАН), Худалдаа, үйлдвэрийн яам (Ц.ЦОГТ), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Дэд бүтцийн хөгжлийн яам (Р.САНДАЛХАН), Худалдаа, үйлдвэрийн яам (Ц.ЦОГТ), Үндэсний хөгжлийн газар (Ч.УЛААН)-т даалгах нь:

а)нийтийн аж ахуйн болон ахуйн үйлчилгээний салбарыг хөгкүүлэх үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний ойрын угацааны төлөвлөгөөг зарчмын хувьд зөвшөөрч, тус улсын эдийн асаг, нийгмийн хөгжлийн жил, жилийн үндсэн чиглэлд тодорхой рга хэмжээг дэс дараатай тусгаж хэрэгжүүлэх талаар холбогдох ам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт иглэл өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласугай төлөвлөгөөг хавсаргав);

б)нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг эрэгжүүлэхэд гадаад орон, олон улсын банк, санхүүгийн айгууллагаас үзүүлэх зээл тусламжийн хөрөнгийн тодорхой эсгийг ашиглах боломжийг судалж шийдвэрлүүлэх арга хэмжээ всугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд Л. ЭНЭБИШ

Дэд бүтцийн хөгжлийн сайд Р. САНДАЛХАН

Худалдаа, үйлдвэрийн сайд Ц. ЦОГТ

Засгийн газрын 1995 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Үндсэн чиглэлийн зорилго

Нийтийн аж ахуйн салбарыг хот байгуулалтын нэгдсэн бодлогын хүрээнд хүн амын нутагшил, бүс нутгийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөтэй нягт уялдуулан хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог зах зээлийн эдийн засгийн харилцааны нийтлэг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн ашиглалт, ажлын чанар, үйлчилгээний хүртээмж, түвшинг дээшлүүлэхэд үндсэн чиглэлийн зорилго оршино.

Нийтийн аж ахуйн салбарын хөгжлийн үндсэн шаардлага

-Хөгжлийн үндсэн шаардлагыг улс, бүс нутаг, аймаг, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд харилцан уялдаатайгаар авч үзэж, хэрэгжүүлэх арга зам, ээлж дараалал, хугацаа, шаардагдах хөрөнгийг оновчтой тодорхойлох;

-Уламжлалт нүүдлийн болон суурин маягийн соёл иргэншлийн онцлог, тухайн орон нутгийн газар зүйн байршил, байгаль цаг уурын нөхцөл, зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний зэрэг дэд бүтцийн хөгжлийн хандлага, орон нутгийн бодит нөөц бололцоонд тулгуурлан нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх оновчтой хувилбаруудыг боловсруулах;

-Салбарын хэмжээнд техник, технологийн шинэчлэлт хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлчилгээний түвшинг олон улсын стандартад хүргэх;

-Нийтийн аж ахуйд хэрэглэгдэх материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх замаар импортын нөлөөллийг багасгах.

Нийтийн аж ахуйн салбарын бодлого

1. Нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь салбарын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавина. Үүнд:

а)үндэсний хөгжлийн чиг баримтлал, хот байгуулалтын бодлоготой уялдуулан бүсийн болон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсруулах төслүүдэд нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгах шаардлагуудыг үндэслэлтэй тодорхойлох;

б)олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжийг ашиглан боловсруулах, хэрэгжүүлэх төслүүдийн өгөгдөл шаардлагыг тодорхойлох, уг төслүүдэд улсын экспертиз хийлгэх;

в)тодорхой чиглэлээр төслүүд шалгаруулах тендер зарлан дүгнэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах;

г)техникийн хөгжлийн үндсэн чиг хандлагыг тодорхойлж, техник технологийн шинэчлэлт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;

д)салбарын чиглэлийн эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлыг дэмжих, цаашдын үйл ажиллагааны чиглэл, шаардлагыг тодорхойлох, уялдуулан зохицуулах, үр дүнд хяналт тавих;

е)салбарын чиглэлийн улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалт, зураг төсөл, хайгуул судалгааны ажлыг уялдуулан зохицуулж, олон улсын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнд хяналт тавих;

ж)олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах, олон улс, бүс нутаг (тив)-ийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд орох арга хэмжээг зохион байгуулах;

з)салбарын мэдээллийн санг байгуулж мэдээлэх, төв, орон нутгийн холбогдох байгууллагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх ажил зохион байгуулах;

и)салбарын хэмжээнд мөрдөх норм, дүрэм, стандарт боловсруулах, батлах.

2. Нутгийн захиргааны байгууллага нь нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэлийг харгалзан нутаг дэвсгэрийнхээ хүн амын нутагшил, байгаль орчныг хамгаалах болон эрүүл ахуйн үндсэн шаардлага, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн иж бүрэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Үүнд:

а)өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээний хөтөлбөр боловсруулахад хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шаардлага, ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шаардлага, зах зээлийн тогтолцооны зарчмыг харгалзахын хамт орон нутгийн бодит боломж, нөөц бололцоонд тулгуурлах;

б)хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлагуудыг хангах чиглэлийг баримтлах;

в)нийтийн аж ахуйн байдалд судалгаа шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгсний үндсэн дээр хэрэгжүүлэх арга зам, ээлж дараалал, хугацаа, санхүүжүүлэх хэлбэр зэргийг оновчтой тодорхойлох;

г)салбарын чиглэлээр орон нутгийн нөөц бололцоонд түшиглэн сэлбэг, тоног төхөөрөмж жижиг, дунд болон хамтарсан үйлдвэр хөгжүүлэх замаар импортын нөлөөллийг багасгах;

д)улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын зээл, тусламжийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх төслийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр дүнг нь дээшлүүлэх;

е)нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийн түвшинг дээшлүүлэх, шударга өрсөлдөөн нэвтрүүлэх болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагын тусламж дэмжлэгийг авах, өмчийн аливаа хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

ж)орон нутгийн хэмжээнд хот, тосгоны усны хангамж, ариутгах татуургын системийн технологийн болон ашиглалтын түвшин, горимыг сайжруулан хэвийн найдвартай ажиллагааг нь хангаж, экологи, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэх;

з)хот, тосгодыг ерөнхий төлөвлөгөөний дагуу тохижуулах, нийтийн аж ахуйг хамгаалах, иргэдийн үйлчилгээний хэлбэр, зохион байгуулалтыг сайжруулах, гэрийн хороолол, амины орон сууцны хуурай, шингэн хог, хаягдлыг цуглуулах, зайлуулах, боловсруулах ажлыг оновчтой шийдвэрлэх;

и)орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, хамгаалалт, эзэмшил, үйлчилгээний соёлын түвшинг дээшлүүлэх, энэ талын сэтгэлгээний хоцрогдлыг арилгах талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийг хамарсан мэдээлэл, сурталчилгаа явуулах;

к)хүн амын амьжиргааны түвшинтэй уялдуулан ажил, үйлчилгээний үнэ, тарифын уян хатан зохистой бодлого барих, зохицуулалт хийж байх;

л)төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа (хамтарсан шийдвэр гаргах, аж ахуйн нэгжийн удирдлагыг өөрчлөх, томилох зэрэг) уялдуулах.

3. Улсын нийслэл, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудад төрийн захиргааны төв байгууллагын бодлогын хүрээнд хэрэгжүүлбэл зохих зарим арга хэмжээг орон нутгийн хөтөлбөрийн үндсэн чиглэлүүдэд тусгаж хэрэгжүүлэх.

Засгийн газрын 1995 оны 51 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ХҮН АМЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хүн амын ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүд бүрэн хувьчлагдаж үйл ажиллагаа нь хувийн өмч дээр тулгуурлан

явагдах болсон нөхцөлд тэдгээрийг дэмжих, бие даасан үйл ажиллагааг нь хангах, зах зээлийн тогтолцооны зарчимд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээг нь оновчтой шинэ хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай байна.

Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх чиглэл

Хүн амын ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх төрийн бодлого нь дараахь чиглэлээр тодорхойлогдоно:

1. Хот, суурин газар, хөдөөгийн хүн амын суурьшлын байдалтай уялдуулан дараахь нэр төрлийн үйлчилгээг хүн амд хүргэсэн байхаар өмчийн бүхий л хэлбэрээр зохион байгуулж ажиллуулан хүн амын хэрэгцээг бүрэн хангах:

-гэр ахуйн зүйл, гутал, хувцас хийх, засварлах үйлчилгээ;

-гэр ахуйн техник, хэрэгсэл засварлах үйлчилгээ;

-газар тариалан болон мал аж ахуйн зориулалттай тоног, хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах үйлчилгээ;

-төмөр болон модон эдлэл үйлдвэрлэх, засварлах үйлчилгээ; -хими цэвэрлэгээ, угаалгын үйлчилгээ;

-гэрэл зураг, үсчин, гоо сайхан, цаг засварын үйлчилгээ.

2. Шаардлагатай газруудад дээр дурдсан үйлчилгээг явуулын хэлбэрээр зохион байгуулах.

3. Үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хувь хүн, гэр бүл, хот айлын хэрэгцээг хангахад чиглэгдсэн өрхийн үйлдвэрлэл, аж ахуйг хөгжүүлэх, улмаар энэ хэлбэрийг жижиг үйлдвэрлэлийн хэмжээнд хүргэх.

4. Орон нутгийн түүхий эд, материал, ажиллах хүчийг ашиглан үндэсний уламжлалт аргаар түүхий эд боловсруулах ажлыг сэргээх, импортын нөлөөллийг багасгах.

5. Хөдөлмөрөөр хорших хэлбэрээр ахуйн үйлчилгээ явуулахад түлхүү анхаарах.

6. Ахуйн үйлчилгээний чанарын түвшинг дээшлүүлэх, нэр төрөл, хүрээг нэмэгдүүлэх.

7. Хүн амын ахуйн үйлчилгээг хөхүүлэн дэмжиж дараахь арга хэмжээ авна:

-үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг дэмжсэн зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

-орон нутгийн түүхий эдийн нөөцийг өндөр үр ашигтай технологиор боловсруулж ашиглаж төслүүдийг дотоодын болон

олон улсын банк, санхүүгийн байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;

-үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмж, техник, технологийг сайжруулах, шинэчлэх зорилгоор шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтлаг зохион байгуулж ажиллуулах;

-ахуйн үйлчилгээг дэмжиж ажилладаг олон нийтийн байгууллага, мэргэжлийн холбоодтой үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллах;

-үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийн удирдах ажилтан, мэргэжилтнийг сургалтад хамруулах;

-экспортын нөөц нэмэгдүүлэх, импортын хамаарлыг багасгах чиглэлээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ явуулж буй нэгжийг дэмжиж урамшуулах;

-үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдолтой шинэ мэдээ, мэдээллээр хангах ажил зохион байгуулж туслах.

8. Хүн амын ахуйн үйлчилгээг хөгжүүлэхтэй холбогдуулан дараахь зохицуулалтын арга хэмжээ авна. Үүнд:

-шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр болон улс ардын аж ахуйн салбарт онц шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход улсаас захиалга өгч нийтэд зарлан мэдээлж, шилдэг төслийг өрсөлдүүлэн шалгаруулах замаар хэрэгжүүлэх ажил зохион байгуулна;

-ахуйн үйлчилгээний чиглэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдолтой тоо баримтыг статистикийн мэдээллийн системд оруулах;

-үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаатай холбогдолтой норм, норматив, эрхийн актыг боловсруулах ажлыг шинжлэх ухааны байгууллагаар захиалан хийлгүүлэх;

-үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Засгийн газраас явуулж буй бодлогод нийцүүлэн эдийн засгийн харилцааг зохицуулж буй хууль, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авах;

-улс орны болон бүс нутгийн хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа бүхий бөгөөд эдийн засгийн бүтцэд нөлөө үзүүлэхүйц аж ахуйн нэгжийг байгуулах, түүнийг зохистой байршуулахад анхаарах.

9. Хүн амын ахуйн үйлчилгээг хөгжүүлэх, зөв зохистой явуулах үүднээс дараахь чиглэлээр хяналтыг зохион байгуулна:

-үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаанд хууль тогтоомжийг хэрхэн мөрдүүлж байгаад;

-бүтээгдэхүүний болон ажил, үйлчилгээний чанар, стандартын мөрдөлтөд;

-гадаад харилцаа, худалдааны үйл ажиллагааг зүй зохистой явуулж, мэдээ тайланг үнэн зөв гаргаж байгаад.

Засгийн газрын 1995 оны 51 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

"НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ОЙРЫН ХУГАЦААНД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Улсын хэмжээнд болон орон нутагт нийтийн аж ахуйн салбарын удирдлагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбар, гүйцэтгэх үүрэг, төв, орон нутгийн байгууллагатай ажиллах зарчмыг тодорхойлон, Засгийн газраас зөвшөөрсөн "Орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх талаар 1994-1996 онд хийх ажлын хөтөлбөр"-тэй уялдуулан хэрэгжүүлэх.

1995-1996 онд. Дэд бүтцийн хөгжлийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

2. Нийтийн аж ахуйн салбарын байгуулж, техник, технологид шинэчлэлт, өргөтгөл хийх ээлж дарааллыг санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан үе шаттайгаар боловсруулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулах.

1995 оноос Дэд бүтцийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

3. Хот, тосгодын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шаардлагатай газарт усны хангамжийн эх үүсвэрийн хайгуул хийлгэж, нөөцийг тогтоон зөв зохистой ашиглах, усны эх үүсвэрийн хувьд хүндрэлтэй суурин газрын усны хангамжийн асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг гарган сонголт хийж, тэр дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

1995-2005 онд. Эрчим хүч, геологи, уул уурхайн яам, Байгаль орчны яам, аймгуудын Засаг даргын Тамгын газар.

4. Нийтийн аж ахуйн байгууламжид гарч болзошгүй аваарь ослоос урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед хэрэглэх материал сэлбэг, тоног төхөөрөмжийн хөрөнгийн нэг удаагийн эх үүсвэрийг шийдэж зохих хэмжээний нөөц бий болгох, байнгын нөөцийг бүрдүүлэх, зарцуулах журам тогтоож мөрдүүлэх.

1995-1996 он. Худалдаа, үйлдвэрийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Сангийн яам.

5. Хот, тосгод дахь гэрийн болон амины орон сууцны хороолллыг ундны усаар хангах, бохир шингэнийг зайлуулж цэвэрлэх бага оврын байгууламж барьж нэвтрүүлэх арга хэмжээ авах.

1996 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

6. Нийтийн аж ахуйн байгууламжийн ашиглалт, эзэмшилтийг зохицуулахад чиглэгдсэн хууль эрхийн актыг гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

1995 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, Хууль зүйн яам

7. Нийтийн аж ахуйн салбарыг удирдах арга ухаанд мэргэжлийн ажилтнуудыг сургах, боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийн мэргэжил мэдлэг, ур чадварыг үнэлэх шалгуур, зэрэглэл, ангилал бий болгох, тэдэнд маркетинг, менежментийн мэдлэг эзэмшүүлэх арга хэмжээ авах.

1995 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, Үндэснийхөгжлийн газар, Шинжлэх ухаан, боловсролын яам,

8. Өөрийн орны онцлогт нийцсэн ус цэвэрлэх технологитой болох, ундны болон технологийн усны чанар, бохир усыг цэвэрлэх түвшинг дэлхийн стандартын хэмжээнд хүргэх, эрчим хүч хэмнэх, нийтийн халуун усны үйлчилгээний зардлыг хямдруулахад эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагын ажлыг чиглүүлж, үйл ажиллагааг нь дэмжих.

Дэд бүтцийн хөгжлийн яам, Шинжлэх ухаан, боловсролын яам, Үндэсний хөгжлийн газар, Байгаль орчны яам, Эрчим хүч, геологи, уул уурхайн яам, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам.

9. Хувьчлагдаад ажиллахгүй байгаа буюу үндсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, түүнчлэн ажлын чиглэлээ өөрчилсөн нийтийн аж ахуйн цэг, салбарын талаар дүгнэлт гаргаж, үйл ажиллагааных нь шинэ чиглэлийг тогтоох асуудлыг судалж шийдвэрлэх.

1995-1996 онд. Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

10. Хот, тосгодын хуурай хог, хаягдлыг ялгаж ашиглах, боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулах боломжийг судалж шийдвэрлэх.

1995 оноос Дэд бүтцийн хөгжлийн яам

11. Цэвэр усны нөөцийг зүй зохистой ашиглах, хэрэглээг оновчтой болгох, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хэрэглэгчдийг дэс дараатай хэмжүүржүүлэх ажил зохион байгуулах.

1995 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

12. Нийтийн аж ахуйн салбарт нэн тэргүүнд шаардлагатай зарим хийцийн сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх замаар импортын нөлөөллийг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

1995 оноос. Худалдаа, үйлдвэрийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

13. Орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, хамгаалалт, эзэмшилт, үйлчилгээг сайжруулах оновчтой хэлбэрийг судалж нэвтрүүлэх.

1995 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар.

14. Нийтийн аж ахуйн салбарын материллаг баазыг бэхжүүлэх, түүний хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үнэ өртөг өндөртэй зарим сэлбэг хэрэгсэл, тусгай зориулалтын автомашиныг олж нийлүүлэх санхүү, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх боломжийг судалж, шийдвэрлүүлэх.

1995 оноос. Дэд бүтцийн хөгжлийн яам, Сангийн яам, Худалдаа, үйлдвэрийн яам.

15. Хог, хаягдал тээвэрлэж, зайлуулах ажил, жорлон, бохир усны цооногийн ашиглалтын үзлэг явуулж улс, орон нутгийн түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах.

1995 онд. Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

16. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн болон хортон шавьж, мэрэгч устгах бодис, арга, технологийн түвшинг дэлхийн

стандартын хэмжээнд хүргэх механизмыг бүрдүүлж хяналт тавих, түүнийг сайжруулах.

1996 оноос. Эрүүл мэндийн яам, Худалдаа, үйлдвэрийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам.

17. Хортон шавьж, мэрэгч устгах албаны эдийн засгийн болон мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

1996 оноос. Эрүүл мэндийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

18. Эмнэлгүүдийн дезкамерын ашиглалтыг сайжруулж, нутаг дэвсгэрийн харьяаллаар үйлчлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

19. Крематори барих асуудлыг судалж, холбогдох байгууллагуудад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

Дархан-уул, Орхон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

Засгийн газрын 1995 оны 51 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

"ХҮН АМЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ОЙРЫН ХУГАЦААНД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэлийг үйлчилгээний чиглэл бүрээр гаргуулж, тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээний талаар байнгын мэдээлэл гаргадаг болох.

1995-1996 онд. Худалдаа, үйлдвэрийн яам, Статистикийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

2. Ахуйн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах нөхцөл, үйлчилгээний чанар, соёлын түвшингийн байдалд үзлэг хийж тэдгээрийг үйлчилгээний төрлөөр нь ангилал, зэрэглэлд хамруулах, үүнтэй холбогдуулан үйлчилгээний салбарын зэрэглэл тогтоох журам боловсруулж

мөрдүүлэх.

1996-1998 онд. Худалдаа, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

3. Хувьчлагдаад ажиллахгүй байгаа буюу үндсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, түүнчлэн ажлын чиглэлээ өөрчилсөн ахуйн үйлчилгээний цэг, салбарын талаар дүгнэлт гаргаж байнгын ажиллагаатай болгох арга хэмжээ авах.

1996-1997 онд. Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Худалдаа, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг, даргын Тамгын газар.

4. Ахуйн үйлчилгээний салбарын удирдлагын арга ухаанд мэргэжлийн ажилтнуудыг сургах, шинээр бэлтгэх тэдний мэргэжил, мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлэх, тэдэнд маркетинг, менежментийн мэдлэг эзэмшүүлэх.

1995-2010 онд, Худалдаа, үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар.

5. Хөдөөгийн хөдөлмөрчдийн хэрэгцээг хангах зорилгоор хими цэвэрлэгээ, угаалгын үйлчилгээ, цагаан ултай гутлын үйлдвэрлэл, ахуйн техник засварлах үйлчилгээ, оёдлын үйлдвэрлэлийг бий болгож тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэх үүднээс тодорхой төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах.

1995-2000 онд. Худалдаа, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

6. Хүн амын ахуйн үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлага, үзүүлэлтүүдийг хангах үүднээс шаардлагатай стандарт, техникийн нөхцөлүүдийг боловсруулж мөрдүүлэх.

1996-2000 онд. Улсын стандартчилал баталгаажуулалтын төв, Шинжлэх ухаан, боловсролын яам

7. Суурин газраас алслагдсан малчдад зайлшгүй шаардлагатай наад захын ахуйн үйлчилгээг газар дээр нь гүйцэтгэх буюу хүлээн авагч- олгогчоор дамжуулан төвлөрсөн байранд гүйцэтгээд хүргэж өгдөг хэлбэрийг худалдааны үйлчилгээтэй хоршуулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулах.

1996-2010 онд. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.

8. Амьжиргааны доод түвшинд байгаа бөгөөд ажил эрхлээгүй хүмүүсийг өрх гэр, хамт олноор нь хөдөлмөрөө хорших хэлбэрээр ажиллуулж хүн амд үйлчлэх ажлыг зохион байгуулах.

1996-2010 онд. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

Төр, захиргааны байгууллага болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын архивын ажлын үндсэн заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төр, захиргааны байгууллага болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Архивын үйл ажиллагаандаа энэхүү зааврыг ашиглахыг нам, олон нийт, шашны байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "БНМАУ-ын улс, олон нийт, хоршооллын байгууллагын архивын ажиллагааны зааврыг батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 444 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — П. ЖАСРАЙ
Хууль зүйн сайд — Н.ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 52 дугаар тогтоолын хавсралт

ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН АЖЛЫН ҮНДСЭН ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү зааврыг Монгол Улсын төр, захиргааны байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага (цаашид "байгууллага" гэх)-ын архивын баримтыг эмхлэн цэгцлэх, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглах, улсын архивт шилжүүлэх үйл ажиллагаанд мөрдөнө.

2. Байгууллага нь өөрийн архивыг эмхлэн байгуулж улсын архивт бүртгүүлэн архивын гэрчилгээ (1 дүгээр хавсралт) авна.

3. Байгууллага нь архивын ажил хариуцсан ажилтанг албан ёсоор томилно.

4. Өөрийн үйл ажиллагаандаа кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг, түүнчлэн шинжлэх ухаан, техникийн зэрэг тусгай төрлийн баримт зохион бүрдүүлдэг байгууллагууд нь дээрх баримтыг хадгалах зориулалт бүхий сан хөмрөг байгуулна.

5. Тусгай төрлийн болон хувийн гаралтай баримтыг эмхлэн цэгцлэх, хадгалах, ашиглах, хосгүй үнэт, үнэт баримтыг илрүүлэх, тэдгээрээс хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувь бий болгох журмыг Улсын архивын хэрэг эрхлэх газар батална.

6. Улсын архивт сан хөмрөг үүсгэгч байгууллагын зэрэглэлийг Улсын архивын хэрэг эрхлэх газар тогтооно. Байгууллагын архивт баримт хадгалах цаад хугацааг архивын сан хөмрөгийн дүрмээр тогтооно. Улсын архивт сан хөмрөг үүсгэдэггүй байгууллага нь байнга хадгалах баримтаа дээд шатны байгууллагадаа шилжүүлнэ.

ХОЁР. Байгууллагын архив (ажилтан) -ын эрх, үүрэг

7. Байгууллагын архив (ажилтан) нь дараахь үндсэн үүргийг гүйцэтгэнэ:

а)байгууллагын зохион байгуулалтын нэгжийн баримтыг эмхлэн цэгцлүүлж архивт хүлээн авах, хадгалах, ашиглуулах,

б)хувийн гаралтай баримтыг хүлээн авах, хадгалах, ашиглуулах;

в)архивт хадгалагдаж буй задгай баримтыг эмхлэн цэгцлэх;

г)баримтыг нягтлан шалгаж байнга, түр хадгалах баримтыг ялгах, байгууллагын нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

д)архивын баримтын данс, бүртгэл үйлдэх;

е)байгууллага, иргэдэд архивын лавлагаа өгөх, шаардлагатай гэж үзвэл баримтын хуулбар хувь олгох;

ж)хадгаламжийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх, тоо бүртгэлийн үндсэн баримт бичиг хөтлөх, гэмтэлтэй баримтыг сэргээн засварлах;

з)улсын архивт шилжүүлэх баримтыг дансны хамт, хосгүй үнэт, үнэт баримтыг хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувийн хамт шилжүүлэх;

и)өөрийн байгууллага болон харьяа газрын албан хэрэг хөтлөлт, архивын ажилд хяналт тавьж, мэргэжил-арга зүйн туслалцаа үзүүлнэ.

8. Байгууллагын архив (ажилтан) нь дараахь эрх эдэлнэ:

а)өөрийн байгууллагын зохион байгуулалтын нэгж болон харьяа газрын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шалгах;

б)зохион байгуулалтын нэгжээс баримтаа хугацаанд нь архивт шилжүүлэхийг шаардах;

в)архивын ажилд зайлшгүй шаардлагатай мэдээг өөрийн байгууллагын зохион байгуулалтын нэгж, харьяа газраас гаргуулж авах;

г)архивын баримтын нөхөн бүрдүүлэлт, хадгалалт, ашиглалтын явцад илэрсэн хариуцлагагүй үйл ажиллагааны талаар улсын байцаагчид мэдэгдэх;

д)архивын ажлыг сайжруулах талаар холбогдох газарт санал, дүгнэлт гаргах.

ГУРАВ. Баримт нягтлан шалгах

9. Баримт нягтлан шалгах нь баримтыг мэдээллийн ач холбогдлоор үнэлэн, тэдгээрийн хадгалах хугацааг тогтоох үйл ажиллагаа юм.

10. Баримтын ач холбогдлыг тогтоохдоо түүх, эрдэм шинжилгээний талаас нь иж бүрнээр хандах зарчмыг баримтална.

11. Баримтыг нягтлан шалгах үндсэн шалгуурт тухайн байгууллагын статус, үйл ажиллагааны онцлог, баримтад тусгагдсан мэдээллийн утга агуулга, ач холбогдол, баримт үүссэн он цаг, баримтын хүчинтэй эсэх, гадаад онцлог, физик, химийн шинж байдал зэрэг орно.

12. Баримт бичгийн ач холбогдлыг дараахь үе шатанд нягтлан шалгана:

а)албан хэрэг хөтлөлтийн явцад хэрэг бүрдүүлэх үед;

б)зохион байгуулалтын нэгжид хөтлөгдөж дууссан хэргийг байгууллагын архивт шилжүүлэх үед;

в)баримтыг эмхлэн цэгцэлж, данс бүртгэл үйлдэх үед;

г)баримтыг улсын архивт шилжүүлэх үед тус тус нягтлан шалгана.

13. Баримтыг нягтлан шалгахдаа баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт, байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон нягтлан шалгах ажлын талаар Улсын архивын хэрэг эрхлэх газраас гаргасан заавар, зөвлөмж зэрэг арга зүйн баримт бичгийг удирдлага болгоно.

14. Баримтыг нягтлан шалгах ажлыг байгууллагын даргын тушаалаар томилогдсон нягтлан шалгах комисс удирдан зохион байгуулна. Комисс нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд комиссын даргаар байгууллагын дэд (орлогч) дарга, комиссын ишүүдээр холбогдох ажилтан, нарийн бичгийн даргаар архив хариуцсан ажилтныг томилно.

15. Нягтлан шалгах комисс нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

а)байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл болон устгах бичгийн түүвэр жагсаалтыг хянан хэлэлцэх;

б)гал, усны болон бусад аюулын улмаас үрэгдсэн, сэргээн засварлах боломжгүй болсон баримтыг шалгаж, комиссын хурлаар хэлэлцэх, акт тогтоон байгууллагын даргаар батлуулж, тоо бүртгэлийн баримт бичгээс хасах;

в)хувийн гаралтай баримтыг байгууллагын архивт хүлээн авах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

г)байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төслийг хянан хэлэлцэх;

д)архиваас хосгүй үнэт, үнэт баримтыг илрүүлэх, тэдгээрийг хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувьтай болгох ажлыг зохион байгуулах;

е)харьяа газрын нягтлан шалгах комиссын ажилд хяналт тавьж, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

16. Нягтлан шалгах комисс нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж хурлын протокол хөтөлнө. Комиссын хурлаар хянан хэлэлцсэн байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл нь зохих улсын архивын дэргэдэх нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар батлагдсаны дараа хүчин төгөлдөр болно.

17. Байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэлийг 3 хувь, устгах бичгийн түүвэр жагсаалтыг 2 хувь үйлдэж хурлын протоколын хамт зохих улсын архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комисст ирүүлнэ.

18. Нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар баталсны дагуу устгах бичгийг байгууллагын нягтлан шалгах комиссын хяналтын

дор устгаж, энэ тухай актыг 2 хувь үйлдэж 1 хувийг нягтлан шалгах арга зүйн комисст ирүүлнэ.

ДӨРӨВ. Хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс, бүртгэл үйлдэх

19. Баримтыг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэхийн өмнө байгууллагын түүхчилсэн лавлах болон эмхлэн цэгцлэх ажлын бүдүүвчийг боловсруулсан байна.

20. Албан хэрэг хөтлөлтийн явцад бүрэн зөв хөтлөгдсөн байнга хадгалах хэрэгт хуудас дугаарлах, үдэж хавтаслах, дотоод товъёог (2 дугаар хавсралт) үйлдэх, баталгаа (3 дугаар хавсралт) болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас (4 дүгээр хавсралт) бичих зэрэг техник боловсруулалт хийж хадгаламжийн нэгж бүрдүүлнэ.

21. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүрэн зөв хөтлөгдөөгүй хэргийг дахин нягтлан шалгаж, байнга, түр хадгалах хугацаагаар нь ангилан төрөлжүүлнэ.

22. Баримтыг он цагаар ангилахад урт хугацааны төлөвлөгөөг биелүүлж эхэлсэн онд нь түүний биелэлтийг дууссан онд нь, хэд хэдэн он дамжиж шийдвэрлэгдсэн хэргийг шийдвэрлэгдэж дууссан онд нь тус тус ангилна.

23. Баримтыг дараахь үндсэн шинжүүдийн аль нэг буюу хэд хэдэн шинжээр ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгж бүрдүүлнэ. Үүнд:

а)баримтын нэр төрөл;

б)асуудал, сэдэв;

в)зохион байгуулалтын нэгж, үйл ажиллагааны чиглэл;

г)он цаг;

д)зохиогч;

е)байгууллага, иргэдтэй харилцсан байдал;

ж)газар нутгийн нэр зэрэг болно.

24. Боловсон хүчний хувийн хэрэг, шүүхийн хэрэг, өвчний түүх, санхүүгийн баримт зэргийг он цаг, нэр төрөл, асуудал, сэдвийн хувьд харилцан адилгүй баримтаар бүрдүүлдэг тул нарийвчлан төрөлжүүлэлгүйгээр хэргийн бүрдлээр нь хадгаламжийн нэгж бүрдүүлнэ.

25. Асуудал шийдвэрлүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг гарсан шийдвэрийн хамт, хариу авахаар явуулсан баримт бичгийг ирсэн

хариутай нь, нэг асуудал, сэдэвт холбогдох хэд хэдэн төрлийн баримт бичгийг тус тус нэгтгэж хадгаламжийн нэгж болгон бүрдүүлнэ.

26. Хадгаламжийн нэгжийн нүүр хуудсанд баримтын утга агуулгыг бүрэн илэрхийлж чадахуйц гарчиг өгнө.

27. Шаардлагатай бол хадгамжийн нэгжийн гарчигт баримт бичгийн эх, хуулбарын аль нь болох, ямар хэлээр бичигдсэн, гадаад онцлог байдлыг тодруулж бичнэ.

28. Хадгаламжийн нэгжид орсон онцгойлон үзвэл зохих баримтад нэмэлт гарчиг бичнэ.

29. Хадгаламжийн нэгжийн хуудсыг дараалан байрлуулахдаа баримтын он, сар, өдөр буюу дугаар, ач холбогдлыг нь харгалзаж үзнэ.

30. Хадгаламжийн нэгжийн хуудасны дараалал, байрлалыг шалгаж, үдээс хавчаарыг салган хуудас бүрийн баруун дээд өнцөгт дугаарлагчаар буюу бал харандаагаар хуудасны дугаар тавина.

31. Хадгаламжийн нэгж нь 250 хүртэл хуудастай байна. Хэрэв хадгаламжийн нэгж нь хэд хэдэн ботиос бүрдэж байгаа бол боть тус бүрийн хуудсыг эхнээс нь дугаарлана.

32. Хадгаламжийн нэгжийн хуудасны зүүн болон дээд талыг тэгшлэн 3-4 цоолж хатуу картоноор хавтаслаж үднэ. Удэх боломжгүй гэрэл зураг, газрын зураг, үнэмлэх зэрэг баримтыг хавтас буюу дугтуйд хадгална.

33. Байгууллагын зохион байгуулалтын нэгж, ажилтнууд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан өмнөх оныхоо баримтыг эмхлэн цэгцэлж байнга хадгалах баримтын бүртгэл (5 дугаар хавсралт), түр хадгалах баримтын бүртгэл (6 дугаар хавсралт) үйлдэн байгууллагын архивт шилжүүлнэ.

34. Архив нь хадгалах хугацаа нь дууссан устгах баримт бичгийн түүвэр жагсаалт (7 дугаар хавсралт), улсын архивт шилжүүлэх баримт бичгийн данс (8 дугаар хавсралт)-ыг тус тус үйлдэнэ.

ТАВ. Баримтын тоо бүртгэл

35. Архивын баримтын бүрэн бүтэн байдал, хадгалалт, ашиглалтын үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих зорилгоор тоо бүртгэл хөтөлнө.

36. Архивт хадгалагдаж байгаа бүх баримт (хадгаламжийн нэгж, хуудасны тоогоороо), тэдгээрийн хамгаалалтын болон ашиглалтын хуулбар хувь, баримтын данс зэрэг нь тоо бүртгэлд хамрагдана.

37. Архив нь гэрчилгээ, архивт хүлээн авсан баримтын бүртгэл (9 дүгээр хавсралт), хадгаламжийн нэгжийн бүртгэл, баримтыг хассан тухай акт (10 дугаар хавсралт), баримтын данс зэрэг тоо бүртгэлийн үндсэн баримт бичгийг заавал хөтөлнө. Хадгаламжийн нэгжийн баталгаа, дотоод товъёог нь тоо бүртгэлийн баримт бичигт хамаарагдана.

38. Хадгаламжийн нэгжийн бүртгэлийг он цагийн тодорхой үеэр зааглан хааж, дүн тоог бүртгэлийн эцэст тоо, үсгээр бичнэ. Хэрэв хадгаламжийн нэгжийн дугаар давхардсан буюу алгассан бол тэр тухай тусгана.

39. Архивын тоо бүртгэлийн баримт бичгийг чандлан хадгалж тоо бүртгэлд зөвхөн архив хариуцсан ажилтан өөрчлөлтийг тусгаж байна.

40. Архив нь жил бүр 1 дүгээр улирлын байдлаар баримтын мэдээгээ (11 дүгээр хавсралт) гаргаж улсын архивт ирүүлнэ.

41. Архивт баримтын тооллого явуулахдаа 1 дүгээр зэргийн байгууллагын баримтыг 3 жилд нэг удаа, II зэргийн байгууллагын баримтыг 5 жилд нэг удаа тоолж дүнг тооллогын хуудсанд (12 дугаар хавсралт) тэмдэглэнэ. Шаардлагатай бол тооллогын мөрөөр холбогдох арга хэмжээ авна.

42. Хосгүй үнэт, үнэт баримтын тооллогыг жил бүр явуулна. Шаардлагатай нөхцөлд гэнэтийн тооллого явуулж болно.

ЗУРГАА. Эрдэм шинжилгээний лавлах

43. Архивт хадгалагдаж буй баримтын эрэл хайлтыг хялбар болгох, тоо бүртгэлийг сайжруулах зорилгоор баримтын данс, байгууллагын түүхчилсэн лавлах зэрэг эрдэм шинжилгээний лавлах зохионо.

44. Баримтын данс нь нэг талаас тоо бүртгэлийн баримт бичиг, нөгөө талаас эрдэм шинжилгээний лавлах болно. Данс нь нүүр хуудас, байгууллагын нэрийн өөрчлөлт, дансны гарчиг, өмнөх үг, товчилсон үгийн жагсаалт, хадгаламжийн нэгжийн бүртгэл, дүн тоо, зүйлийн болон хүний нэрийн, түүнчлэн газар зүйн хийгээд он цагийн заагуур, ашигласан номын жагсаалт, баталгаа зэрэг бүрдэлтэй байна.

45. 1 дүгээр зэргийн байгууллагын баримтын дансыг бүрэн бүрдэлтэйгээр, II, III зэргийн байгууллагын баримтын дансыг зөвхөн дансны нүүр, өмнөх үг, хадгаламжийн нэгжийн бүртгэл,

баталгаа зэрэг зарим бүрдэлтэйгээр үйлдэнэ. Данс бүр бие даасан дугаартай байна.

46. Сан хөмрөг үүсгэгч байгууллага, түүний баримтын түүхээс түүхчилсэн лавлах бүрдэнэ. Түүхчилсэн лавлах нь зохиомжийн хувьд дэлгэрэнгүй байна.

47. Сан хөмрөг үүсгэгч байгууллагын түүхэнд дараахь зүйлийг тусгана. Үүнд:

а)сан хөмрөг үүсгэгчийг анх байгуулсан эрх зүйн акт, огноо;

б)тухайн байгууллагыг байгуулах үеийн улс орны хөгжлийн онцлог, нийгмийн шаардлага;

в) тухайн байгууллагын эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтэц, өөрчлөлт;

г)тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл;

д)харъяа газар, тэдгээрийн гүйцэтгэсэн үүрэг;

е)сан хөмрөг үүсгэгчийг татан буулгасан, өөр байгууллагад нэгтгэсэн болон үүргийг нь шилжүүлсэн бол түүний шалтгаан, тухайн байгууллагын үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа байгууллага, түүний албан ёсны нэр.

48. Байгууллагын архивын баримтын түүхэнд дараахь зүйлийг тусгана. Үүнд:

а)албан хэрэг хөтлөлтийн арга хэлбэр, түүнд гарсан өөрчлөлт;

б)сан хөмрөг үүсгэгчийн нэр дээр хуримтлагдсан баримтын тоо хэмжээ, он цагийн хязгаар, хадгаламжийн нэгжийн тоо;

в)баримтыг хэзээ, ямар байгууллагаас шилжүүлэн авсан, шилжүүлж өгсөн актын дугаар, огноо;

г)баримт хүлээн авах үед хамт ирүүлсэн лавлах, тоо бүртгэлийн баримт бичгүүд, ашиглах журам, шаардага хангасан байдал;

д)устгасан бичгийн тоо хэмжээ, түүний гол агуулга, зохих шатны нягтлан шалгах комиссын шийдвэр, протоколын дугаар, огноо;

е)үрэгдэж үгүй болсон, сэргээн засварлах боломжгүй баримт байвал түүний тоо хэмжээ, он цагийн хязгаарын тухай акт;

ж)бусад байгууллага, архивын сан хөмрөгт шилжүүлсэн баримтын тоо хэмжээ, түүний он цагийн хязгаар;

з)баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийсэн арга, түүний онцлог;

и)эрдэм шинжилгээний лавлах, түүний бүрэлдэхүүн, үйлдсэн арга;

к)баримтын бүрэлдэхүүн, түүний гол агуулга, хосгүй үнэт, үнэт баримт болон дутагдаж байгаа баримтын нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх талаар зохиосон ажил, үр дүн;

л)баримтад тооллого явуулдаг арга хэлбэр;

м)баримтыг нийтлүүлсэн, зохиол бүтээл, үзэсгэлэн болон радио, телевизийн нэвтрүүлэгт ашигласан байдал.

49. Үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа байгууллагын зохион байгуулалт, эрх хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүр холбогдох баримтаар түүхчилсэн лавлахыг байнга баяжуулна.

50. Түүхчилсэн лавлахыг 3 хувь үйлдэж нэг хувийг байгууллагын архивт хадгаламжийн нэгж болгон хадгалж, бусад хувийг улсын архивт шилжүүлнэ.

ДОЛОО. Баримтын хадгалалт

51. Архив нь баримтын тоо хэмжээ, ашиглалтаас шалтгаалан зориулалтын байр, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан байна.

52. Баримтын тоо хэмжээ багатай байгууллагууд архивын баримтаа сейф, шүүгээнд хадгалж болно.

53. Архивын хадгаламжийн сан нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

а)гал, усны болон бусад аюулаас бүрэн хамгаалагдсан байх;

б)цахилгааны шугам болон дулааны шугам сүлжээ найдвартай байх;

в)байрны дулаан +14+16 С хэм, чийглэг 50-55 хувь, аль болох бүдэг гэрэлтэй байх;

г)цонх, хаалгыг төмрөөр бэхэлсэн байх.

54. Архивын баримтыг хадгалалт, хамгаалалтын шаардлага хангаагүй нөхцөлд (зориулалтын бус байр, дээврийн хөндий, барилгын хонгил, агуулах болон шалан дээр зэрэг) хадгалахыг хатуу хориглоно.

55. Архивын хадгамжийн санг зориулалтын тавиураар хангаж шал, таазнаас 20-30 см зайтай байрлуулна. Тавиурын хоорондох зай 75 см, түүний тавцангийн хоорондох зай 40 см-ээс багагүй байх ба гол гарцын зай 120 см байна.

56. Тавиур, шүүгээг орох хаалганы зүүн гар талаас эхлэн дугаарлаж тэдгээрийн тавцанг дээрээс доош дугаарлана. Энэ дугаарыг ашиглан хадгаламжийн нэгжийн байрлалын заагуур (13 дугаар хавсралт) хийнэ.

57. Хадгаламжийн санд нүүрс хүчлийн хийн гал унтраагуур 1-2 ширхэг, гал унтраах бусад багаж хэрэгслийг ашиглахад ямагт бэлэн байлгана.

58. Тасалгааны зориулалтын агааржуулагч, чийглүүлэгч зэрэг техник хэрэгсэл болон механик аргуудыг хэрэглэн хадгаламжийн сангийн чийгийг шаардлагатай хэмжээнд байлгана.

59. Тоос шороо үүсэх, хортон шавьж бий болгох, баримт ялзарч хөгцрөхөөс сэргийлж ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийнэ.

НАЙМ. Баримтын ашиглалт

60. Архивын баримтыг байгууллагын даргын зөвшөөрлөөр ашиглуулна.

61. Архив нь байгуулга, иргэдэд олгосон лавлагаа, баримтын хуулбарын бүртгэл (14 дүгээр хавсралт), ашиглалтад түр олгосон баримтын бүртгэл (15 дугаар хавсралт)-ийг тус тус хөтөлнө. Архивын лавлагааг албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичиж, холбогдох зохион байгуулалтын нэгжийн дарга гарын үсэг зурна.

62. Хэрэв баримт тухайн архивт байхгүй бол энэ тухай байгууллага, иргэдэд албан ёсоор мэдэгдэнэ.

63. Архивын баримтыг ашиглуулахад дараахь зүйлийг хориглоно:

а)холбогдох зохион байгуулалтын нэгжийн дарга, архивын ажилтны зөвшөөрөлгүйгээр архивын баримт хувилах, олшруулах;

б)баримт дээр зурах, тэмдэглэл хийх, хуудас, хавтсыг нугалах, салгаж авах, урж таслах;

в)ашиглаж буй баримтыг ил задгай орхих, хамгаалалт муутай шүүгээ, саванд хадгалах, гадуур авч явж ашиглах.

64. Архивын баримтыг сонирхогч бусад архив, байгууллагуудтай хамтран үзэсгэлэн гаргах, баримтын эмхтгэл бэлтгэх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахад ашиглаж болно.

65. Баримтыг ашиглуулсны дараа хүлээн авахдаа түүний бүрэн бүтэн байдлыг нарийвчлан шалгаж архиваас түр олгосон баримтын бүртгэл (15 дугаар хавсралтын 6-8 дугаар багана)-д тэмдэглэл хийнэ.

ЕС. Баримтыг улсын архивт шилжүүлэх

66. Улсын архивт шилжүүлэх баримт нь бүрэн эмхлэн цэгцлэгдсэн, данс нь нягтлан шалгах зохих шатны комиссоор батлагдсан байна.

67. Хосгүй үнэт, үнэт баримтыг хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувийн хамт улсын архивт шилжүүлнэ.

68. Архивын ажил хариуцсан ажилтан өөрчлөгдөх үед 3-аас доошгүй хүнтэй ажил хүлээлцэх комисс томилж архивын баримтыг хүлээлцүүлнэ. Ажил хүлээлцүүлэх комисс нь архивын баримт, тэдгээрийн данс, бүртгэл, эрдэм шинжилгээний лавлах, тоо бүртгэлийн баримт бичиг, хосгүй үнэт, үнэт баримтын хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувь, архивын тоног төхөөрөмж, эд аж ахуйг тоолж шалган акт үйлдэж хүлээлцүүлнэ.

69. Актад комиссын гишүүд ба ажил хүлээлцэгчид гарын үсэг зурж байгууллагын даргаар батлуулна. Ажил хүлээлцэх үед баримт дутагдвал түүнийг эрж олох арга хэмжээ авна.

70. Байгууллагыг шинэчлэн зохион байгуулах, татан буулгах талаар дээд шатны байгууллагаас гаргах шийдвэрт архивын баримтыг хаана шилжүүлэх тухай тодорхой заасан байна. Үүнд:

а)тухайн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааг өөр байгууллагад шилжүүлэхгүйгээр татан буулгасан бол тухайн байгууллагын бүх баримтыг улсын архивт;

б)тухайн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааг хэд хэдэн байгууллагад шилжүүлэн өөрчлөн зохион байгуулах үед архивын байнга хадгалах баримтыг улсын архивт, түр хадгалах баримтыг дээд шатны байгууллагын архивт, албан хэрэгт хөтлөгдөж буй шийдвэрлэгдэж дуусаагүй хэрэг, ажиллагчдын хувийн хэргийг тухайн байгууллагын үүргийг хүлээн авсан байгууллагад;

в) тухайн байгууллагын аль нэг зохион байгуулалтын нэгж салж бие даасан байгууллага болсон тохиолдолд түүнд уг нэгжийн зөвхөн тухайн жилийн албан хэрэг, ажиллагчдын хувийн хэргийг шилжүүлнэ.

71. Архивын баримтыг улсын архивт шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн байгууллага хариуцна.

1 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ГЭРЧИЛГЭЭ

_____

/байгууллагын нэр/

Байгууллагын анх байгуулагдсан
огноо _____

Байгууллагын хаяг _____

Телефон утасны дугаар_____

Гэрчилгээ олгосон_____

_____

/албан тушаал,гарын үсэг,тайлал,тамга/

Үргэлжлэл /хавсралт N 1/

1. Архивын байр, тоног төхөөрөмж

N	Архивын байр, өрөөний тодорхойлолт	Хадгаламжийн сангийн талбай м2-аар	Тавиурын тавцангийн урт	Архивын тоног төхөөрөмж	Техник хэрэгсэл	Тэмдэглэл
	1	2	3	4	5	6

Үргэлжлэл /хавсралт N 1/

2. Архивын эрхлэгчийн бүртгэл

N	Овог, нэр	Төрсөн он	Хүйс	Боловсрол	Мэргэжил	Ажилд орсон, халагдсан огноо	Ажил хүлээлцсэн актын огноо
	1	2	3	4	5	6	7

Үргэлжлэл
/хавсралт № 1/

3. Баримтын хөдөлгөөний бүртгэл

№	Хөдөлгөөнийг тэмдэглэсэн огноо	Байгууллагын архивт байвал зохих баримт		Зохион байгуулалтын нэгж, харьяа газраас шилжүүлж авсан баримт бичиг		Улсын архивт шилжүүлсэн баримт бичиг		Бусад хэлбэрээр гадагш шилжүүлсэн баримт бичиг		Бэлэн байгаа баримт бичиг	
		хн-ээр	кг-аар	хн-ээр	кг-аар	хн-ээр	кг-аар	хн-ээр	кг-аар	хн-ээр	кг-аар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	

2 дугаар хавсралт

ДОТООД ТОВЪЁОГ

Д N ХН N

N	Баримтын огноо	Баримтын гарчиг	Хуудасны дугаар	Тэмдэглэл
	1	2	3	4

Бүгд _____ баримт бичиг бүртгэв.
/тоо, үсгээр/

Товъёог үйлдсэн _____ _____ _____
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

3 дугаар хавсралт

ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН БАТАЛГАА

Хадгаламжийн нэгж нь: _____
/тоо, үсгээр/

1. Давхар дугаартай хуудас _____
_____

2. Алгассан дугаартай хуудас _____
_____

3. Гэмтэлтэй хуудас _____
_____

4. Нэмэлт хуудас _____
_____

Баталгаа бичсэн _____ _____ _____
/албан тушаал/ /гарын үсэг/ /тайлал/

Огноо _____

Хэмжээ А4 /210х297/

4 дүгээр хавсралт

_____
/байгууллагын нэр/

_____
/Улсын архивын нэр/

С N _____

Д N _____

ХН N _____

_____
/зохион байгуулалтын
нэгжийн нэр/

ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН ГАРЧИГ

/нэмэлт гарчиг, онцлог/

Эхэлсэн огноо_____
Дууссан огноо_____
Хуудасны тоо _____
Хадгалах хугацааны жаг-
саалтын зүйлийн дугаар,
жил _____

5 дугаар хавсралт

_____-ын
/Улсын архивын нэр/
дэргэдэх НШАЗК-ын
... оны ... сарын ...өдрийн
хурлаар батлав.
Протокол N_____

Зөвшөөрөв: _____
/байгууллагын нэр, даргын
гарын үсэг, тайлал/

Огноо _____

_____
/байгууллагын нэр/

БАЙНГА ХАДГАЛАХ ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН
БҮРТГЭЛ

_____
/оны хязгаар/

Үйлдсэн огноо _____

С N _____
/оршин буй төвийн нэр/

N	Индекс	Хадгаламжийн нэгжийн гарчиг	Эхэлсэн, дууссан огноо	Хуудасны тоо	Тэмдэглэл
	1	2	3	4	5

Энэ бүртгэлд .....-ээс .....дугаар бүхий _____
/тоо, үсгээр/
хадгаламжийн нэгжийг бүртгэв. Үүнд: ХН-ийн давхар дугаар_____
алгассан дугаар _____ бий.

БҮРТГЭЛ ҮЙЛДСЭН _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

БАЙГУУЛЛАГЫН
ББНШК-ЫН ДАРГА _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

ГИШҮҮДИЙН НЭР _____
_____
/тайлал/

Хэмжээ А4 /210x297/

6 дугаар хавсралт

_____-ын
/Улсын архивын нэр/
дэргэдэх НШАЗК-ын
...оны ...сарын ... өдрийн
хурлаар батлав.
Протокол N_____

Зөвшөөрөв:
_____
/байгууллагын нэр,
даргын гарын үсэг,
тэйлал/

_____
/байгууллагын нэр/

ТҮР ХАДГАЛАХ ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН БҮРТГЭЛ

_____
/оны хязгаар/

Үйлдсэн огноо _____

Бүртгэлийн N ...

_____
/оршин буй төвийн нэр/

N	Индекс	Хадгалам-жийн нэг-жийн гар-чиг	Эхэлсэн, дууссан огноо	Хуудас-ны тоо	Архивт хадгалах хугацааны зүй-лийн дугаар,жил	Тайлбар
	1	2	3	4	5	6

Энэ бүртгэлд ___-ээс _____ дугаар бүхий _____
/тоо, үсгээр/
хадгаламжийн нэгж бүртгэв. Үүнд: ХН-ийн давхар дугаар_____
алгассан дугаар _____бий.

БҮРТГЭЛ ҮЙЛДСЭН _____
/албан тушаал, гарын үсэг,тайлал/

БАЙГУУЛЛАГЫН
ББНШК-ЫН ДАРГА _____
/албан тушаал,гарын үсэг,тайлал/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА _____
/албан тушаал,гарын үсэг,тайлал/

ГИШҮҮДИЙН НЭР,ТАЙЛАЛ _____

Хэмжээ А4 /210x297/

7 дугаар хавсралт

_____-ын
/Улсын архивын нэр/
дэргэдэх НШАЗК-ын
...оны ...сарын ...өдрийн
хурлаар батлав.
Протокол N____

Зөвшөөрөв: _____
/байгууллагын нэр,
даргын гарын үсэг,
тайлал/

Огноо_____

_____
/байгууллагын нэр/

УСТГАХ БИЧГИЙН ТҮҮВЭР ЖАГСААЛТ N...

Үйлдсэн огноо _____ Бүртгэлийн N ... _____
/оршин буй төвийн нэр/

Байгууллагын даргын ... оны ... сарын ... өдрийн ... тоот тушаалаар байгуулагдсан баримт нягтлан шалгах комиссын шийдвэрийн дагуу хадгалах хугацаа дууссан дараахь устгах бичгийг түүвэр жагсаалтад оруулав. Үүнд:

N	Устгах бичгийн он цагийн хязгаар	Нэр төрөл, агуулга	Хэргийн тоо, жин	Хадгалах хугацааны жагсаалтын зүйлийн дугаар, жил	Тайлбар
	1	2	3	4	5

Энэ жагсаалтад _____ /хэрэг,кг/ бүртгэв.
/тоо, үсгээр/

ЖАГСААЛТ ҮЙЛДСЭН _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

БАЙГУУЛЛАГЫН
ББНШК-ЫН ДАРГА _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

ГИШҮҮДИЙН НЭР, ТАЙЛАЛ _____
_____

Хэмжээ А4 /210х297/

8 дугаар хавсралт

_____
/Улсын архивын нэр/

_____
/байгууллагын нэр/

С N _____
Д N _____

_____
_____
_____
/дансны нэр/

_____
/оны хязгаар/

_____
/оршиж буй төвийн нэр/

Он _____

Хэмжээ А4 /210х297/

9 дүгээр хавсралт

_____

/байгууллагын нэр/

АРХИВТ ХҮЛЭЭН АВСАН БАРИМТЫН БҮРТГЭЛ

N _____

Эхэлсэн _____ он

Дууссан _____ он

Хэмжээ А4 /210х297/

Хүлээн авсан огноо	Баримт бичиг шилжүүлсэн зохион байгуулалтын нэгж, харьяа газар, хүнийн нэр	Ямар баримт бичгээр шилжүүлсэн	Шилжүүлсэн баримт бичгийн он цагийн хязгаар	Данс бүртгэлийн	Тоо хэмжээ				Тэмдэглэл
					Данс бүртгэлтэй хн-ийн тоо	Данс бүртгэлгүй			
						хн	кг	хуудас	
1	2	3	4	5	6	7	8	9	10

10 дугаар хавсралт

Батлав: _____
/байгууллагын нэр,даргын
гарын үсэг, тайлал/

Огноо_____

БАРИМТ ХАССАН ТУХАЙ АКТ
N____

Баримт хасах болсон шалтгаан _____
_____
_____

ДN	ХНN	Баримтын он цагийн хязгаар	Баримтын хэмжээ			Тайлбар
			хн	кг	хуудас	

Дүн

Хасаж буй баримтын жагсаалтыг хавсаргав.
Хавсралт _____ хуудастай.

АКТ ҮЙЛДСЭН _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

БАЙГУУЛЛАГЫН
ББНШК-ЫН ДАРГА _____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА_____
/албан тушаал, гарын үсэг, тайлал/

ГИШҮҮДИЙН НЭР, ТАЙЛАЛ _____
_____

Хэмжээ А4 /210х297/

11 дүгээр хавсралт

_____
/байгууллагын нэр/

АРХИВЫН БАРИМТЫН МЭДЭЭ

... оны 1 дүгээр улирлын байдлаар

N	Үзүүлэлт	тоо хэмжээ
1.	Нийт хадгаламжийн нэгжийн тоо үүнээс: байнга хадгалах түр хадгалах	
2.	Дансны тоо	
3.	Бүртгэлийн тоо	
4.	НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо	
5.	НШАЗК-ын хурлаар батлагдсан бүртгэлийн тоо	
6.	Байнга хадгалах хн-ийн он цагийн хязгаар	
7.	Улсын архивт шилжүүлэх хугацаа гүйцсэн хн-ийн тоо	
8.	Түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо	
9.	Архиваас олгосон лавлагааны тоо	
10.	Архиваас олгосон баримтын хуулбарын тоо	
11.	Хамгаалалтын ба ашиглалтын хуулбар хувийн тоо	

БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ЭРХЛЭГЧ _____

ТООЛЛОГЫН ХУУДАС

Данс N _____

Байгууллагын нэр_____

Д	Данс бүрт-гэлээр бай-вал зохих хн-ийн тоо	Дутагд-сан хн-ийн дугаар	Өөр архивт шилжүүлсэн хн-ийн дугаар	Данс бүрт-гэлтэй хн-ийн тоо	Данс бүрт-гэлгүй хн-ийн тоо	Хэнхээ кг-аар	Хэнхээ хуудсаар	Түр хугацаагаар олгосон хн-ийн дугаар	Сэргээн засварлах хн-ийн дугаар	Удэх хавтаслах хн-ийн дугаар	Бусад
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11

13 дугаар хавсралт

ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН БАЙРЛАЛЫН ЗААГУУР

Зохион байгуулалтын нэгж,
харьяа байгууллагын нэр _____

N	Данс N	Хадгаламжийн нэгжийн дугаар	Тавиурын N	Давхрын N	Тэмдэглэл
	1	2	3	4	5

14 дүгээр хавсралт

_____

/байгууллагын нэр/

АРХИВААС ОЛГОСОН ЛАВЛАГАА, БАРИМТЫН ХУУЛБАРЫН БҮРТГЭЛ

N _____

Эхэлсэн _____он

Дууссан _____он

Хэмжээ А4 /210х297/

Үргэлжлэл
/хавсралт N 14/

N	Олгосон огноо	Лавлагаа, хуулбарын товч утга	Хуудасны тоо	Лавлагаа, хуулбарын эх баримт байгаа			Хаана, хэнд шилжүүлсэн	Тэмдэглэл
				Д N	ХН N	хуудасны дугаар		
1	2		3	4	5	6	7	8

15 дугаар хавсралт

_____

/байгууллагын нэр/

АРХИВААС ТУР ОЛГОСОН БАРИМТЫН
БҮРТГЭЛ

N _____

Эхэлсэн ____он

Дууссан ____он

Хэмжээ А4 /210х297/

Үргэлжлэл
/хавсралт N 15/

Олгосон						Хүлээн авсан		
N	Ог-ноо	ДN	ХНN	Хаана, хэнд олгосон	Ашиглагчийн нэр, гарын үсэг	Ог-ноо	Хүлээн авсан хүний нэр, гарын үсэг	Тэмдэглэл
	1	2	3	4	5	6	7	8

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын 04-ны өдөр | Дугаар 125 | Улаанбаатар хот

Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Аж ахуйн нэгжийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Аж ахуйн нэгжийн тухай хуулийн зарим зүйл хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1. Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Бүх гишүүний хуралд компаний дүрмийн сангийн 50-иас дээш хувийг эзэмшигчид оролцож байвал хурлыг хүчин төгөлдөр гэж тооцох ..." гэсэн заалт нь ББХК-ний бүх гишүүдийн хурал, ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хуралд нэгэн адил хамаарна. Тэгэхдээ ББХК-ний тайлан тэнцэл батлах, ашиг хуваарилах, компаний удирдлагыг сонгох, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцэх, ББХК-ний бүх гишүүдийн хурлыг дүрмийн сангийн 50-иас доош хувийн оногдох хувийг эзэмшигчдийн, ХК-ний дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох цалин хөлс, урамшлыг тогтоох, тайлан тэнцэл хэлэлцэх, ашиг хуваарилах асуудлыг хэлэлцэх ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хурлыг дүрмийн сангийн 50-иас доош хувийн хувьцаа эзэмшигчдийн ирцтэй хийхээр дүрмэнд зааж болохгүй. Харин дээрхээс бусад асуудлыг хэлэлцэх ББХК-ний бүх гишүүдийн болон ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг, дүрмэнд өөрөөр заан тогтоож болно.

2. Дүрмийн сангийн 50-иас дээш хувь гэдгийг ББХК-ний хувьд дүрмийн сангийн 50,1-ээс дээш хувийн ноогдол хувийг, ХК-ний хувьд дүрмийн сангийн 50,1-ээс дээш хувийн хувьцаа эзэмшигч гэж ойлгоно.

3. ХК-ний дүрмийн санг нэмэгдүүлэх болон хорогдуулах

тохиолдолд дүрмийн санг нэмэгдүүлэх, хорогдуулах хувьцааны хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

4. Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "Дүрмийн сангийн аравны нэгээс доошгүй хэсгийг оруулсан гишүүн зорилго шалтгаанаа зааж бүх гишүүний хурал хуралдуулах хүсэлтээ ТУЗ-д хэдийд ч гаргах эрхтэй" гэсэн заалт ББХК-ний бүх гишүүдийн хурал, ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хуралд нэгэн адил хамаарна.

5. ББХК-ний дүрмийн сангийн 10-иас доошгүй хувийн ноогдол хувь, ХК-ний дүрмийн сангийн 10-аас доошгүй хувийн хувьцаа эзэмшигч, нэг буюу хэд хэдэн гишүүн болон хувьцаа эзэмшигч ББХК-ний бүх гишүүдийн болон ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй болон бусад шалтгаанаар зөвхөн бичгээр гаргасан байвал зохино. Энэ тохиолдолд ББХК-ний бүх гишүүдийн болон ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хүсэлт гаргасан дүрмийн сангийн 10-аас доошгүй хувийг эзэмшигчдийн нэрс, тэдний дүрмийн сангийн хувь, гарын үсгийг бүртгэлийн байгууллага баталгаажуулна. Ирц хүрээгүй болон бусад шалтгаанаар ББХК-ны бүх гишүүдийн буюу ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурал хойшлогдсон тохиолдолд хэлэлцэх асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэхийг компоний дүрмэнд зааж байвал зохино.

6. Хуулийн 26 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн "саналын дийлэнх олонх" гэдгийг хүчин төгөлдөрт тооцогдох ББХК-ний бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүдийн буюу ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн гуравны хоёроос доошгүйн санал гэж ойлгоно.

7. Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "... төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн ... 26 дугаар зүйлийн 1,2, 3,4 дэх хэсэг нэгэн адил хамаарна" гэсэн заалтын дагуу ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зөвхөн төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулах эрхтэй бөгөөд тэгэхдээ 26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох танилцуулгын хамт хурал эхлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигч бүрт мэдэгдсэн байх ёстой.

8. Хуулийн 26 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "төлөөлөн удирдах зөвлөл 7 хоногийн дотор хариу өгөөгүй буюу шийдвэр гаргах эрх

бүхий этгээд эзгүй байвал хүсэлт гаргасан гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно" гэдгийг ББХК-ний буюу ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөл 7 хоногийн дотор хариу өгөөгүй буюу Төлөөлөн удирдах зөвлөлгүй ХК-ний захирал 7-гоос доошгүй хоног эзгүй байсныг ойлгоно. Тэгэхдээ бүх гишүүдийн буюу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж байгаа гишүүд хэлэлцэх асуудлыг танилцуулгын хамт ББХК-ний гишүүн, ХК-ний хувьцаа эзэмшигч бүрт хурал эхлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө хүргэсэн байх үүрэгтэй. Энэ журмыг бүх гишүүдийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөл болон ерөнхий захирал зарлан хуралдуулж байгаа тохиолдолд нэгэн адил дагаж мөрдөнө.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ШҮҮГЧ Д.ДАНЗАНДОРЖ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан.Жаргалсайхан
Гишүүд	Т. Баасансүрэн
	Ч. Бавуу
	Б. Ганбат
	Б. Янжинлхам
Техник редактор	Т.Сарантуяа
Уншиж хянасан	Сан.Жаргалсайхан
	Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 8-р сарын 11-нд. Өрөлтөд 1995 оны 8-р сарын 11-нд. Хэвлэлтэд 1995 оны 9-р сарын 15-нд. Хэвлэлийн хуудас 12,25. Хэвлэсэн тоо 4400.

Манай хаяг: Улаанбаатар-12, Төрийн ордон

Утас: 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр